



НЭЭЛТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Дэлхийн санхүү эдийн засгийн хямралын Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө

2009 оны дөрөвдүгээр улирлын тайлан

МУИС-ийн Эдийн засгийн сургууль

Улаанбаатар, 2010



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Дэлхийн санхүү эдийн засгийн
Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

МУИС-ИЙН ЭДИЙН ЗАСГИЙН СУРГУУЛИЙН
ЭДИЙН ЗАСГИЙН ОНОЛЫН ТЭНХИМИЙН СУДЛААЧДЫН БАГ

Ч. Нарантуяа

Судалгааны багийн ахлах судлаач, МУИС, ЭЗС-ийн Эдийн засгийн онолын тэнхимийн эрхлэгч,
АНУ-ын Мэрилендийн их сургуулийн докторант

С. Даваасүрэн

Судлаач, АНУ-ын Өмнөд Нью-Хемпширийн их сургуулийн докторант

Б. Отгонтөгс

Судлаач, АНУ-ын Колумбийн их сургуулийн докторант

Б. Түвшинтөгс

Судлаач, Эдийн засгийн ухааны доктор, АНУ-ын Бостоны их сургууль, Эдийн засгийн судалгаа,
эрдэм шинжилгээний хүрээлэн

Хянан тохиолдуулсан **Б. Мөнхсоёл**
Нээлттэй Нийгэм Форумын менежер

© Нээлттэй Нийгэм Форум

Энэхүү номын зохиогчийн эрхийг ННФ эзэмших ба номыг хэсэгчлэн
болон бүтнээр нь хэвлэхийг хүсвэл доорхи хаягаар хандаж зохих
зөвшөөрөл авна уу.

Хаяг: Жамъян гүний гудамж-5/1
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар -48,

Утас: 976-11-313207

Факс: 976-11-324857

Вэб: <http://www.forum.mn>

И-мэйл: osf@forum.mn



ГАРЧИГ

1. ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ.....	4
2. ОРШИЛ	10
3. ДЭЛХИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ.....	12
4. МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	20
4.1. Дотоодын үйлдвэрлэл	20
4.2. Гадаад худалдаа.....	29
4.3. Үнэ ханш ба мөнгөний бодлогын тойм	36
5. МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН САНХҮҮ БА ТӨСӨВ, САНГИЙН БОДЛОГО	43
5.1. 2009 онд хэрэгжүүлсэн төсөв, сангийн бодлогын тойм	43
5.2. 2010 оны төсөв ба сангийн бодлого	47
5.3. Тогтворжуулалтын сан: Олон улсын туршлага ба Монгол Улс.....	54
6. ДҮГНЭЛТ: ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХЯМРАЛ МОНГОЛ УЛСАД ЯМАР СУРГАМЖ ӨГӨВ?	61
7. АШИГЛАСАН МАТЕРИАЛ	65
8. ХАВСРАЛТ.....	68

1. Тайлангийн хураангуй

Энэхүү улирлын тайланд дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал Монгол Улсын эдийн засагт хэрхэн нөлөөлж байгааг үргэлжлүүлэн судаллаа. Ингэхдээ дотоод болон гадаад эдийн засгийн нөхцөл байдалд 2009 оны дөрөвдүгээр улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад ямар өөрчлөлт орсон, энэ хугацаанд макро эдийн засгийн бодлогын ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, цаашилбал 2010 оны төсөв хэрхэн батлагдсан, төсвийн хүрээнд эрх зүйн ямар шинэчлэл хийх шаардлагатай байгаа талаар тоон болон чанарын мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийж, холбогдох бодлогын зөвлөмжийг боловсруулсан юм.

Судалгааны үр дүнд дараахь үндсэн дүгнэлтүүдийг хийлээ. Үүнд:

- ▶ 2009 онд дэлхийн ДНБ өмнөх онтой харьцуулахад 2.2 хувиар буурсан бөгөөд өндөр хөгжилтэй эдийн засгуудын бодит өсөлт хөгжиж буй орнуудын түвшнээс илүү ихээр буурсан нь энэ хямралын нэг онцлог байлаа. Хямралын хамгийн хэцүү үе бол 2008 оны дөрөвдүгээр болон 2009 оны нэгдүгээр улирлууд байв.
- ▶ 2010 оны 1 дүгээр сарын байдлаар ажилгүйчүүдийн тоо дэлхийн хэмжээнд 212 сая хүн болсон нь дэлхийн ажилгүйдлийн түвшинг 6.6 хувьд хүргэжээ. Хямралын уршгаар нэг өдөрт 1.25 ам. доллараар аж төрдөг ядуу хүмүүсийн тоо 50 саяар нэмэгдэв.
- ▶ Зарим нэг орон, тухайлбал АНУ, Их Британи, Герман, Япон, ОХУ, Мексик хямралд илүү хүнд нэрвэгдлээ. Харьцангуй бага өртсөн улсуудын тоонд Хятад, Австрали, Израиль, Энэтхэг зэрэг улс багтаж байна.
- ▶ АНУ, Европын Холбоо, Австрали, Канад, Япон, Франц, Герман, Их Британи, Хятад, Энэтхэг, ОХУ зэрэг G20 бүлэг орнууд ДНБ-ийхээ 3.5 хувьтай тэнцэх хөрөнгийг гарган эдийн засгийг дэмжсэн төсвийн тэлэлтийн бодлого хэрэгжүүллээ. Хөгжиж буй орнуудад Дэлхийн Банк 12.8 тэрбум ам доллар, ОУВС 70 тэрбум ам. доллар тус тус зээлүүлж хямралын хүнд үеийг давахад нь тусаллаа.

- ◀ 2009 оны гуравдугаар улирлаас эхлэн томоохон эдийн засгуудын ДНБ-ий бодит өсөлт нэмэгдэж, олон улсын худалдаа сэргэж эхэллээ. Хямралын хурц үе өнгөрсөн учир өнөөгийн байдлаар хямралаас бий болсон эдийн засгийн хүндрэлүүдийг хэрхэн даван туулах, үйлдвэрлэл, ажил эрхлэлтийг хэрхэн нэмэгдүүлэх вэ гэдэг асуудал чухал болж байна.
- ◀ Манай улсын ДНБ 2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр 6055.8 тэрбум төгрөг болж, өмнөх онтой харьцуулахад 2005 оны зэрэгцүүлэх үнээр 1.6 хувиар буурсан. Энэ нь эдийн засаг бага зэрэг өснө гэж олон улсын санхүүгийн байгууллагууд болон Сангийн яамнаас дэвшүүлж байсан таамаглалуудаас доогуур байна. ДНБ ийнхүү буурахад барилгын салбарын нэмэгдсэн өртөг 48.8 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбарынх 26.6 хувь, санхүүгийн гүйлгээний үйл ажиллагаа 20.4 хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний татварын нийт хэмжээ 16.6 хувиар тус тус буурсан нь нөлөөлжээ.
- ◀ Манай улсын эдийн засгийн томоохон салбарын нэг болох хөдөө аж ахуйн салбар бага зэрэг өсөлттэй гарсан байна. 2009 онд нийт 44 сая толгой мал тоологдсон нь малын тоо өмнөх оноос 1.7 хувиар өссөн үзүүлэлт юм. Мөн Атрын 3 дугаар аянг амжилттай хэрэгжүүлсний үр дүнд хураасан үр тариа өмнөх онтой харьцуулахад 84 хувь, төмс 12.2 хувиар өссөн зэрэг нааштай хандлага бий болсон хэдий ч өвс бэлтгэлт 13.3 хувь, гар тэжээл 32.8 хувиар буурсан зэрэг нь цаг агаар муудаж, өвөлжилт ихээхэн хүндэрсэн энэ үед мал аж ахуйн салбарт ихээхэн таагүй байдал үүсгээд байна.
- ◀ Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2009 онд өмнөх оноос 3.3 хувиар буурсан ба ийнхүү буурахад боловсруулах аж үйлдвэрийн салбар 14.2 хувь, металлын хүдэр олборлолтын дэд салбар 6.2 хувиар унасан нь сөргөөр нөлөөлөв. Тоон мэдээнээс дотоодын үйлдвэрлэлийн салбарт шинэчлэл, өөрчлөлт хийх шаардлагатай нь харагдлаа. Энэ нь санхүү, эдийн засгийн хямралын нөлөөгөөр манай улсад өсөн нэмэгдээд байгаа ажилгүйдэл, ядуурлын түвшинг бууруулахын тулд ажил эрхлэлтийг өсгөх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, улмаар бүтээмжийн өсөлтийг хангах, үйлдвэрлэлийн төрөлжилтийг бий болгоход ихээхэн тустай алхам болно гэж үзлээ.
- ◀ Оюу толгойн зэс, алтны орд, Таван толгойн нүүрсний орд зэрэг уул уурхайн салбарын томоохон төслүүд амжилттай хэрэгжихээс манай улсын ирээдүйн төлөв хандлага, эдийн засгийн хөгжил хамаарах болоод байна. Тиймээс, төрийн зүгээс хувийн сектор, хувь хүмүүс, пүүс компаниудад бизнесийн үйл ажиллагаа эрхлэн явуулах эерэг орчныг нь бүрдүүлэхэд бодлогоор дэмжлэг үзүүлэх нэн чухал байна. Юун түрүүнд хямралын эсрэг, улмаар эдийн засгийн дунд болон урт хугацаанд эерэг нөлөө үзүүлэх хамгийн чухал арга хэмжээ бол эрэлт болон нийлүүлэлтийг хөшүүрэгдэх шууд бодлого гэхээс илүү бизнес эрхлэхэд таатай институцийн орчинг бүрдүүлэх явдал чухал байгааг онцолж байна.
- ◀ 2009 оны экспортын нийт хэмжээг өмнөх онтой харьцуулахад 25 хувиар, импорт 34 хувиар буурсан байна. Хямрал нөлөөлсөн гол механизм бол 2008 оны дөрөвдүгээр улирал болон 2009 оны эхний улиралд зэсийн

дэлхийн эрэлт буурч, үнэ нь эрс унасан явдал юм. 2009 оны дөрөвдүгээр улиралд өмнөх оны тухайн саруудтай харьцуулахад экспортын хэмжээ нэмэгдсэн нь алт, зэсийн баяжмал, мах, арьс ширний экспорт өссөнтэй холбоотой. Үйлчилгээний экспортын хувьд хямралын нөлөө төмөр зам болон агаарын тээвэрлэлтийн салбарт илүү хүнд туслаа.

- ◀ 2009 оны дөрөвдүгээр улиралд өмнөх оны тухайн саруудтай харьцуулахад импортын хэмжээ унасан хэвээр байна. Гол шалтгаан нь нэгдүгээрт, дотоодын үйлдвэрлэлийн, ялангуяа импортын бараа материал илүү их ашигладаг барилгын салбарын уналт, хоёрдугаарт, төгрөгийн ханш суларсантай холбоотой гэж үзэж байна.
- ◀ Импортын хэмжээний уналт нь экспортынхоос илүү их байгаа учир гадаад худалдааны алдагдал дөрөвдүгээр улиралд багассан байна. Уг алдагдлын хэмжээ 2008 онд ДНБ-ий 13.1 хувьтай тэнцүү их байсан бол 2009 онд 6.9 хувьтай тэнцэх хэмжээнд очсон байна. Хямралын нэг эерэг нөлөө бол гадаад худалдааны алдагдал ийнхүү багасч буй явдал юм.
- ◀ 2009 оны дөрөвдүгээр улиралд экспортын болон импортын хэмжээ аажмаар нэмэгдэн эхний зургаан сарын хугацаанд байсан түвшнээс давж байгаа нь улирлын шинж чанартай өөрчлөлтөөс гадна эдийн засаг нийтдээ тогтворжиж эхэлсний нөлөө гэж үзэж байна.
- ◀ Хямрал эхлэнгүүт буураад байсан гадаадаас шилжүүлдэг хувийн мөнгөн гуйвуулгын хэмжээ 2009 оны 7 дугаар сараас эхлэн нэмэгдэж эхэлсэн байна. Гадаад худалдааны алдагдал багасч буй болон гадаадаас шилжүүлэх хувийн гуйвуулга нэмэгдэж байгаа нь эдийн засаг дахь гадаад валютын нөөц нэмэгдэхэд цаашилбал төгрөгийн ханш тогтворжиход эерэг нөлөөтэй. 2009 онд өмнөх онтой гадаад худалдаанаас авах татварын орлого нийтдээ 43 тэрбум төгрөгөөр буурсан байна.
- ◀ 2009 онд инфляцийн түвшин 4.2 хувь байсан нь мөнгөний бодлого үндсэндээ гол зорилгоо биелүүлсэн харагдаж байна. Тайлант оны турш жилээр тооцсон инфляци дунджаар 7 хувьтай байжээ. Үнийн өсөлт ийнхүү тогтворжиж эхэлсэн нь макро эдийн засгийн тогтворжилтийн эхлэлийг тавьсан ч банкны салбар нэлээд тогтворгүй орчинд үйл ажиллагаагаа явуулж байна.
- ◀ Тайлант оны хоёрдугаар хагаст мөнгөний нийлүүлэлт өсч оны эцсийн байдлаар 26.9 хувиар өсөөд байна. Банкуудаас олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2009 оны эцсийн байдлаар 2.5 их наяд төгрөг байгаа нь өмнөх оны түвшиндээ байна. Энэ нь 2009 онд банкны системээс шинээр зээл гараагүйг харуулж байна.
- ◀ Банкууд дахь хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн үлдэгдэл огцом өсч 583 тэрбум төгрөг буюу нийт зээлийн багцад 22 хувь эзлэх болсон нь банкны системийн хэвийн үйл ажиллагаа доголдож байгааг илтгэж байна. Түүнчлэн 2009 оны эцэст зээлийн эрсдлийн сан 327 тэрбум төгрөгт хүрсэн нь банкууд ийм хэмжээний алдагдал үндсэндээ үүрээд байгааг илэрхийлж байгаа юм.

- ◀ Дампуурсан, хаагдсан банкуудын алдагдлыг байнга төрөөс хариуцаж ирсэн нь ёс суртахууны эрсдлийг улам дэвэргэж байна гэдгийг бид дахин сануулж байна.
- ◀ Оны эцсийн байлаар банкуудад 270 орчим тэрбум төгрөгийн илүүдэл нөөц байна. Үүн дээр төв банкны үнэт цаасны үлдэгдэл болох 392 тэрбум төгрөгийг нэмж тооцвол нийтдээ 600 гаруй тэрбум төгрөгтэй тэнцэх хөрөнгийн эх үүсвэр банкуудад байгаа хэдий ч зээл олгохгүй байна. 600 тэрбум төгрөг гэдэг нь одоогийн банкуудаас олгоод байгаа цэвэр зээлийн (чанаргүй зээлийг хасч тооцсон зээл) үлдэгдэл болох 1.7 их наяд төгрөгийн 35.3 хувьтай тэнцэж байгаа нь маш өндөр үзүүлэлт юм.
- ◀ Монголбанк гадаад валютын нөөцөө өсгөх бодлого идэвхийлэн баримталсан нь мөнгөний нийлүүлэлтийг дөрөвдүгээр улиралд хүчтэй өсгөсөн. Гадаад валютын нөөцийн хуримтлалыг бий болгох нь эдийн засгийн онцгой нөхцөл үүссэн үед улс орныг импортоор тасралтгүй хангаж байх чухал үүрэг гүйцэтгэдэг хэдий ч валютын бодлого нь мөнгөний нийлүүлэлтийн бодлогоосоо байнга урьтаж байгаа нь санаа зовоож байна. Бидний үзэж байгаагаар үнийн өсөлтийг нам түвшинд барих нь Монголбанкны цорын ганц зорилго гэж олон нийтэд зарлах нь зүйтэй. Учир нь олон нийтэд энэ байгууллагын үндсэн зорилгын талаар нэгдмэл ойлголт бүрэлдээгүй хэвээр байна.
- ◀ Монголбанк хараат бус үйл ажиллагаа явуулж чадаж байгаа эсэх нь анхаарал татаж байна. Ялангуяа, томоохон эрдэс баялгийн ордууд ашиглалтад орохоор хүлээгдэж байгаа энэ үед мөнгөний бодлого хараат бус байх нь бүр ч чухал. Улс төрийн хүчнүүд зориг, зүрх, тэвчээр гаргаж Монголбанкны үйл ажиллагааны хараат бус байдлыг хангаж өгөх нь зүйтэй. Төв банкны бодлогод тодорхой улс төрийн хүчин, бүлэглэл нөлөөлөх нь өрсөлдөөнийг боомилох, улс төрийн ашиг сонирхол дагасан бүлэглэлүүд хүчирхэгжих, рент хайх үйл ажиллагаа газар авах, шинэ үйлдвэрлэл, үйлчилгээг нухчин дарах сөрөг үр дагавартай. Мөнгөний бодлогыг хараат бус болгож, үр нөлөөг сайжруулах нэг арга бол мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг жилээр гаргахаас гадна дунд болоод урт хугацаанд мөн боловсруулж өгөх явдал юм.
- ◀ 2009 оны хувьд төсөв, сангийн бодлогын гол зорилго нь Засгийн газрын зарлагыг өсгөх замаар нийт эрэлтийг өсгөж, эдийн засгийн уналтаас сэргийлэхэд оршиж байлаа. Санхүү, эдийн засгийн хямралтай холбоотойгоор Засгийн газрын орлого оны эхний хагаст нэлээд доголдож ирсэн нь сангийн бодлогоор дамжуулан эдийн засгийг тогтворжуулах бодлого баримтлах боломжгүй болгосон. Улс орнууд төсвийн тэлэлт хийх замаар хямралтай тэмцэж байсан бол манай Засгийн газарт тэлэлт хийх орон зай байхгүй байжээ.
- ◀ Засгийн газрын орлого оны эцэст 2 их наяд төгрөг байсан нь өмнөх оны эцэстэй харьцуулахад 163 тэрбум төгрөгөөр буюу 7 хувиар буурсан нь хямралын жил гэхэд харьцангуй бага бууралт юм. 2009 онд төсвийн алдагдал 328.6 тэрбум төгрөгт хүрсэн нь төлөвлөгдсөн хэмжээ болох 364 тэрбум төгрөгөөс бага байна.

- ◀ 2010 оны хувьд төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 2.43 их наяд төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн нь 2.79 их наяд төгрөг, төсвийн алдагдал нь 358.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 5 хувьтай тэнцүү байхаар заасан байна. Энэ нь Засгийн газраас оруулсан төсвийн төсөлтэй харьцуулахад орлого, зарлагын хувьд нэлээд өссөн үзүүлэлт юм.
- ◀ Төсөв ийнхүү өсч батлагдсан нь өмнөх жилүүдэд илэрсэн ерөнхий хандлагыг улам баталгаажуулж байна. Энэ нь УИХ орлогыг зэсийн үнийг шинэчлэн тогтоох замаар өсгөж, энэ хэмжээгээр зарлагаа автоматаар ихэсгэдэг зуршил дахин давтагдлаа. Төсвийн тооноос харахад алдагдал боломжийн түвшинд, төсвийн тэлэлт ерөнхийдөө үргэлжлэх нь тодорхой байна. Энэ нь хямрал бүрэн дуусаагүй, эдийн засаг эмзэг байгаа нөхцөлд эерэг нөлөөтэй байх болно.
- ◀ Манай улсын төсөв, сангийн бодлогод тогтолцооны шинжтэй томоохон сул тал байгааг энэ удаагийн хямрал тод томруунаар харуулсан. Тухайлбал, төсөв, сангийн бодлогыг эдийн засгийн мөчлөг сөрсөн бодлого болгохоос нааш эдийн засгийн хямралтай тэмцэх орон зай Засгийн газарт үүсэхгүй гэдгийг хямрал харууллаа.
- ◀ Төсөв, сангийн бодлогыг эдийн засгийн шинэ мөчлөг эхлэхээс өмнө зөв гольдролд нь оруулах нь хамгаас чухал байна. Үүнтэй холбоотой Засгийн газраас бодлогыг эрс шинэчлэх санаачилга гаргаад байгаагийн нэг нь “Төсвийн тогтвортой байдлын тухай” хуулийн төсөл юм. Улстөрчдийн хувьд төсөвтэй холбоотой өөрсдийн эрх мэдлийг сайн дурын үндсэн дээр хязгаарлах шаардлага зайлшгүй тулгарч байна. Энэ нь улстөрчдийн хувьд нэгэн чухал сорилт болно.
- ◀ Бодлого боловсруулагчид төрийн эдийн засагт гүйцэтгэх үүргийг чухалчилж буй нь ажиглагдаж байна. Бидний байгуулахаар зорьж буй эдийн засгийн тогтолцоо нь хувь хүмүүс, пүүс компаниудын шинэлэг санаа, эрэлхийлэлд тулгуурлаж тогтвортой өсөлтийг бий болгодог тогтолцоо юм. Харамсалтай нь өнөө зонхилж буй хандлага нь нэмэгдсэн өртөг гэхээсээ илүү ашигт малтмалын үл сэргээгдэх, тогтворгүй орлогыг хүмүүст жигд хуваарилах гэж оролдсон явцуу байдалтай байна. Энэ нь эдийн засгийн тогтворгүй орчныг бий болгож байна.
- ◀ Тогтвортой хөгжлийн санг зөв зүйтэй байгуулж, хэрэгжүүлж чадвал эдийн засгийг тогтворжуулах, урт хугацааны тогтвортой өсөлтийг бий болгоход чухал түлхэц болно. Тогтвортой хөгжлийн санг бий болгох гол зорилго нь олборлох салбараас орох гадаад валютын урсгалд зохицуулалт хийхэд оршино. Ямарваа нэг орны эдийн засагт ашигт малтмалын орлого ихээр орж ирэх нь тухайн оронд нэрлэсэн болоод бодит үнийн өсөлтийг бий болгож улмаар эдийн засгийн тогтворгүйжилтийг авчирдаг.
- ◀ Бодлого боловсруулагчид “Хүний хөгжил сан” (ХХС)-г шинээр байгуулахдаа Монгол Улсыг хөгжүүлэх санг (МУХС) ажиллуулахад гаргасан алдаанаасаа сургамж аваагүйгээр үл барам бүр ч муутгасан дүр зураг харагдаж байна. Засгийн газраас ХХС-ийн хөрөнгийг хэрхэн байршуулах тал дээр жишиг гаргаж өгнө гэсэн нь ойлгомжгүй байна.

Тухайлбал, үүнийг зааг хязгаар гэж ойлгох уу, аль эсвэл тодорхой хувьд барих ёстой хэм хэмжээ юу гэдэг нь тодорхойгүй байна.

- ◀ Тус санд хуримтлагдах хөрөнгийг ямарваа нэг зорилтот бүлэг рүү чиглүүлэх биш харин ч нийт ард иргэдэд жигд хуваарилахаар зохион байгуулсан нь хөрөнгийг өмнөхөөсөө илүү үрэлгэн байдалтайгаар зарцуулахаар байна. 2010 онд ХХС сангаас иргэн болгонд 70,000 төгрөг олгох шийдвэр Засгийн газраас гаргасан. Иргэдэд хавтгайруулан олгож буй энэхүү халамжийг татвар төлөгчдийн мөнгө болоод Оюу толгой төслийг барьцаалж авсан зээлээр санхүүжүүлж байгаа нь хэр зөв шийдэл вэ гэж асуухад хүргэж байна.
- ◀ Энэхүү санд төвлөрөх хөрөнгө нь одоо үе гэхээсээ илүү ирээдүй, хойч үеийн амьжиргааны баталгаа болж өгөх учиртай. Гэтэл энэ хөрөнгийн зарцуулалтыг дөрвөн жилээр сонгогддог УИХ, Засгийн газар ямар нэг хэмжээ, хязгааргүйгээр зарцуулах эрхтэй байгаа нь эрсдлийг дагуулж байна. Тэгвэл УИХ-д тавих хяналт, хязгаар, хэм хэмжээг хэн тогтоож өгөх вэ? Дүгнэж хэлэхэд ХХС маш их эрсдлийг дагуулсан шийдвэр болсон. Энэхүү сангийн зарцуулалтад хойч үеэ бодсон, алсаа харсан хязгаарлалтуудыг тавьж өгөх шаардлагатай байна.
- ◀ Дэлхийн хямралаас бидний авах хамгийн том сургамж бол эдийн засгийн тэсвэрлэх чадварыг бэхжүүлэх явдал юм. Монгол Улсын эдийн засаг цөөн тооны түүхий эд, тэдгээрийн гадаад зах зээл дэх үнээс улам бүр хамааралтай болж байна. Ийм нөхцөлд энэхүү хамаарлыг сааруулах үндсэн арга бол эдийн засгийн суурь харьцаануудыг сайжруулах, бодлогыг зөв гольдролд оруулах замаар ирээдүйд ирэх гадаад эдийн засгийн шокуудыг даван туулах, сөрөх, шингээх, уян хатан зохицох чадварыг бий болгох явдал гэж үзлээ.



2. Оршил

Дэлхийн эдийн засаг сэргэж эхэлсэн шинж тэмдгүүд өнгөрсөн оны сүүлийн улиралд баталгаажиг байна. Манай улсын хувьд дөрөвдүгээр улиралд ДНБ энэ оны хувьд анх удаа өсөлттэй гарсан нь уналт саарснаар үл барам эдийн засаг сэргэж эхэлж буйн шинж тэмдэг гэж үзэж байна. Гэсэн хэдий ч ерөнхий дүнгээрээ эдийн засаг уналттай байгаа нь сүүлийн улирлын сэргэлт өмнөх улирлуудын уналтыг нөхөж чадаагүйтэй холбоотой бөгөөд эерэг хандлага дөнгөж эхэлж эдийн засаг эмзэг хэвээр байгааг гэрчилж байна.

Энэ удаагийн тайландаа бид манай орны эдийн засагт дөрөвдүгээр улиралд ямар өөрчлөлтүүд гарсан, бодлогын ямар арга хэмжээ авагдсан, энэ нь ямар үр дүнтэй байсан талаар дэлгэрэнгүй авч үзлээ. Дотоодын үйлдвэрлэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад өссөн нь эдийн засаг мөчлөгийн шинэ үе шатандаа орж буйн илрэл юм. Гол салбарууд уналттай хэвээр байгаа хэдий ч зэсийн үнэ өссөнөөс уул уурхайн салбарын уналт саарч, улмаар өсөлт гарсан нь нийт эдийн засгийн уналт тогтворжиж эхлэхэд чухал нөлөө үзүүлээ. Энэ жилийн хувьд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, тэр дундаа газар тариалангийн бүтээгдэхүүн нэлээд өсөлттэй байгаа нь байгалийн таатай нөхцөл, энэ салбарыг дэмжсэн Засгийн газрын бодлоготой холбоотой юм. Энэ улиралд гадаад худалдаа өмнөх улиралтай харьцуулахад үргэлжлэн өссөн хэдий ч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад буурсаар байна. Ашигт малтмал, түүн дотроо алт болон бохир ноолуур зэрэг зарим нэг бүтээгдэхүүний эрэлт өндөр байна. Дүнгээрээ экспорт 25, импорт 34 хувийн уналттай байснаас гадаад худалдааны тэнцэл сайжирсан нэг давуу тал ажиглагдаж байна. Дотоодын үйлдвэрлэл болон гадаад худалдааны талаарх тоон мэдээлэл болон холбогдох дүн шинжилгээг 4 дүгээр бүлгээс харна уу.

Мөнгөний бодлогод гарсан өөрчлөлтүүдийг мөн энэ бүлэгт авч үзэв. Мөнгөний хатуу бодлого оны сүүлээр нэлээд суларсан нь зээлийг нэмэгдүүлж чадаагүй бөгөөд үндсэндээ Монголбанк валютын нөөцөө зузаатгасантай холбоотой гэж үзэж байна. Үүнтэй холбоотойгоор бид дүн шинжилгээ хийж, өөрийн бодлыг илэрхийлэв. Ингэхдээ бид төв банкны бие даасан байдал хэр чухал болох талаар хэлэлцлээ. Сүүлийн сард Монголбанкинд өрнөсөн үйл явдал энэхүү байгууллагын улс төрийн бие даасан байдалд эргэлзэх бодлыг улам баталгаажуулав. Төв банкны хувьд бодлогын бие даасан байдал нь хамгаас чухал бөгөөд энэ нь төрийн оролцоо, бизнесийн идэвх санаачилга,

улмаар манай улсын эдийн засгийн бүтэц, чадавхид ч нөлөөлж болзошгүй талаар 4 дүгээр бүлэгт авч үзэв.

Тайлангийн сүүлийн бүлэгт төрийн санхүү, төсөв сангийн бодлогыг авч үзэв. Ингэхдээ 2009 он хэрэгжүүлсэн бодлого, 2010 оны төсөвт шинжилгээ хийж дүгнэлт хийв. Сангийн бодлогыг мөчлөг сөрсөн шинж чанартай болгох нь юунаас чухал байгаа талаар дэлгэрэнгүй хэлэлцлээ. Ингэхийн тулд тогтворжуулалтын санг байгуулж, эрдэс баялгийн орлогоос орж ирэх хөрөнгийн зохистой менежмент хийх, улмаар эдийн засгийг тогтворжуулах, баялгийн “хараал”-аас зайлсхийх талаар энэ бүлэгт дэлгэрэнгүй авч үзлээ.

3. Дэлхийн санхүү, эдийн засгийн байдалд гарсан өөрчлөлт

АНУ-д 2007-2008 онуудад орон сууцны, хувийн байшингийн зээлийн эргэн төлөлт муудаж, тус улсын банкууд 100 сая орчим долларын алдагдалтай болж ирсэн нь 2009 онд АНУ-д төдийгүй дэлхий даяар санхүүгийн хямралыг эхлүүлнэ гэж хэн ч бодоогүй билээ. Гэтэл 2008 оны 9 дүгээр сарын 12-нд “Лиман ах дүүс” (Lehman brothers) дампуурлаа зарласнаас хойш хэдхэн хоногийн дотор дэлхий нийтээрээ санхүүгийн гүнзгий хямрал аль хэдийнэ эхэлснийг ойлгосон юм. 2008 оны дөрөвдүгээр улирал гэхэд л санхүүгийн зах зээл дээр анх эхэлсэн уг хямрал дэлхийн бодит эдийн засаг, үйлдвэрлэлийн хэмжээнд шууд нөлөөлж, дэлхийн нийт үйлдвэрлэлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22 хувиар, 2009 оны нэгдүгээр улиралд 28 хувиар тус тус буурсан нь 1929 оны Их хямралаас хойш үзэгдээгүй явдал байлаа. Хямралын далайцын хувьд 2009 онд дэлхийн нийлбэр ДНБ-ий хэмжээ өмнөх онтой харьцуулахад 2.2 хувиар, хөгжиж буй орнууд руу шилжсэн хувийн цэвэр капиталын хэмжээ 70 хувиар, гол металлын дэлхийн үнэ 2008 оны 6 дугаар сарын түвшнээс даруй 20 хувиар, газрын тосны үнэ 44 хувиар, хүнсний барааны үнэ 24 хувиар буурч, дэлхийн худалдааны нийт ам. доллараар тооцсон мөнгөн дүн 31 хувиар буурсан байна.

Хямрал яагаад эхлэв?

2003-2007 онуудад ихэнх орнуудад эдийн засгийн өсөлт хурдацтай явагдаж, ажил эрхлэлт нэмэгдэж, зээлийн хүү буурч, дэлхий даяар хаана ашигтай хөрөнгө оруулалт байна тийшээ хөрөнгийн их хэмжээний урсгал чиглэж байлаа. Эрэлт өндөр байсан учир ашигтай хөрөнгө оруулалтын, хөрөнгийн зах зээл дээрх үнэт цаасны үнэ аажмаар өсөн нэмэгдэж байв. Энэ хугацаанд санхүүгийн ярвигтай систем дотор хөрөнгийн үнэлгээ, гол нь АНУ дахь хувийн орон сууцны үнэ цэнэ бодит байдлаасаа илүү бичигдэж явсан нь санхүүгийн хоёрдогч зах зээл дээрх үнэлгээг бодит бус болгож, энэ буруу үнэлгээн дээр үндэслэгдсэн эрсдлийн тооцоо мөн буруу байснаас санхүүгийн хямрал бий болсон гэж эдийн засагчид үзэж байна.

2000 оноос хойш АНУ-д бага орлоготой иргэдийг хувийн байшинтай болоход нь туслах хууль эрх зүйн болон урт хугацааны зээл олгон дэмжих бодлогыг

өргөн хэрэгжүүлсэн. 2007 оны сүүлээр болон 2008 он гарсаар өрхүүд зээлээр авсан байрныхаа сарын төлбөрийг хийж чадахаа больж банкинд буцаан өгөхөд хүрсэн нь эдгээр байрны үнийг мөн давхар унагахад хүргэсэн. 2009 оны 4 дүгээр сар гэхэд АНУ-д хувийн орон сууцны мөнгөн үнэлгээ 1/3-ээр унасан нь орон сууц эзэмшигчдийн хөрөнгийг даруй 6 триллион ам. доллараар багасгасан байна. АНУ-д тус бүр нь дунджаар 300 мянган ам. долларын өртөгтэй 7 сая байшингийн төлбөр хийгдэж чадахаа больсон тул нийт банк, цаашилбал санхүүгийн системд 2.1 триллион ам. долларын алдагдлыг бий болгосон. Дээр нь нэмээд хүмүүсийн эргэн төлж чадахаа больсон зээлийн картны өр, дээд сургуульд сурахдаа хэрэглэсэн оюутны сургалтын төлбөрийн зээл, машины зээлийн төлбөр нийлээд 10-12 триллион ам. доллар болсон нь уг эдийн засгийн банкны салбарын хувьд дийлшгүй их алдагдал байлаа.¹

2000 оноос хойш эрчимтэй явагдаж эхэлсэн глобальчлал дэлхийн улс орны эдийн засгуудын хоорондох бараа, үйлчилгээ, хөрөнгө, ажиллах хүч, технологи, бизнесийн шинэ санааг улам хурдацтай нэгтгэн нийлүүлж байсан бол энэ хямралыг мөн адил эдгээр сувгаар дамжуулан хурдацтай тараалаа.

Эдийн засгийн өсөлт

Олон Улсын Валютын Сан болон Дэлхийн Банкнаас 2009 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн талаарх таамаглалуудаа он гарсаар хэд хэдэн удаа өөрчилсөн бөгөөд бодит байдал дээр 2009 онд дэлхийн эдийн засгийн өсөлт хэр зэрэг уналтад орсон, 2010 онд ямар байх талаарх Дэлхийн Банкны гаргасан тайланг хүснэгт 3.1-д үзүүлэв. Дэлхийн улсуудын нийлбэр ДНБ-ий хэмжээ өмнөх онтой харьцуулахад 2.2 хувиар буурсан байна. Өндөр хөгжилтэй орнуудын ДНБ-ий бодит өсөлт хөгжиж буй орнуудын түвшнээс илүү ихээр буурсан байгаа нь доорх хүснэгтээс харагдаж байна.

Хүснэгт 3.1. Дэлхийн эдийн засаг болон зарим улсуудын ДНБ-ий бодит өсөлт (хувиар)

	2007	2008	2009	2010
Дэлхийн эдийн засаг	3.9	1.7	-2.2	2.7
Хөгжилтэй орнууд	2.6	0.4	-3.3	1.8
Хөгжиж буй орнууд ²	6.2	4.3	-2.2	3.3
Европын Холбоо	2.5	0.3	-3.3	1.8
АНУ	2.1	0.4	-2.5	2.5
Япон	2.3	-1.2	-5.4	1.3
Зүүн Өмнөд Азийн орнууд	11.4	8	6.8	8.1
Хятад	13	9	8.4	9
ОХУ	8.1	5.6	-8.7	3.2
Энэтхэг	9.1	0.4	2.5	2.5

Эх сурвалж: Дэлхийн Банк «Global Economic Outlook», 2010 оны 1-р сар, хуудас 17.

1 World Bank Institute. Development Outreach. 2009 оны 12 дугаар сар. Хуудас 7.

2 Хятад, Энэтхэгийг оруулахгүйгээр тооцсон өсөлтийн түвшин юм.

Хүснэгт 3.1-ээс харахад Япон, Европын Холбооны орнууд, АНУ болон ОХУ-ын ДНБ-ий бодит өсөлт хамгийн ихээр буурлаа. Энэ уналтын хамгийн хүчтэй үе бол 2008 оны дөрөвдүгээр болон 2009 оны нэгдүгээр улирлууд байлаа. 2009 оны гуравдугаар улирлаас эхлээд гол эдийн засгуудын ДНБ-ий бодит өсөлт нэмэгдэж, олон улсын худалдаа эргэн сэргэж ирсэн талаар Дэлхийн Банк, бүсийн хөгжлийн банкууд, Олон Улсын Валютын Сан, Олон улсын худалдааны байгууллага зэрэг олон улсын гол байгууллагууд бүгд санал нэгтэй байна.

Ямар бодлого явуулав?

2009 оны 9 дүгээр сард Олон Улсын Валютын Сангаас (ОУВС) дэлхийн өндөр хөгжилтэй болон хөгжиж буй G20 бүлэг орнууд төсвийн тэлэлтийн бодлогыг хэрэгжүүлбэл дэлхийн ДНБ-ийг энэ онд дор хаяж 1 пунктээр өсгөж чадна гэсэн тооцоог гаргасан байна.³ Тиймээс хямрал эхлэнгүүт ОУВС-аас эдийн засгийг дэмжсэн төсвийн тэлэлтийн бодлого хэрэгжүүлэхийг зөвлөсөн бөгөөд АНУ, Европын Холбоо, Австрали, Канад, Япон, Франц, Герман, Их Британи, Хятад, Энэтхэг, ОХУ зэрэг G20 бүлэг орнууд ДНБ-ийхээ 3.5 хувьтай тэнцэх хөрөнгийг гаргасан. АНУ, Франц зэрэг өндөр хөгжилтэй орнууд үндэснийхээ гол салбаруудад шууд их хэмжээний мөнгөн тусламж үзүүлж, дампуурлаас аварсан. Герман ажилгүйдлийн тэтгэмжид илүү их анхаарал хандуулсан байна.

Хөгжиж буй орнуудын хувьд засгийн газрууд нь их хэмжээний мөнгө гаргаж чадахгүй тул энэ орнуудад 2009 оны 10 дугаар сар гэхэд Дэлхийн Банк 12.8 тэрбум, ОУВС 70 тэрбум ам. доллар тус тус зээлүүлсэн ба энэ хэмжээ нэмэгдэнэ гэдгийг уг байгууллагууд мэдэгдээд байна. Зарим хөгжиж буй орнууд мөн тухайлбал, Украин, Унгар, Польш төсвийн тэлэлтийн бодлогыг хэрэгжүүллээ.


Дэлхийн олон улсын байгууллагууд бүгд зөвшилцөж, хамтран ажиллаж байгаа нь дэлхийн бүх улсыг хамарсан энэ удаагийн хямралын хурц үеийг даван туулахад гол үүрэг гүйцэтгэлээ. Улс орнууд, олон улсын байгууллагууд эдийн засгийн тооцоо, судалгааг цаг алдалгүй хийж, салбар болгоны өсөлт өөрчлөлтийн индексийг тооцож дэлхийн, бүс нутгийн, улс болгоны эдийн засгийн төлөв байдлыг тасралтгүй мэдэгдэж байсан нь шийдвэр гаргах, бодлого хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой байв.

Ямар улс харьцангуй бага өртөв? Ямар улс илүү их нэрвэгдэв?

Зураг 3.1-ээс харахад Зүүн Өмнөд Азийн эдийн засаг унаагүйгээр үл барам 6.8 хувийн өсөлттэй байгаа нь энэ удаагийн дэлхийн санхүүгийн хямралаар хамгийн хохирол багатай, тэсвэрлэх чадвар өндөртэй бүс нутаг болохыг харуулж байна. Энэ бүс нутгийн эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгөгч хүч нь Хятад болон Энэтхэгийн эдийн засгийн өсөлт байлаа. Өөрөөр хэлбэл хөгжиж буй улсуудын 2009 оны эдийн засгийн өсөлт нь Хятад болон Энэтхэг улсын эдийн засгийн өсөлтөөр тодорхойлогдож байна. Тухайлбал, 2009 оны гуравдугаар улиралд Хятадын эдийн засаг 8.9 хувиар, харин Энэтхэг улсынх 5.3 хувиар өсчээ. Хятадын эдийн засгийн өсөлтийн гол эх үүсвэр нь гадаад эдийн засгийн эрэлт биш, дотоодын өрхийн хэрэглээ бус, гол нь засгийн газрын хөрөнгө оруулалт, ялангуяа дэд бүтцэд оруулсан их хэмжээний хөрөнгө оруулалт байлаа. Хятадын

3 International Monetary Fund (2009) "World Economic Outlook: Sustaining the Recovery", October 2009

Зураг 3. 1. Дэлхийн эдийн засаг болон зарим улсуудын ДНБ-ий бодит өсөлт, 2009 он (хувиар)



Эх сурвалж: The World Bank Report 2010. Chapter 1, p. 17. www.worldbank.org

экспортод суурилсан өндөр өсөлтийн үе өндөрлөж, дотоодын эрэлтэд түшиглэх эдийн засгийн хөгжлийн үе ирж байгаа талаар судлаачид бичиж байгаа бөгөөд бид мөн өмнөх улирлын тайландаа энэ талаар дурдсан. Дэлхий нийтийг хамарсан хямралд харьцангуй бага өртсөн улсуудын тоонд Хятад, Австрали, Израиль зэрэг улсууд багтаж байна.

Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудаас АНУ, Их Британи, Герман, Япон, хөгжиж буй орнуудаас Европ болон Төв Азийн орнууд тухайлбал, ОХУ, Латин Америкийн орнуудаас Мексик хямралд илүү хүнд нэрвэгдлээ. Мексикийн хувьд ДНБ нь 9.7 хувь хүртэл буурснаас гадна А хүрээний H1N1 вирусийн томуу гарсан учир аялал жуулчлал, агаарын тээвэрлэлтийн салбарууд илүү уналтад орсон байна. Ойрхи Дорнод, Хойд Африк, Персийн булангийн орнуудын хувьд өсөлт 2-4.7 хувьтай гарсан боловч Дубай дахь Дэлхийн холдинг компанийн санхүүгийн тодорхойгүй байдал, ОПЕК-ийн гишүүн орнуудын нефтийн экспорт өсөхгүй байгаа зэрэг нь бүс нутгийн эдийн засгийн зах зээлд итгэх итгэл, санхүүгийн нөхцөл, хөрөнгө оруулалт улмаар ажил эрхлэлтийг нэмэгдүүлэхгүй байна. Зүүн Өмнөд Азийн орнуудаас Малдив, Пакистан, Шри-Ланк зэрэг аялал жуулчлал, гадаадаас ирдэг хувийн мөнгөн гуйвуулгаас ихээхэн хамаардаг эдийн засгууд хямралд илүү нэрвэгдлээ. Африкийн орнуудын хувьд тивийн өмнөд хэсгээр оршдог дэлхийн санхүүгийн зах зээлтэй илүү интегралчлалд орсон ӨАБНУ, Ботсвана, Намиби зэрэг орнууд эхлээд ихээхэн өртсөн бол нефть, түүхий эд экспортлогч Ангол, Габон, Нигер зэрэг орнууд хямралын хоёрдахь үед нь илүү их өртсөн байна.

Банк санхүү, инфляци, төлбөрийн тэнцэл

Дэлхийн гол бараа, түүхий эд тухайлбал, газрын тос, төрөл бүрийн металл, хүнсний барааны үнэ унасан тул 2008 оны 8 дугаар сард 10 хувьд хүрээд байсан дэлхийн инфляцийн түвшин 2009 оны 9 дүгээр сард 1 хувь болтлоо буурлаа.⁴

4 World Bank "Global Economic Outlook 2010". Бүлэг 1. Хуудас 16. www.worldbank.org

Хямралын улмаас дэлхийн худалдааны хэмжээ, импортын хэмжээ ихээхэн буурсан, нефтийн үнэ унасан, Хятад болон АНУ-ын хоорондох худалдааны тэнцлийн зөрүү багассан зэргээс шалтгаалаад дэлхийн төлбөрийн тэнцлийн урсгал тэнцлийн алдагдал багаслаа. 2008 онд дэлхийн хэмжээгээр урсгал тэнцлийн алдагдлын дэлхийн ДНБ-д эзлэх хувь 5.9 хувь байсан бол 2009 онд энэ нь 3.9 болтлоо буурлаа.

2009 онд хөгжиж буй орнууд руу шилжсэн хувийн цэвэр капиталын⁵ хэмжээ өмнөх онтой харьцуулахад 70 хувиар буурсан байна. АНУ, Европын Холбоо, Япон зэрэг орнуудын зээлийн хүү доогуур байх тусам капитал ашиг өндөртэй бусад эдийн засгууд руу шилжих болно. Дэлхийн Банкны тооцоолж байгаагаар 2009 оны эхний хагаст хөгжиж буй орнууд руу шилжсэн капиталын хэмжээ нийтдээ 218 тэрбум ам. доллар байсан бол 2009 оны 11 дүгээр сарын сүүлээр энэ хэмжээ 435 тэрбум ам. доллар болж нэмэгдсэн бөгөөд энэ нь гол төлөв Хятад, Бразил, Чили, Энэтхэг, Турк, Филиппин руу шилжсэн байна. Хэдийгээр энэ хэмжээ 2008 оныхоос 20 хувиар бага байгаа боловч капиталын шилжилт явагдаж, тэр ч байтугай нэмэгдэж эхэлсэн нь санхүүгийн зах зээл тогтворжиж байгааг харуулсан үзүүлэлт юм. Гэвч Арабын Нэгдсэн Эмират, Мексик, Грек зэрэг орнуудад санхүүгийн зах зээл нь тогтворжих болоогүй, аюул дагуулсан хэвээр байна. Мөн хөгжиж буй орнуудын бондын зах зээл сэргэж эхэлсэн талаар дэлхийн санхүүгийн зах зээлийн шинжээчид ярьж байна.⁶

Гадаад худалдаа

Дэлхийн худалдааны хэмжээ аж үйлдвэрийн уналттай адил мөчлөгтэй буурч ирсэн боловч цаг хугацааны хувьд хоцрогдолтой буурч байлаа. Дэлхийн Банкны мэдээлснээр 2008 оны 8 дугаар сар ба 2009 оны 3 дугаар сарын хооронд дэлхийн худалдааны нийт ам. доллараар тооцсон мөнгөн дүн 31 хувиар унасан.⁷ 2008 оны сүүлээс 2009 оны эхний улиралд өндөр хөгжилтэй болон хөгжиж буй орнуудын экспортын болон импортын хэмжээ эрс багассан байна.

2009 оны хоёрдугаар улирлаас дэлхийн экспортын хэмжээ, ялангуяа хөгжиж буй орнуудын экспортын хэмжээ өсөн нэмэгдэж эхэлсэн. Дэлхийн худалдааны хэмжээ буурсан гол шалтгаан нь хямралын улмаас өндөр хөгжилтэй импортлогч орнуудын эрэлт огцом буурсан, гол экспортын барааны дэлхийн үнэ огцом унасан явдал юм. Хөнгөн цагаан, зэс зэрэг гол металлын дэлхийн үнэ 2008 оны 6 дугаар сарын түвшнээс даруй 20 хувиар, газрын тосны үнэ 44 хувиар, хүнсний барааны үнэ 24 хувиар буурсан нь экспортын хэмжээг ийнхүү багасахад хүргэлээ.

2009 оны нэгдүгээр улиралд дэлхийн импортын хэмжээ нийтдээ 40 хувиар буурсан. 2008 оны 9 дүгээр сард “Лиман ах дүүс” (Lehman brothers) дампуурлаа зарласнаас хойш өндөр хөгжилтэй орнуудын импорт илүү ихээр буурч эхэлсэн бол 2009 он гараад хөгжиж буй орнуудын импорт багасч эхэлсэн байна. 2009 оны хоёрдугаар улирлаас эхлэн Зүүн Өмнөд Азийн орнуудын импорт сэргэж эхэлсэн бол гуравдугаар улирлаас хойш өндөр

5 Хувийн цэвэр капитал=дотогш чиглэсэн хувийн капитал урсгал- гадагш чиглэсэн хувийн капитал урсгал

6 www.cnn.com/finance

7 World Bank. 2009. World Economic Outlook.

хөгжилтэй орнуудын импорт нэмэгдэж эхэлсэн хэмээн Дэлхийн худалдааны байгууллагын тайланд тэмдэглэсэн байна. Импорт нэмэгдэж байгаа нь эдийн засгуудын дотоодын эрэлт, цаашилбал үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдсэнийг илэрхийлж буй эерэг үзүүлэлт юм.

Ажил эрхлэлт

2009 оны сүүлээр Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас хямралын улмаас ажилгүйчүүдийн тоо дэлхийн хэмжээнд 30 саяд хүрнэ гэж таамаглаж байсан бол 2010 оны 1 дүгээр сарын байдлаар ажилгүйчүүдийн тоо 212 сая хүн⁸ болсон бөгөөд дэлхийн ажилгүйдлийн түвшин 6.6 хувь⁹ хүрсэн гэж мэдэгдлээ.¹⁰ Ажилгүйчүүдийн ихэнх нь өндөр хөгжилтэй орнууд, Европын Холбооны орнуудад ногдож байгаа ба энэ орнуудын ажилгүйдлийн түвшин өнгөрсөн онд 2.3 пунктээр нэмэгдсэн байна.

АНУ-д ажилгүйдлийн түвшин 9.4 хувь, Канадад 8.0 хувь, Францад 8.8 хувь, Германд 6.9 хувь, Японд 5.5 хувь, Ирландад 11.9 хувь, Испанид 17.9 хувь, Туркэд 13.4 хувь хүрсэн бол Хятадад 5.2 хувь, Өмнөд Солонгост 3.3 хувь болж тус тус өссөн байна.¹¹ Африк тивийн хувьд ажилгүйдлийн түвшин 10 хувь хүрсэн бол Ойрхи Дорнод, Персийн булангийн орнуудын хувьд албан ёсны ажилгүйдлийн түвшин ихээр өсөөгүй байна. Эдгээр оронд Өмнөд болон Зүүн Өмнөд Азиас ирсэн ажилчид ихээр ажилладаг бөгөөд хямралын үед ажилгүй болсон эдгээр хүмүүс тухайн орнуудын албан ёсны ажиллах хүчний тоонд ордоггүй тул ажилгүйдлийн түвшин бага гарсан байж болзошгүй юм. Зүүн Өмнөд Азийн орнуудад ажилгүйдлийн түвшин мөн өндөр биш байна.

Өндөр хөгжилтэй орнуудад ажилгүйдлийн түвшин ийнхүү өндөр байгаа нь энэ орнуудын өрхийн хэрэглээ өсөн нэмэгдэхгүй гэсэн үг юм. Өндөр хөгжилтэй орнуудад дотоодын болон экспортын бараа, үйлчилгээний эрэлт, хэрэглээ нэмэгдэхгүй байх нь дэлхийн эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлнө. Харин хөгжиж буй орнуудад бий болсон ажилгүйдлийн түвшин буурахгүй бол ядуурал нэмэгдэх аюултай юм.

Хөгжиж буй зарим орны хувьд гадаадаас шилжүүлдэг хувийн мөнгөн гуйвуулга ихээхэн ач холбогдолтой байдаг. 2009 онд мөнгөн гуйвуулгын нийт хэмжээ 6.1 хувиар буурсан. Тухайлбал, Армени, Киргиз, Тажикстан зэрэг улсад хувийн гуйвуулгын хэмжээ 15-33 хувь, Бангладешд 16 хувь, Пакистанд 27 хувь, Мексикт 16 хувь, Жамайкад 13 хувиар тус тус буурсан байна. Судлаачдын үзэж байгаагаар 2010-2011 онуудад гадаадаас шилжүүлдэг хувийн мөнгөн гуйвуулга нэмэгдэх төлөвтэй байгаа боловч бодит хэмжээ нь хэрхэн өөрчлөгдөх нь валютын ханшны өөрчлөлтөөс ихээхэн хамааралтай байх юм.

Ядуурал

Өмнөх улирлын тайланд бичсэнчлэн хямралын томоохон сөрөг нөлөө нь хөгжингүй орнуудад ажилгүйдэл эрс нэмэгдэх, харин хөгжиж буй орнуудад ядуурлын түвшин огцом өсөх хандлагаар илэрч байна. Дэлхийн Банкны

8 Итгэлцлийн интервал нь 202-221 сая хүн.

9 Итгэлцлийн интервал нь 6.3-6.9 хувь.

10 International Labor Organization. Global Employment Trend, January 2010. Хуудас 10. www.ilo.org

11 Олон улсын хөдөлмөрийн байгууллага ба Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын тоо мэдээ.

судалгаагаар хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт нэг пунктээр буурах нь ядуучуудын тоог 20 саяар нэмэгдүүлдэг. Тэгвэл энэ онд хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт өнгөрсөн оноос 2.2 пунктээр буурсан тул ядуучуудын тоо 44 саяар өссөн байж болзошгүй юм.

Дэлхийн Банкны ядуурлын судалгаа, бодлогыг тодорхойлдог гол эдийн засагчдын нэг Мартин Равиллионийн үзэж байгаагаар нэг өдөрт 1.25 ам. доллараар аж төрдөг ядуу хүмүүсийн тоо 2005 онд 1.4 тэрбум байсан бол 2009 онд хямралын уршгаар даруй 50 саяар нэмэгдсэн байх магадлалтай бөгөөд үүний тэн хагас нь Өмнөд Азийн орнуудад, 10 сая нь Зүүн Азийн орнуудад, 7 сая нь Африкийн орнуудад байна. 2010 онд энэ тоо үргэлжлэн өсч 89 саяар нэмэгдэх тооцоо байна.¹² Дэлхийн Банкны судлаачдын тооцоолж байгаагаар 2009 онд хямралын улмаас Сахарын цөлийн хавийн Африкийн орнуудад нэмэгдэл 30,000-50,000 хүүхэд хоол тэжээлийн дутагдлаас болж үхсэн байж болзошгүй байна.¹³

Төсвийн алдагдал

Хямрал эхлэнгүүт олон орны эдийн засагт төрийн эзлэх хувь огцом өссөн, тиймээс ч хямралд нэрвэгдсэн дийлэнх улс орнуудад төсвийн алдагдал өндөр байна. Хямралын үед төсвөөс олгосон дэмжлэгийн үр нөлөөний талаар дүгнэлт, үнэлгээ хараахан хийгдэж дуусаагүй байгаа бөгөөд 2010 оны 1 дүгээр сард Азийн Хөгжлийн Банкнаас гаргасан урьдчилсан тооцоогоор төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь АНУ-д 12.5 хувь, Европын Холбоонд 6.2 хувь, Их Британид 13.4 хувь, Японд 10.2 хувь хүрсэн бол Хятадад 2.9 хувь, Энэтхэгт 6.8 хувь болсон байна.¹⁴ Энэ хэмжээ нь 2008 оны хэмжээтэй харьцуулахад даруй 2-3 дахин өндөр үзүүлэлт юм.

Эдийн засгийн уналт зогсож байдал тогтворжиж эхлэхэд төсвийн зарлага болон улсын хөрөнгө оруулалтын механик өсөлт их үүрэг гүйцэтгэсэн. Эдийн засагт төрийн оролцоог аль болох багасгах нь чухал байдаг ч нэгэнт тогтворжиж байгаа эдийн засгийн байдлыг дэмжиж баталгаажуулах үүднээс ОУВС-аас төсвийн зарцуулалтыг бууруулахгүй байх бодлого хэрэгжүүлэхийг зөвлөж байгаа тул 2010 онд төсвийн алдагдлын ДНБ-ий хэмжээнд эзлэх хувь 2009 оны түвшнээс буурахгүй байх төлөвтэй байна.

Энэхүү хямрал ямар сургамж өгөв?

Энэхүү хямрал нь дэлхий нийтийн хэмжээгээр хэд хэдэн чухал сургамжийг өглөө.

- 1) Салбар, компанийн түвшинд бол өндөр хөгжилтэй орнуудын санхүүгийн салбарт, ялангуяа санхүүгийн инженерингт бүртгэлийн, эрсдлийг тооцох, хяналтын, аудитын илүү нарийн зохицуулалт, хяналт хэрэгтэйг харууллаа.

12 Martin Ravallion. The Crisis and the World's Poorest: A special report on poverty situation. 2009. www.worldbank.org

13 Freidman, J & Shadu, N. How Many More Infants are Likely to Die in Africa in the result of the Global Financial Crisis. World Bank. Policy Research Working Paper.

14 Asian Development Bank. (2010). Global Economic and Financial Crisis: Impact on developing Asia and Immediate Policy Implications. Report 1. Хуудас. 37.

- 2) Өрх гэр, хэрэглэгчдийн түвшинд ярихад ялангуяа америкийн өрхүүдэд хэрэглээнээс илүү хадгаламж чухал гэдгийг ойлгууллаа.
- 3) Эдийн засгуудын хувьд бол хямралын улмаас том эдийн засгуудын өрхүүд хэрэглээгээ багасгаж, хадгаламжаа нэмэгдүүлбэл энэ нь хөгжиж буй орнууд болон экспортод чиглэсэн эдийн засгийн бүтэцтэй орнуудад хүндээр тусна тиймээс экспортод түшиглэсэн өсөлтийн стратеги баримталдаг, урсгал дансны илүүдэлтэй хөгжиж буй олон эдийн засаг, тухайлбал БНХАУ дотоодын хэрэглэгчид, дотоодын бизнесийн сектор, төрийн секторын эрэлтэд илүү түшиглэсэн өсөлтийн бодлоготой болох хэрэгтэйг харууллаа. Энэ нь дэлхийн хэмжээгээр сүүлийн хэдэн арван жилийн турш хуримтлагдсан худалдааны болон бусад тэнцвэргүй байдлыг дунд болон урт хугацаанд засах зайлшгүй шаардлага байгаатай холбоотой юм.
- 4) Эдийн засгийн бодлого боловсруулагчдын хувьд зах зээл нийтдээ төдийгүй нэг салбар л гэхэд өөрөө өөрийгөө бүрэн засч, зохицуулж чаддаггүй гэдгийг дахин харууллаа. Хамгийн гол сургамж бол хямрал энэ удаагийнхаар дуусахгүй гэдгийг ойлгууллаа. Мөн нээлттэй глобал болсноороо дэлхийн эдийн засаг хямралд илүү ихээр нийтээрээ өртсөн боловч нээлттэй глобал байсныхаа л хүчинд 2009 оны санхүүгийн хямралыг илүү богино хугацаанд даван туулж байна.

4. Монгол Улсын макро эдийн засгийн өнөөгийн байдал


4.1. Дотоодын үйлдвэрлэл

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2004-2008 оны хооронд жилд дунджаар 9.1 хувиар өссөн бөгөөд энэхүү өндөр өсөлтийн үр дүнд нэг хүнд ногдох ДНБ 2.7 дахин нэмэгдсэнээр манай улс Дэлхийн Банкны бага орлоготой орнуудын жагсаалтаас гарч дундаж орлоготой орнуудын тоонд орсон болохыг бид өмнөх тайландаа тэмдэглэж байсан.

Тэгвэл, 2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр манай улсын ДНБ 6055.8 тэрбум төгрөг болж, өмнөх онтой харьцуулахад (2005 оны зэрэгцүүлэх үнээр) 1.6 хувиар буурсан нь 2009 оны 2 дугаар сард Дэлхийн Банкнаас манай эдийн засгийг 2.7 хувиар өснө гэсэн таамаглалаас нэлээд доогуур байна. Монгол Улсын Сангийн яам 0.5 хувийн өсөлттэй байна гэж оны сүүлээр таамаглаж байсан ч мөн л биеллээ олсонгүй. 2009 оны эхний гурван улирлын туршид манай ДНБ өмнөх оны мөн үеэс огцом уналттай байсан бөгөөд оны сүүлийн улиралд өссөнөөр ДНБ 2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр ийнхүү 1.6 хувиар буурсан нь уналт харьцангуй саарч, эдийн засаг тогтворжиж эхэлж байгаатай холбоотой (Зураг 4.1). Энэ нь хямралд голчлон нэрвэгдсэн хөгжингүй орнуудтай харьцуулахад бага уналт боловч хөгжиж буй орнууд, тэр дотроо Зүүн Азийн бүс нутгийн хувьд томоохон уналтад тооцогдох үзүүлэлт юм. Эдийн засгийн уналтын үйл явц ийнхүү саарсан нь ч цаашид эдийн засаг тогтворжиж, улмаар өсөлтийг хангахад ихээхэн хүчин чармайлт шаардлагатай хэвээр байгааг хямралд нэрвэгдсэн дэлхийн улсуудын өнөөгийн нөхцөл байдал харуулж байна.

Тоон мэдээнээс санхүү, эдийн засгийн хямралын нөлөөгөөр манай эдийн засгийн зарим салбарын үйл ажиллагаанд мэдэгдэхүйц уналт бий болжээ. Тухайлбал, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2009 онд өмнөх онтой харьцуулахад барилгын салбарын нэмэгдсэн өртөг 48.8 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбарынх 26.6 хувь, санхүүгийн гүйлгээний үйл ажиллагааны салбарынх 20.4 хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний татварын нийт хэмжээ 16.6 хувиар тус тус буурсан байна.


Зураг 4.1 ДНБ-ий өсөлт, 2008 ба 2009 онд, хувиар (2005 оны зэрэгцүүлсэн үнээр)



Эх сурвалж:ҮСХ, 2008 оны статистикийн эмхэтгэл, 2009 оны саруудын бюллетень

Барилгын салбар нь хямралд хамгийн хүчтэй нэрвэгдсэн салбар болохыг бид өмнөх тайландаа онцолсон. Уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс үүдэлтэй эдийн засгийн өндөр өсөлттэй байсан жилүүдэд барилгын салбар 2007 онд 8.5 хувь, 2008 онд 8.1 хувиар тус тус өсөн, үйл ажиллагаа нь эрчимтэй өргөжсөн бол эдийн засаг унахад тус салбарын уналт бусад салбартай харьцуулахад мэдэгдэхүйц өндөр байна. Орон сууцны барилгын хэрэгцээ шаардлага төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үеэс манай улсад

Зураг 4.2. ДНБ-ий цэвэр өсөлт бууралт, салбараар, 2009 онд, хувиар



Эх сурвалж:ҮСХ, 2009 оны 12 дугаар сарын бюллетень

өндөр байсан хэдий ч хэрэгцээ шаардлага их байна гэдэг нь эрэлт төдий хэмжээгээр өндөр байна гэсэн үг хараахан биш юм. Барилгын салбар нь байнгын хомсдолтой байсан хэрэгцээгээр өдөөгдөн, сүүлийн жилүүдэд тухайн салбарт олгогдсон ихээхэн хэмжээний зээлээр дэмжигдэж ирсэн билээ. Бодит эрэлт тодорхой хугацаанд мөн орон сууцны зээлээр дамжин өссөн хэдий ч эдийн засгийн бэрхшээл нүүрлэхэд огцом буурсан байна. Барилгын салбарын хувьд тооцоогүй хийгдсэн нийлүүлэлт, түүнчлэн материалын зардал өссөөр байхад үйлдвэрлэлээ нэмэгдүүлснээс үүдэлтэй үнийн хөөрөгдөл, тус салбарын эрхэлж буй үйл ажиллагаанд шаардлагатай зохицуулалт, хяналт хангалтгүй байсан зэргээс ийнхүү уналтад орсон гэж үзэж болох юм. Барилгын зах зээлд сүүлийн хэдэн жилийн турш бүрэлдэж бий болсон “хөөс” ийнхүү хагарсан байна.

Барилгын компаниуд бусад бизнесийг бодвол газраа олж, барилгаа барихын сацуу захиалга авч борлуулалт хийдэг нэлээд онцлогтой салбар юм. Тиймээс барилга барих газар олгох үйл ажиллагаанд төрийн зүгээс тодорхой анхаарал хандуулан, бодлогоор зохицуулж, нэгдсэн судалгаа шинжилгээ хийж, нийлүүлэгчдийг мэдээллээр хангах тал дээр арга хэмжээ авч ажиллаж чадаагүй байна. Бизнес эрхлэгчдийн хувьд эрчимтэй өсч буй, ашигтай салбар гэдгээс мэргэжлийн ур чадвар, боловсон хүчний чадавхи сул, зохион байгуулалт, төлөвлөлт тооцоогүйгээр тус салбар руу хэт олноор орсон нь барилгын салбар богино хугацаанд томорч, үйл ажиллагаа хэт тэлж улмаар уналтад ороход нөлөөлөв. 2009 онд барилгын салбар бараг хоёр дахин унасан нь эдийн засгийн томоохон салбаруудаас хамгийн их нэрвэгдсэн нь болоод байна.

Банк, санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа 2009 онд өмнөх оноос 20.4 хувиар буурсан нь барилгын салбарын уналттай тодорхой хэмжээгээр холбогдож байна. Арилжааны банкууд барилгын компаниуд болон байр, орон сууц авахыг хүссэн иргэдэд өндөр хүүтэй зээл олгосоор байсан нь барилгын салбарын өсөлтийн эргэлдэх хурдыг нэмэгдүүлсэн бол барилгын салбарын уналт нь эргээд арилжааны банкуудын үйл ажиллагааны өнөөгийн хүндрэлтэй байдалд нөлөөлөв. Банкны системд чанаргүй зээл 2009 оны эцэст 462 тэрбум төгрөгт хүрээд байгаа нь өмнөх оны 12 дугаар сарынхаас 2.4 дахин өссөн үзүүлэлт юм. Цаашилбал, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарын нэмэгдсэн өртөг 2009 онд өмнөх онтой харьцуулахад 26.6 хувиар буурсан нь арилжааны банкуудад бий болсон санхүүгийн хүндрэл нь зээлээр бизнесийн үйл ажиллагаа эрхлэн явуулдаг жижиг бизнесийнхний үйл ажиллагаа, улмаар тус бизнесээр амьдралаа залгуулдаг олон иргэдийн амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлэв. Бизнес болон үйлчилгээний үйл ажиллагаа хумигдахын хэрээр татварын орлогын бүрдэлт муудсан байна. Тухайлбал, бүтээгдэхүүн, үйлчилгээний татварын хэмжээ 2009 онд өмнөх оноос 16.6 хувиар буурсан үзүүлэлттэй гарчээ.

Санхүү, эдийн засгийн хямрал барилгын салбарын уналтад хүчтэй нөлөө үзүүлсэн хэдий ч барилгын салбарын уналт нь дээр дурдсанаар нэг талаас тус салбарын үйл ажиллагаанд шаардлагатай хяналт, зохицуулалт сул байснаас, нөгөө талаас компаниудын бизнесийн ур чадвар, чадавхи сул, тооцоо төлөвлөлт, зохион байгуулалт муу байсан зэрэгтэй холбоотой байна. Түүнчлэн, уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс үүдэлтэй эдийн засгийн өсөлтөөр санхүүгийн болон бусад салбарт бий болсон тэлэлтээс зээлийн хэмжээ эрчимтэй нэмэгдсэн нь барилгын салбарын эрс өсөлтөд


нөлөөлсөн агаад эдийн засаг хүндрэлд орсноор зээлийг зогсоосон нь салбарын үйл ажиллагаа зогсч, улмаар унахад хүргэв. Манай улсын дотоодын үйлдвэрлэлийн зарим салбар тэр дундаа барилгын салбарт бий болсон энэхүү уналт нь бодлого боловсруулагчид, бизнес эрхлэгчдэд ихээхэн сургамжтай зүйл болох ёстой гэж үзэж байна.

Хөдөө аж ахуй

Манай улсын эдийн засгийн томоохон салбарын нэг болох хөдөө аж ахуй нь цаг уурын өөрчлөлт болон хүний хүчин зүйлийн хүчтэй нөлөөнд оршдог билээ. 2009 онд нийт 44 сая толгой мал тоологдсон нь малын тоо өмнөх оноос 1.7 хувиар өссөн үзүүлэлт юм. Харин зүй бусаар хорогдсон малын тоо 2009 оны эхэнд нийт малын 4 хувьтай тэнцүү байгаа нь өмнөх оноос 5.6 хувиар өндөр байна. Санхүү, эдийн засгийн хямралтай байсан 2009 онд Атрын III дугаар аянг амжилттай хэрэгжүүлсэний үр дүнд хураасан үр тариа өмнөх онтой харьцуулахад 84 хувь, төмс 12.2 хувиар өссөн зэрэг нааштай хандлага бий болсон ч өвс бэлтгэл 13.3 хувь, гар тэжээл 32.8 хувиар буурсан зэрэг нь цаг агаар муудаж, өвөлжилт ихээхэн хүндэрсэн энэ үед тус салбарт таагүй байдлын бий болгоод байна.

Манай орны адил хөгжиж буй улс орны хөдөө аж ахуйн салбарыг тодорхойлох гол шинж нь *хөдөлмөрийн бүтээмж доогуур, жижиг өрхийн хэлбэрийн аж ахуй, зах зээлийн хязгаарлагдмал байдал* зэрэг үндсэн шинжтэй байдгийг “Олон улсын хөгжил, сэргээгдэх нөөц болон байгаль орчин” байгууллагын Хөгжиж буй орнуудын хөдөө аж ахуй илтгэлд онцолжээ¹⁵. *Хөдөлмөрийн бүтээмж* (нэг ажилчинд оногдох бүтээгдэхүүн эсвэл ажиллах хүчний нэг цагт үйлдвэрлэх бүтээгдэхүүн) маш доогуур байдгаас нийт хүчин зүйлийн бүтээмж доогуур байдаг. Нийт хүчин зүйлийн бүтээмжийг бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардагдсан орцуудын индекст хувааж тооцдог. Малын тоо толгой өслөө, өндөр ургац хураан авлаа гэдэг нь малчид болон тариаланчдын орлого төдий хэмжээгээр өндөр байна гэдгийн баталгаа болдоггүй нь тус салбарт хөдөлмөрийн бүтээмж доогуур байдагтай холбоотой байна. Цаашилбал, хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлд аль нь эцсийн бүтээгдэхүүн, аль нь завсрын бүтээгдэхүүн болохыг тооцоход хүндрэлтэй байдгаас орлогыг нарийн тооцох боломж тааруу байдаг.

Зураг 4.3. Нийт малын тоо толгой, 2009 онд



Эх сурвалж: УСХ, 2009 оны 12 дугаар сарын бюллетень

15 International Development, Renewable Resources, and the Environment, “Agriculture in Developing Countries”, 2008

Хоёрт, хөдөө аж ахуйн үйл ажиллагаа нь гаднаас ажиллах хүчин хөлсөлж авч чаддаггүйгээс ихэнхдээ *өрхийн* үйл ажиллагаанд тулгуурласан байдаг. Тиймээс өрхийн гишүүдийн нас, хүйс, чадавхиас аж ахуйн үйл ажиллагааны үр дүн шууд хамаардаг. Хэрвээ засгийн газрын татварын хөнгөлөлт, татаас болон бусад төрлийн тусламж, дэмжлэгийг зогсоовол тус салбар оршин тогтнох үндэс маш сул байгаа нь хөдөө аж ахуйн салбарт шинэчлэлт, өөрчлөлт хийх чухал шаардлагатайг харуулж байна.

Ус, цаг уурын хүрээлэнгийн мэдээгээр 2009 оны 12 дугаар сард Завхан аймгийн Тосонцэнгэл суманд -46.3 хэм хүрч хүйтэрсэн бол Архангай аймгийн Төвшрүүлэх суманд 40 сантиметр зузаан цасан бүрхүүл бий болсон, Дундговь аймгийн Мандалговь суманд салхины хурд 40м/сек-д хүрсэн зэрэг байгаль цаг уурын гэнэтийн огцом өөрчлөлтийн улмаас олон аймагт өвөлжилт хүндэрч, ихээхэн хүндрэл бий болоод байна. Өвөлжилт хүндэрсэнтэй холбоотойгоор Засгийн газраас малчдад туслах, тусламж дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авч эхлээд байгаа билээ. Энэ нь манай улсын хөдөө аж ахуйн салбар цаг агаарын өөрчлөлт болон хүний хүчин зүйлийн хэт их нөлөөнд оршдогийн тод жишээ юм.

2010 онд манай улсын эдийн засаг 7.4 хувиар өснө гэж Сангийн яам болон олон улсын санхүүгийн байгууллагууд тооцоолж байгаа. Гэтэл манай ажиллах хүчний 40 орчин хувь, ДНБ-ий 20 орчим хувийг бүрдүүлдэг ХАА ийнхүү хүндрэлд орсны улмаас эдийн засгийн өсөлтийн тооцоог эргэн харах шаардлага гарах магадлалтай юм. Түүгээр үл барам хөдөөгийн иргэдийн дунд ядуурал өсөх, нийгмийн асуудал хурцаар тавигдаж болзошгүй байна.

Гуравт, хөдөө аж ахуйн салбар дахь *зах зээлийн хязгаарлагдмал байдал* нь тус салбарын бүтээгдэхүүний нэг нь нөгөөгөөсөө ялгарах ялгааг бага болгодог. Өөрөөр хэлбэл, хөдөө аж ахуйн зах зээлд ижил төрлийн стандарт бүтээгдэхүүн нийлүүлж буй бусад үйлдвэрлэгчдээс ялгарах онцлог муу байдаг. Түүнчлэн, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид шаардлагатай орцоо худалдан авахын оронд ихэнхдээ өөрсдөө бэлтгэдэг, тиймээс бүтээгдэхүүнээ зарж борлуулахаас бусад тохиолдолд зах зээлийн үйлчилгээнд хязгаарлагдмал оролцдог.

Дэлхийн бусад улсуудын туршлагаас эдийн засгийн өсөлтийн хувь (нэг хүнд ногдох дундаж орлогын өсөлт) болон хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн хооронд хүчтэй эерэг хамаарал байдаг. Оюу толгойн зэс, алтны орд, Таван толгойн нүүрсний орд зэрэг уул уурхайн салбарын томоохон төслүүд амжилттай хэрэгжсэнээр манай улсын эдийн засаг 2011 оноос эхлэн хоёр оронтой тоотой хувиар өснө гэсэн тооцоо бий. Эдийн засгийн өсөлт өндөр байна гэдэг нь бүтээгдэхүүн болон үйлчилгээний үйлдвэрлэл нэмэгдэж, бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл зүйлийн өргөжилт бий болно. Эдийн засгийн өсөлт бусад үйлдвэрлэлийн салбарын нэгэн адил хөдөө аж ахуйд нөлөөлнө. Хэрэв уг салбарт хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт бий болвол хөдөөд байгаа илүүдэл ажиллах хүч хөдөө аж ахуйгаас бусад өндөр өсөлттэй салбар руу шилжихэд ХАА-н одоогийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд төдийлөн сөрөг нөлөө үзүүлэхгүй байх боломжтой. Өөрөөр хэлбэл, хүний тоо цөөрсөн ч хөдөөд үйлдвэрлэлийн хэмжээ буурахгүй байх боломж бий. Түүнчлэн, аж үйлдвэр болон үйлчилгээний салбарын хурдан өсөлт нь ДНБ-д эзлэх хөдөө аж ахуйн салбарын хувийн жинг бууруулдаг ба хурдацтай эдийн засгийн өсөлтийн эхний үед энэ байдал илүү тод илэрдэг. Цаашилбал,

эдийн засгийн хурдан өсөлттэй үед өрхүүдийн хүнсний хэрэглээний зардал ч аажимдаа буурна. Учир нь нэг хүнд ногдох орлогын хэмжээ нэмэгдсэнээр өрхийн орлогын хүнсэнд зарцуулдаг хувь хэмжээ буурдаг зүй тогтолтой.

Энэ бүгдээс, эдийн засгийн урт хугацааны өндөр өсөлтийн үр дүнд манай улсын хөдөө аж ахуйн салбар нь шинэчлэлт, өөрчлөлт хийгдэх шаардлагатай тулгарах ба ингэснээр цаг агаар болон хүний хүчин зүйлийн хүчтэй нөлөөнд оршдог хөдөө аж ахуй үйл ажиллагаанд уламжлалт төдийгүй орчин үеийн үр ашигтай хэлбэр бүхий фермерийн аж ахуйн төрөл, хэлбэр хөгжих боломж бүрдэх бололцоотой юм. Энэ өвлийн зудын байдалтай холбоотой ХАА-н эрсдлийг бууруулах асуудал чухлаар тавигдаж байна. Малын даатгалын тогтолцоог хэрэгжүүлэх, малын тоог цөөрүүлж, үр шимийг нэмэгдүүлэх, малын хашаа хороо зэрэгт хөрөнгө оруулалт хийх, малын тэжээл зэрэг өвөлжилтийн бэлтгэлийг сайтар хангах, малыг эрүүлжүүлэх, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын потенциалыг – үүнд мах ба махан бүтээгдэхүүн, сүү ба сүүн бүтээгдэхүүн, арьс, шир, өлөн гэдэс, ноос ноолуур зэрэг бүх төрлийн бүтээгдэхүүн орно – нэмэгдүүлэх зэрэг олон чухал асуудал тавигдсаар байна. Эдийн засгийн хямралын нэгэн адилаар зудын байдал дахин давтагдах нь тодорхой учир ХАА-н салбарт томоохон өөрчлөлтүүдийг хийж, эрсдлийг даван туулах чадварыг дээшлүүлэх асуудал нэн чухал байна.


Аж үйлдвэр ба үйлчилгээний салбар

Манай улсын аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2009 онд (2005 оны зэрэгцүүлэх үнээр) 1704.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 3.3 хувиар буурсан байна. Энэ бууралтад боловсруулах аж үйлдвэрийн салбар 14.2 хувь, металлын хүдэр олборлолтын дэд салбар 6.2 хувиар буурсан нь сөргөөр нөлөөлжээ. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 2009 оны нэгдүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 8.3 хувь, оны эхний хагас жилд 7.9 хувь, оны эхний есөн сард 10.5 хувиар тус тус унаад байсан бол жилийн эцсийн дүнгээр салбарын уналтын хэмжээ багасч 3.3 хувиар буурсан нь нааштай хандлагын илрэл билээ.

Гэхдээ, аж үйлдвэрийн салбарын зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.6-аас 92.6 хувиар унасан байгааг тэмдэглэх хэрэгтэй. Энэхүү уналт нь нарийн боов, амтат ундаа, хиам, талх зэрэг хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, катодын зэс, самнасан ноолуур, цемент, шохой, төмөр бетон эдлэл, молибдений исэл зэрэг боловсруулах салбарын үйлдвэрлэлд үргэлжилсэн хэвээр байна. Аж үйлдвэрийн салбарын бууралтад томоохон хувийг эзэлж буй боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг Зураг 4.4-т үзүүлэв.

2009 онд тээврийн үйлчилгээний салбарт өмнөх онтой харьцуулахад бүх төрлийн тээврээр тээвэрлэсэн ачаа 3.5 хувь, зорчигчдын тоо 0.3 хувиар өссөн нааштай хандлагатай байна. Бүх төрлийн тээврээр тээсэн ачааны өсөлтөд авто тээврээр тээсэн ачаа 14.1 хувиар өссөн нь хүчтэй эерэг нөлөө үзүүлэв. Харин зорчигчдын тооны хувьд авто тээврээр зорчигчид өмнөх онтой харьцуулахад давхардсан тоогоор 2.1 сая хүнээр нэмэгдсэн бол төмөр замынх 1.3 сая, агаарын тээврийнх 56.4 мянган хүнээр буурсан байгаагаас хэрэглэгчид өндөр үнэтэй агаарын болон төмөр замын тээврийг харьцангуй хямд үнэтэй авто замын тээврээр орлуулах болсон нь харагдав. Шатахууны үнэ болон автомашины үнэ 2009 онд буурсан нь авто тээврийг харьцангуй хямд болгосон байна.

Зураг 4.4. Боловсруулах аж үйлдвэрийн салбарын өсөлт хувиар, 2006-2009 онд (2005 оны зэрэгцүүлсэн үнээр)



Эх сурвалж: УСХ, 2006-2008 оны статистикийн эмхэтгэл, 2009 оны 12 дугаар сарын бюллетень

Дотоодын үйлдвэрлэл, тэр дундаа аж үйлдвэрийн боловсруулах салбарын уналт нь бидний өмнөх улирлын тайланд онцолсноор үнийн өсөлтийг бууруулахын тул авч хэрэгжүүлсэн мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр дотоодын нийт эрэлт буурсантай холбоотой гэж үзэж байна. Дотоодын үйлдвэрлэлийн уналтаас үүдэн ажилгүйдлийн хэмжээ нэмэгдсэн нь дотоодын нийт эрэлтэд мөн сөргөөр нөлөөлөв. Үндэсний статистикийн хорооноос явуулсан ажиллах хүчний судалгаагаар¹⁶ 2009 оны гуравдугаар улиралд манай улсад нийт 119 мянган ажилгүй хүн байсан нь ажилгүйдлийн түвшин 10.5 хувьд хүрснийг илтгэж байна. 2009 оны 12 дугаар сарын сүүлээр аймаг, нийслэлийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгүүлсэн, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 38.1 мянгад хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 28 хувиар өсчээ.

Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын хөгжиж буй манайх шиг эдийн засагт үзүүлж буй томоохон сөрөг нөлөө нь ажилгүйдлийн өндөр түвшний улмаас ядуурлын хэмжээ огцом өсөх хандлагаар илэрч байгааг ОУВС-аас гаргасан судалгаа харуулав¹⁷. Тиймээс ажиллах хүчнийг бизнесийн салбар руу буцаан оруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бүтээмжийн өсөлтийг хангах зорилгоор санхүү, бизнесийн үйл ажиллагаандаа бүтцийн өөрчлөлт хийх шаардлага хямралд нэрвэгдсэн дэлхийн олон улсад тулгарч байна. Манай улсын хувьд ч мөн дотоодын үйлдвэрлэл тэр дундаа боловсруулах аж үйлдвэрийн салбар дахь уналт нь тус салбарт шинэчлэлт, өөрчлөлт хийх шаардлага чухал байгааг илтгэв.

Уул уурхай, олборлох аж үйлдвэр

2004 оноос 2008 онд Монгол Улсын ДНБ дунджаар 9.1 хувийн өсөлттэй байснаас нэг хүнд ногдох ДНБ 7.7 хувиар өссөн бол мөн хугацаанд уул уурхайн салбарын үйлдвэрлэл 10.2 хувиар өссөн билээ. Тэгвэл, 2009 онд

¹⁶ Үндэсний статистикийн хороо, Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал (2009 оны урьдчилсан гүйцэтгэл)

¹⁷ World Economic Outlook: Sustaining the Recovery, International Monetary Fund, October 2009

манай улсын уул уурхай олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл дэлхийн зах зээлд бий болсон зэсийн үнийн хэлбэлзлэлээс улбаалан нэгдүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 6 хувь, эхний хагас жилд 1.6 хувь, гуравдугаар улиралд 2.4 хувиар тус тус унаад байсан бол оны эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр (2005 оны зэрэгцүүлсэн үнээр) 2.2 хувиар өсчээ. Энэ нь манай гол түүхий эдийг худалдан авдаг БНХАУ-ын эдийн засаг тогтвортой өсч байгаагийн улмаас эрдэс баялгийн эрэлт өндөр хэвээр байгаатай холбоотой юм. Цаашдаа ч энэ хандлага үргэлжлэх магадлалтай тул эрдэс баялгийн салбарын хувьд төлөв эерэг байгаа. Гэхдээ тус салбарын зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 0.6-аас 72.8 хүртэл хувиар буурсан байна. Үүнд төмрийн хүдэр 0.6 хувь, цайрын баяжмал 1.5 хувь, хайлуур жоншны баяжмал 19.3 хувь, алт 35.4 хувь, гянтболдын баяжмал 72.8 хувиар тус тус буурчээ.

2008 онд манай улс молибдений хүдэр ба баяжмал, жоншны хүдэр ба баяжмалыг тус бүр 10 гаруй улсад экспортлож байсан бол энэ онд таван улсад л экспортлосон байна. Молибдений хүдэр ба баяжмалын хувьд өмнөх онтой харьцуулахад БНСУ, ХБНГУ, БНХАУ-д экспортлосон хэмжээ нэмэгдсэн бол Япон улсынх эрс буурсан, Эстони, Киргизстан, Нидерланд, Арабын Нэгдсэн Эмират зэрэг улсуудад огт экспортлоогүй байна. Молибдений хүдэр ба баяжмалын нийт экспортлосон тоо хэмжээ өнгөрсөн оноос (тонноор) 66 хувиар өссөн ч мөнгөн дүн нь (ам.доллараар) 36 хувиар буурчээ. Харин жоншны хүдэр ба баяжмалын хувьд экспортлосон хэмжээ, мөнгөн дүнгийн аль аль нь 50 орчим хувиар унасан бөгөөд уг эрдсийг голлон худалдан авдаг ОХУ болон Украин улсын импортын бууралт үүнд сөрөг нөлөө үзүүлэв. Эндээс үзэхэд импортлогч улсуудын эдийн засгийн нөхцөл байдал, түүхий эдийн үнэ ханшны аль аль нь манай улсын уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлд нөлөөлж байна.

Уул уурхайн салбар нь аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 65 хувь, экспортын орлогын 60 хувь, улсын төсвийн орлогын 40 хувь, эдийн засгийн нийт үйлдвэрлэлийн 30 орчим хувийг эзэлдэг манай эдийн засгийн том салбар билээ. Тиймээс Оюу толгойн зэс, алтны орд, Таван толгойн нүүрсний орд зэрэг томоохон төслийн үйл ажиллагаа хэрхэн амжилттай хэрэгжихээс манай улсын ирээдүйн төлөв хандлага, эдийн засгийн хөгжил хамаарах болоод байна.

Манай улсын уул уурхайн салбар дахь өсөлт нь дэлхийн зах зээл дэх зэс, эрдэс баялгийн түүхий эдийн үнийн өсөлтөөс шууд хамааралтай. Харин манай эдийн засаг нь уул уурхайн салбараас хүчтэй хамаарсан энгийн бүтэцтэй бөгөөд дэлхийн зах зээлд эрдэс баялгийн түүхий эдийн үнэ өсөхөд манай эдийн засагт авч ирэх эерэг нөлөө хүчтэй байдгийн адил үнэ буурахад учрах сөрөг нөлөө мөн шууд мэдрэгддэгийг бид тэмдэглэж байсан. Тухайлбал, 2009 оны эхний зургаан сарын дунджаар 2008 оны 12 сарын дундажтай харьцуулахад нэг тонн зэсийн үнэ 31.7 хувь, нэг унц алтны үнэ 12.1 хувиар буурснаас 2009 оны эхний хагас жилд оны нэгдүгээр улиралтай харьцуулахад тус салбарын үйлдвэрлэлийн уналт бараг дөрөв дахин буурсан. Бодит эдийн засаг уул уурхайн салбараас хараат байх нь гадаад зах зээл дээр үнэ тогтворгүй болсноос тухайн улсын эдийн засаг тогтворгүй болж, эдийн засгийн тогтворгүй орчин нь тодорхой бус байдлыг бий болгодгоос хувь хүн, пүүс компаниудын бизнес эрхлэх сонирхол багасч, улмаар эдийн засагт оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ буурдаг сөрөг үр дагавартай.

Дэлхийн зах зээл дэх эрдэс баялгийн түүхий эдийн үнийн өсөлтөөр нөхцөлдсөн эдийн засгийн өндөр өсөлттэй байсан сүүлийн жилүүдэд ДНБ-д засгийн газрын зарлагын эзлэх хувь 2005 оныг бодвол 2008 онд 10 гаруй хувиар өссөн бол эдийн засаг дахь хувийн секторын эзлэх хувийн жин мөн хугацаанд 8 орчим хувиар буурсан дүнтэй байна. Ийнхүү уул уурхайн салбарын эдийн засагт эзлэх хувийн жин нэмэгдэхийн хэрээр төсвийн орлого нэмэгдэж төсвийн тэлэлт бий болсноор эдийн засагт төрийн оролцоо нэмэгдэж, улмаар хувийн секторын эзлэх хувийн жин буурч буй сөрөг хандлага манай эдийн засагт бий болоод байна. Хөдөлмөрийн зах зээл ба нийгмийн эмзэг байдлын талаар бэлтгэсэн тайландаа¹⁸ бид засгийн газрын зарлагын өсөлтийн эрчимжилт, нийгмийн халамжийн үйлчилгээний цар хүрээний өргөжилтийн талаар авч үзсэн байгаа. Тодруулбал, 2008 онд 2003 оноос нийгмийн халамжийн үйлчилгээний зардал 11 дахин, уг үйлчилгээнээс хүртсэн иргэдийн тоо 16.8 дахин өсчээ. Цаашилбал, 2005 онд нийгмийн халамжийн үйлчилгээнд зориулан орон нутгийн төсвөөс 39.6 сая төгрөг оруулж байсан бол 2008 онд 100 хувь улсын төсвөөс санхүүжсэн зэрэг нь манай эдийн засагт төвлөрөл нэмэгдэж, төрийн оролцоо өссөнийг харуулж байна.

Эдийн засагт бий болсон нөхцөл байдлаас харахад уул уурхайн томоохон төслүүд хэрэгжихийн хэрээр улсын секторын хувийн жин өсч, нийгмийн халамжийн үйлчилгээ өргөжсөнөөс иргэдийн ажил хийх идэвх санаачилгыг бууруулах, хувийн секторын үйл ажиллагааг шахах зэрэг сөрөг хандлага нэмэгдэж болзошгүй байна. Иймээс энэ сөрөг хандлагыг аль болох багасгахын тулд уул уурхайгаас орж ирэх хөрөнгө оруулалтыг хувийн бизнесийг дэмжих, ажиллах хүчнийг бизнесийн салбар руу татах, бүтээмжийн өсөлтийг хангахад чиглүүлэх ингэснээр дотоодын үйлдвэрлэлийн салбарт шинэ бүтээгдэхүүний үйлдвэрлэл, төрөлжилтийг бий болгох нь чухал юм.

Үүний тулд төрийн зүгээс хувийн секторын, үүнд хувь хүмүүс, пүүс компаниудад бизнесийн үйл ажиллагаа эрхлэн явуулах орчныг илүү таатай болгох бодлогоор дэмжлэг үзүүлэх нь нэн чухал байна. Юун түрүүнд хямралын эсрэг, улмаар эдийн засгийн дунд болон урт хугацаанд эерэг нөлөө үзүүлэх хамгийн чухал арга хэмжээ бол эрэлт болон нийлүүлэлтийг хөшүүрэгдэх шууд бодлого гэхээс илүү бизнес эрхлэхэд таатай институцийн орчинг бүрдүүлэх явдал гэж бид өмнөх тайлангууддаа удаа дараа тэмдэглэж байсан.

2010 оныг Монгол Улсын Засгийн газраас “Бизнесийн орчны шинэтгэлийн жил” болгон зарлаж бизнесийн орчныг шинэтгэх талаар хууль, тогтоомж, шийдвэрийн төсөл боловсруулахаас эхлэн ажиллаж байгаад бидний судлаачид ач холбогдол өгч, бодит эдийн засгийн үндэс суурь болсон хувийн секторын үйл ажиллагааг дэмжиж, цаашид өргөжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн ихээхэн тустай алхам болох болов уу гэсэн өндөр хүлээлттэй байна. “Бизнесийн орчны шинэтгэлийн жил” болгон зарлаж буй нь нэг талаас эдийн засгийн хямралд нэрвэгдсэн манай улсын дотоодын үйлдвэрлэл үйлчилгээний салбарыг уналтаас гаргаж, эдийн засгийн тогтворжилт улмаар өсөлтийг хангахад чиглэсэн зөв зүйтэй санаачилга болж байгаа бол нөгөө талаас, уул уурхайн томоохон төслүүд хэрэгжиж эхлэхтэй холбоотойгоор манай улсын эдийн засгийн урт хугацааны өсөлтийг хангахад дорвитой хувь нэмэр оруулах ажлын эхлэл байх болно гэж найдаж байна.

18 Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө: Хөдөлмөрийн зах зээл ба нийгмийн эмзэг бүлэг, эхний хагас жилийн тайлан, 2009 он

4.2. Гадаад худалдаа

Монгол Улсын хувьд хямрал гадаад худалдааны сувгаар илүү дамжиж нөлөөлсөн. 2009 оны экспортын нийт хэмжээг 2008 онтой харьцуулахад 632 сая ам. доллараар буюу 25 хувиар буурсан бол импорт 1 тэрбум 113 сая ам. доллараар буюу 34 хувиар буурсан дүн гарсан байна. 2008 оны сүүлийн улирлаас эхлэн экспорт, импортын хэмжээ эрс буурч ирсэн байдал энэ оны эхний гурван улиралд үргэлжилсээр байсан бол дөрөвдүгээр улиралд байдал экспортын хувьд хэмжээ нь нэмэгдсэнийг тоон үзүүлэлт харуулж байна. Тухайлбал, 2009 оны дөрөвдүгээр улиралд экспортын хэмжээ өмнөх оны тухайн саруудтай харьцуулахад 0.5-16.2 хувиар өссөн нь Хүснэгт 4.1-ээс харагдаж байна.

Хүснэгт 4.1. Гадаад худалдааны өөрчлөлт, 2009 онд, хувиар
(өмнөх оны мөн үетэй харьцуулахад)

	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
Экспорт	-21.3	-71.0	-38.6	-21.3	-71.0	-38.6	-16.2	-23.6	-26.1	0.5	16.2	2.4
Импорт	-40.0	-51.0	-24.3	-40.0	-51.0	-24.3	-44.8	-35.9	-32.1	-21	-24.4	-17.5


Эх сурвалж: УСХ, 2009 оны 12-р сарын бюллетень

Дөрөвдүгээр улиралд импортын хэмжээ өмнөх оны тухайн саруудтай харьцуулахад өсөөгүй боловч багассан хэмжээ нь гуравдугаар улиралд ажиглагдсан уналтаас бага байгаа нь мөн дээрх хүснэгтээс харагдаж байна. Бизнесийн болон өрхүүдийн эрэлт ихээхэн нэмэгддэг дөрөвдүгээр улиралд импортын хэмжээ өсөөгүй нь дотоодын эрэлт хангалттай сайн өсөхгүй байгааг илэрхийлж байна. 2009 оны эхний хоёр улирлын турш экспортын хэмжээний уналт нь импортын хэмжээний уналтаас их байсан бол гуравдугаар болон дөрөвдүгээр улиралд импортын уналт нь экспортынхоос илүү их байна. Импортын хэмжээний уналт нь экспортынхоос илүү их байгаа учир гадаад худалдааны алдагдал дөрөвдүгээр улиралд багассан байна.

2009 оны сараар авч үзвэл нэгдүгээр улирлын туршид экспорт, импортын хэмжээ огцом багассан бол хоёрдугаар улирлаас эхлэн экспортын болон импортын хэмжээ аажмаар нэмэгдэж ирсэн бөгөөд ялангуяа дөрөвдүгээр улиралд экспорт болон импорт хоёулаа ихээхэн өссөн байна (Зураг 4.5). Есдүгээр сараас эхлэн экспорт болон импортын хэмжээ аажмаар үргэлжлэн нэмэгдэж, эхний найман сарын хугацаанд байсан түвшингээс давж гарсан нь мөн зургаас харагдаж байна. 12 дугаар сард гадаад худалдааны эргэлт он гарсаар хамгийн өндөр түвшиндээ хүрчээ.

2009 оны гуравдугаар улиралд алтны экспорт зогссон байсан бол 9 дүгээр сард 2.2 тонн болж өссөн байна. Зэсийн баяжмалын экспорт хэвийн түвшиндээ хийгдэж байсан бөгөөд сард дунджаар 50 мянган тонн зэсийн баяжмал экспортлосон байна (Хүснэгт 4.2). 2009 оны дөрөвдүгээр улирлын экспортын нийт хэмжээ өссөн нь алт, зэсийн баяжмал, мах, арьс ширний экспорт эхний улиралтай харьцуулахад нэмэгдсэнтэй холбоотой байна. Монголын зэсийн гол экспортлогч Хятадын эдийн засгийн байдал тогтвортой байгаа, дэд бүтэц, ялангуяа төмөр замд оруулж байгаа хөрөнгө оруулалт тасралтгүй нэмэгдэж зэсийн эрэлт өсч байгаатай холбоотойгоор дэлхийн зах

Зураг 4.5. 2009 оны экспорт ба импортын хэмжээ, сая ам. доллар



Эх сурвалж: УСХ, 2009 оны 12-р сарын бюллетень

зээл дээр зэсийн эрэлт өсч байна.¹⁹ Тухайлбал, БНХАУ 2009 онд Бээжин-Шанхай хотын хоорондох хурдан галт тэрэгний зам шинээр тавьсан бөгөөд ийм хурдан галт тэрэгний сүлжээ барихад энэ онд гэхэд 50 миллиард ам. доллар зарцуулах бөгөөд 2020 он гэхэд зөвхөн төмөр замын салбарт л гэхэд 300 миллиард ам. доллар зарцуулах төлөвлөгөөтэй байгаагаа мэдэгдсэн.²⁰ Энэ нь дэлхийн зэсийн эрэлтийг нэмэгдүүлэх тогтвортой эх үүсвэр байгааг болон манай зэсийн экспорт ирэх онуудад өсөн нэмэгдэх боломжтойг харуулж байна. Нөгөө талаас, мэргэжлийн хүмүүсийн дүгнэж байгаагаар дэлхийн өндөр хөгжилтэй улс орнууд өндөр түвшний технологи, мэдлэгт суурилсан эдийн засгийн бүтцэд аажмаар шилжиж байгаа бол Энэтхэг, Хятад зэрэг Азийн томоохон эдийн засгууд байгалийн баялаг эрчимтэй ашигладаг аж үйлдвэржилтийн үе шатандаа орж буй талаар мэдэгдэж байна.

Хүснэгт 4.2. Гол барааны экспортын хэмжээ 2009 онд

Сар	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Алт (тн)	3.9	0.3	0.4	0.7	0.9	0	0	0.6	2.2	1.2	0.8	0.7
Зэсийн баяжмал (мян. тн)	45.7	44.3	47.6	50.9	51.3	50.6	42.9	51.2	48.5	51.3	50	52.8
Бохир ноолуур (тн)	29.5	48.7	31.7	311	420.3	1384	691.2	545.4	92.8	3.5	0	17.8
Самнасан ноолуур (тн)	131	12.9	42.7	62.4	196	146	274.2	172.2	116	160	119	190.7

Эх сурвалж: УСХ, 2009 оны 12-р сарын бюллетень

Гуравдугаар улиралд бохир ноолуурын экспортын оргил үе байсан бөгөөд зөвхөн 6 дугаар сард л гэхэд 1.4 сая тонныг экспортлосон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал өндөр байна. 2009 оны 5 дугаар сард бохир ноолуурын экспортын татварыг тэглэсэн нь ийнхүү бохир ноолуурын экспортыг эрс

19 Зэсийн хамгийн том хэрэглэгч болох БНХАУ зэсийн баяжмалын импортын 17 хувийн болон цэвэршүүлсэн зэсийн экспортын 10 хувийн татваруудаа тэглэсэн нь манай зэсийн экспортод мөн эерэг нөлөө үзүүлж байгаа талаар мөн өмнөх тайланд дурдсан.

20 www.cnn.com/news

өсгөсөн. Бохир ноолуурын экспортын хэмжээ дөрөвдүгээр улиралд эрс багассан бол самнасан ноолуурын экспортын хэмжээ тогтвортой байсан бөгөөд дөрөвдүгээр улиралд нийт 469.7 мянган тонныг экспортлосон нь нэгдүгээр улирлын экспортын хэмжээнээс 2.5 дахин их байна (Хүснэгт 4.2).

Монголын махны экспортын 90 орчим хувийг ОХУ авдаг бөгөөд 2009 оны нийт үхрийн махны экспорт 2008 оны нийт хэмжээнээс хоёр дахин өссөн бөгөөд Япон, Казахстан улсууд руу гаргадаг адууны махны хэмжээ 42 хувиар нэмэгдсэн нь хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний экспорт нэмэгдэж байгааг харуулж байна. 2009 оны дөрөвдүгээр улиралд энэ салбарын экспортын бүтээгдэхүүний хувьд байдал сайжирч байгаа боловч 2010 оны нэгдүгээр сард гэхэд нийт 44 сая толгой малаас нэг сая толгой мал хорогдсон ба цаашид ч энэ зүй бус хорогдол нэмэгдэх шинжтэй байгаа нь 2010 онд мах, ноолуурын экспортонд сөргөөр нөлөөлөх төлөвтэй байна.

Үйлчилгээний экспортын хувьд хямрал тээврийн салбарт илүү хүнд туслаа. Экспортын барааны төмөр замын тээвэрлэлт 8.4 хувиар нэмэгдсэн боловч импортынх 32 хувиар буурсан байна. Төмөр замаар гадаадад зорчигсдын тоо 30 хувиар, агаараар зорчигсдын тоо 10 хувиар тус тус буурсан байна. Ингэж буурахад хямрал нөлөөлсөн нь дамжиггүй боловч дэд бүтэц, тээвэрлэлт, логистикд хийсэн хөрөнгө оруулалт бага байсан нь уг салбарын өсөлтийг зогсоолоо. Таван толгойн нүүрсний үйлдвэрээс Хятад руу тавих төмөр замын асуудал шийдэгдэхгүй удах тусам дэлхийн зах зээлд бага өртөгтэй хүргэх боломж алдагдаад байх болно. Бараа, түүхий эдийг түргэн хугацаанд экспортлох, импортлох, бараагаа дэлхийн зах зээлд хүргэх зардлыг багасгаж чадаж байж эдийн засгийн өсөлтийг бий болгон, өрсөлдөх чадвараа дээшлүүлнэ. Экспортын нийт зардлын 18 хувь, импортын зардлын 10 хувь нь тээвэрлэлтийн зардал байдаг.²¹ Энэхүү цуврал тайлангийн эхний дугаарт дурдсан тээвэрлэлт, логистикийн хөгжил дорой хэвээр байна. Тухайлбал, дэлхийн худалдааны томоохон ачаа тээврийн 1000 компаниас авсан түүвэр судалгаагаар 2010 оны нэгдүгээр сарын байдлаар дэлхийн 115 орныг “Logistic Performance Index”-ээр жагсаахад Монгол сүүлээсээ хоёрт буюу 114-т жагссан байгаа нь манай гадаад худалдааны хурд, хэмжээ, үр ашигт ихээхэн сөргөөр нөлөөлж байна²².

Аялал жуулчлалын салбарын хувьд 2009 онд манайд ирсэн жуулчдын тоо өмнөх онтой харьцуулахад 3 хувиар буурсан байна. Жуулчдын тоог орноор нь харвал Япон, БНСУ, АНУ, Австрали, Канад зэрэг хөгжингүй орнуудаас ирсэн жуулчдын тоо 17-25 хувиар багассан бол БНХАУ-аас ирсэн жуулчдын тоо 16.6 хувиар нэмэгдсэн байна. Дэлхийн хэмжээнд жуулчдын тоо 8.4 хувиар, зүүн Өмнөд Азид ирсэн жуулчдын тоо 6.3 хувиар буураад байгаа энэ үед манайд ирэх жуулчдын тоо хэмжээ гурван хувиар буурсан гэдэг харьцангуй бага бууралт юм. Гэхдээ өндөр хөгжилтэй орнуудаас ирсэн жуулчдын тоо эрс цөөрсөн нь жуулчдын салбарын нэмэгдсэн өртөгт сөргөөр нөлөөлсөн байх магадлалтай. Учир нь БНХАУ-аас ирсэн жуулчдын худалдан авах үйлчилгээ нь өндөр хөгжилтэй орны жуулчдаас бага байх магадлалтай юм.

Ирсэн жуулчдын тоо буурахад зөвхөн хямрал нөлөөлөөд зогсохгүй бензин түлшний үнийн өсөлт болон дэлхийн даяар тархсан А хүрээний H1N1 вирусийн томуу сөргөөр нөлөөллөө. Хямрал жуулчлалын салбарт арай хөнгөн

21 UNDP.(2009). Trade policy and human development in Mongolia. p. 111.

22 www.worldbank.org


туссан хэдий ч 2010 онд ирэх жуулчид, ялангуяа өндөр хөгжилтэй орнуудаас ирэх хүмүүсийн тоо үргэлжлэн буурч болзошгүй гэж үзвэл аялал жуулчлалын салбарын орлогод сөргөөр нөлөөлнө.

2009 оны импортын нийт хэмжээг 2008 онтой харьцуулахад 1 тэрбум 113 сая ам. доллараар буюу 34 хувиар буурсан гол шалтгаан нь дотоодын аж үйлдвэрлэл унасантай ялангуяа импортын бараа материал илүү их ашигладаг барилгын салбарын уналттай ихээхэн холбоотой. Хямралын улмаас 2009 онд уг салбар өмнөх онтой харьцуулбал 48.8 хувиар бага барилга угсралт, их засварын ажил хийж гүйцэтгэсэн байна. Түүнчлэн химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, уул уурхайн машин тоног төхөөрөмжийн импорт буурсан хэвээр байна. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэгчдийн эрэлт өсөхгүй байна.

Хэрэглээний барааны импортын хувьд, 2009 оны сүүлийн хагаст бензин болон дизель түлшний импорт өссөн. Эхний хоёр улиралд багасаад байсан хүнсний гол бараа болох гурил, цагаан будаа, элсэн чихэр, ургамлын тосны импорт сүүлийн хоёр улиралд ихээхэн нэмэгдсэн байна. Харин хэрэглэгчдийн алт мөнгөн эдлэл, суудлын автомашин зэрэг тансаг хэрэглээний барааны импортын эрэлт бага хэвээр байна. 2009 оны эхний хоёр улиралд өмнөх үетэй харьцуулахад багасаад байсан хүнсний гол барааны импортын хэмжээ гурав, дөрөвдүгээр улирлуудад нэмэгдсэн нь хэрэглэгчдийн эрэлт аажмаар өсч байгаа байгааг харуулж байгаа бол үйлдвэрийн түүхий эд, бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмжийн импорт бага хэвээр байгаа нь дотоодын үйлдвэрлэгчдийн эрэлт нийтдээ сайжрахгүй байгаатай холбоотой.

Мөн түүнчлэн импортын нийт хэмжээ буурсан өөр нэг шалтгаан нь 2009 оны гурав, дөрөвдүгээр улиралд өмнөх оны мөн үетэй, ялангуяа оны эхэн үетэй харьцуулахад ам. доллартай харьцах төгрөгийн ханш суларсан тул дотоодын үйлдвэрлэгчид болон хэрэглэгчдийн хувьд гадаадаас худалдан авах бараа үйлчилгээ, материал түүхий эд илүү үнэтэй болсонтой холбоотой. Зүйрлэж хэлбэл 1 ам. долларын үнэтэй барааг 2008 оны 11 дүгээр сард 1,170 төгрөгөөр импортлож байсан бол уг барааг 2009 оны 11 дүгээр сард 1,446 төгрөгөөр авах болж байна гэсэн үг. Төгрөгийн ханш ингэж унаж байхад хүнсний барааны импорт гурав болон дөрөвдүгээр улиралд өссөн бол үйлдвэрийн түүхий эд, бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмжийн импорт

Зураг 4.6. Гадаад худалдааны тэнцэл 2009 онд сараар, сая ам. доллар




Эх сурвалж: Монгол Банкны 12 дугаар сарын статистикийн сарын мэдээлэл

нэмэгдэхгүй хэвээр байна. Тиймээс нийт импорт 34 хувиар буурсан шалтгаан бол *нэгдүгээрт*, үйлдвэрлэгчдийн эрэлт илүү буурсан, *хоёрдугаарт*, төгрөгийн ханш суларсантай холбоотой гэж үзэж байна.

Зураг 4.6-д сүүлийн хоёр жилийн гадаад худалдааны тэнцлийг харууллаа. 2008 онд гадаад худалдааны тэнцлийн алдагдал зарим сард нэг тэрбум ам. доллар хүрч байсан бол 2009 онд энэ хэмжээ эрс багассан бөгөөд хамгийн их гэхэд 12 дугаар сард 228 сая ам. доллар хүрсэн байна. Азийн Хөгжлийн Банкны тооцоолсноор уг алдагдлын хэмжээ 2008 онд ДНБ-ний 13.1 хувьтай тэнцүү байсан бол 2009 онд ДНБ-ний 6.9 хувьтай тэнцэхээр хэмжээнд очиж буурсан байна.²³ Эндээс харахад хямралын нэг эерэг нөлөө бол гадаад худалдааны алдагдал багасч буй явдал юм.

Хямралын улмаас 2009 онд Польш, Тажикстан, Турк зэрэг орнуудад гадаадаас шилжүүлдэг хувийн гуйвуулгын хэмжээ багассан бол Зүүн Өмнөд Азийн орнуудад тухайлбал, Бангладеш, Филиппинд гуйвуулгын хэмжээ 30 хувиар өссөн мэдээ байна.²⁴ Зураг 4.7-оос харахад Монголын хувьд 2008 оны 11 дүгээр сараас эхлэн буураад байсан гадаадаас шилжүүлдэг хувийн гуйвуулгын хэмжээ 2009 оны 7 дугаар сараас эхлэн нэмэгдэж эхэлсэн байна. 11 дүгээр сарын гуйвуулгын хэмжээ 20.8 сая ам доллар болсон нь хямралын өмнөх үеийн хэмжээнээс давж гараад байна (Хавсралт 4). 2007 онд хувийн шилжүүлгийн нийт хэмжээ 174 сая ам доллар, 2008 онд 185 сая ам доллар байсан бол 2009 оны 11 дүгээр сарын дүнгээс харахад нийт хэмжээ нь өмнөх оны нийт хэмжээтэй тэнцүү байхаар байна.²⁵ Гадаад худалдааны алдагдал багасч байгаа болон гадаадаас шилжүүлэх хувийн гуйвуулга нэмэгдэж байгаа нь эдийн засаг дахь гадаад валютын нөөц нэмэгдэхэд, цаашилбал төгрөгийн ханш тогтворжиж ирэхэд эерэг нөлөөтэй.

Зураг 4.7 2009 онд гадаадаас шилжүүлсэн хувийн мөнгөн гуйвуулгын хэмжээ (сая ам. доллар)




Эх сурвалж: Монголбанкны Валют эдийн засгийн газрын тооцоо

23 Asian Development Bank. ADB regional forum on the impact of global economic and financial crisis. Report 2. Хуудас 29.

24 Asian Development Bank. ADB regional forum on the impact of global economic and financial crisis. Report 1. Хуудас 28.

25 UNDP (2009) Trade policy and human development in Mongolia. p. 91. Монгол Банкны Валют эдийн засгийн газрын тооцоо.

Зураг 4.8 Гадаад худалдааны эргэлтээс авч буй татварын орлого, сая төгрөг²⁶



Эх сурвалж: УСХ, 2009 оны 12-р сарын бюллетень

Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр 2009 онд өмнөх онтой харьцуулахад импортын бараанаас авсан гаалийн албан татварын орлого 15 хувиар, экспортын бараанаас авсан гаалийн албан татварын орлого 45 хувиар, импортоор оруулдаг бензин, дизель түлш, архи, тамхи, пиво, автомашинаас авах онцгой албан татварын орлого 18 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна (Зураг 4.7). 2009 оны экспортын нийт хэмжээг 2008 онтой харьцуулахад 25 хувиар, импорт 34 хувиар буурсан учраас гадаад худалдаанаас авах татварын орлого ийнхүү нийтдээ 43 тэрбум төгрөгөөр буурсан байна.²⁷ 2009 онд төвийн алдагдал 328 тэрбум төгрөгт хүрэхэд гадаад худалдаанаас олох татварын орлого 43 тэрбум төгрөгөөр тасалдсан нь нөлөөллөө. Өмнөх эдийн засгийн хямралуудын нэгэн адил ихэнх улс оронд төсвийн алдагдал нэмэгдэж, улсын өр өсөх үйл явдал энэ удаагийн хямралаар мөн давтагдлаа.

Эдийн засгийн хямралын түүхийг сөхвөл улс орнуудын бодлого дотоодын зах зээлээ илүүтэйгээр хамгаалсан, худалдааны татвараа өсгөх зэрэг гадаад худалдааны протекционист бодлого явуулж ирсэн нь илт байна. Энэ удаагийн санхүүгийн хямралаар олон улсын худалдааны байгууллага улс орнуудыг аль болох протекционист бодлого авч хэрэгжүүлэхгүй байхыг уриалж, улс орнууд ч хичээж байна. Тэгсэн хэдий ч хөгжилтэй болон хөгжиж буй хэд хэдэн орнууд протекционист бодлого хэрэгжүүлж эхлээд байна (Хүснэгт 4.3).

Манай хоёр хөрш орны хувьд Монголоос авах зэс, ноолуур болон жонш, махны импортод аливаа худалдааны саад хориг тогтоогоогүй тул хямралын үеийн экспортын борлуулалт харьцангуй хурдан сэргэж байна гэж үзэх үндэстэй юм.

26 Импортын онцгой албан татварын орлогод импортоор оруулж ирсэн бензин, дизель түлш, архи, тамхи, пиво, суудлын автомашинаас авсан татварын орлогын нийлбэр дүнг харууллаа.

27 2009 онд өмнөх онтой харьцуулахад импортын бараанаас авсан гаалийн албан татварын орлого 21 тэрбум, экспортын бараанаас авсан гаалийн албан татварын орлого 4 тэрбум, импортоор оруулдаг бензин, дизель түлш, архи, тамхи, пиво, машинаас авах онцгой албан татварын орлого 18 тэрбум төгрөгөөр буюу нийт 43 тэрбум төгрөгөөр буурсан.

Хүснэгт 4.3 Дэлхийн зарим орны авч хэрэгжүүлж байгаа протекционист бодлого

Улс	Протекционист бодлогын хэлбэр
Европын Холбоо	Цецгийн тос, бялаг, сүүний экспортод татаас олгож эхэлсэн.
Герман, Франц, Канад	Автомашин салбарт их хэмжээний хөнгөлөлттэй зээл олгосон.
ОХУ	Автомашин салбарт их хэмжээний хөнгөлөлттэй зээл олгосон, 2009 оны 1 дүгээр сараас импортын машинаас авах гаалийн татвараа нэмэгдүүлсэн.
Энэтхэг	2008 оны 11 дүгээр сараас гангийн импортын татварыг нэмэгдүүлсэн.
Өмнөд Солонгос	2009 оны 3 дугаар сараас түүхий нефтийн импортын татварыг 1-3 хувиар нэмэгдүүлсэн.
Индонез	2008 оны 12 дугаар сараас электрон бараа, хувцас, гутал, хоол хүнсний импортыг зөвхөн 5 порт, нисэх онгоцны буудлаар оруулж ирэхээр болсон.
Аргентин	Импортоор оруулж ирж байгаа авто машины сэлбэг, эд анги, хувцас, гутал, савхин эдлэл, телевизор, тоглоомонд лизенцийн шаардлага тавьж эхэлсэн.
Эквадор	900 орчим барааны импортын татварыг нэмэгдүүлсэн.

Эх сурвалж: Baldwin, R and Evenett.S. (2009) *The collapse of global trade, murky protectionism, and the crisis*. VoxEU.org publication, p. 31

Хямралын Монголын эдийн засагт нөлөөлсөн гол суваг нь гадаад худалдаа бөгөөд нөлөөлсөн гол механизм бол 2008 оны дөрөвдүгээр улирал болон 2009 оны эхний улиралд зэсийн дэлхийн үнэ унасан явдал байлаа. Дэлхийн худалдааны эргэлт энэ үед мөн эрс багассан. Дэлхийн Банкны мэдээлснээр 2008 оны 8 дугаар сар ба 2009 оны 3 дугаар сарын хооронд дэлхийн худалдааны нийт ам. доллараар тооцсон мөнгөн дүн 31 хувиар унасан байна.²⁸ ОУВС-ийн мэдээлж байгаагаар 2009 оны ерөнхий дүнгээр дэлхийн худалдааны эргэлт 12 хувиар хумигдсан байна²⁹. Монгол Улсын хувьд 2009 оны дөрөвдүгээр улиралд экспортын болон импортын хэмжээ аажмаар нэмэгдэн эхний зургаан сард байсан түвшнээс давсан нь улирлын шинж чанартай бус харин эдийн засаг нийтдээ тогтворжиж эхэлж буйн шинж тэмдэг гэж үзэж байна. Энэхүү нөхцөл байдалд банкны салбарын тогтворжилт, улмаар зээлийн өсөлт, аж үйлдвэрийн салбарын эрэлт нэмэгдэх нь чухал байна. Гадаад худалдааны сэргэлт дотоодын бодит эдийн засагт эерэг хөшүүрэг болох нь тодорхой юм. Гэхдээ энэ нөлөөлөл хүчээ авахад тодорхой цаг хугацаа шаардагдах нь ойлгомжтой.

Хямралын улмаас улс орнуудын гадаад худалдааны хэмжээ багассан тул өмнөх онтой харьцуулахад дэлхийн худалдааны эргэлт эрс багаслаа. Япон, ОХУ, Герман, Канад зэрэг орнуудын экспортын хэмжээний уналт нь импортын хэмжээний уналтаас их байсан тул экспортын салбарууд уналтад орж улмаар ажилгүйдэл ихээр нэмэгдсэн, экспортын салбаруудаас авах татварын орлого багассан тул эдгээр томоохон эдийн засгууд 2009 оны дэлхийн эдийн засгийн хямрал илүү хүндээр тусчээ. АНУ, Их Британи, БНХАУ, Бразил, Испани, Өмнөд Солонгос, Туркийн хувьд импортын хэмжээний уналт нь экспортын уналтын хэмжээнээс их байсан нь бусад эдийн засгууд, ялангуяа хөгжиж

28 World Bank. 2009. World Outlook.

29 IMF. World Economic Outlook. October 2009

байгаа орнуудын экспортыг багасгаж уналтад нөлөөлсөн тул хямралыг өөрсдөө гэхээсээ бусдад илүү үүрүүлсэн орнууд боллоо. Монголын хувьд импортын хэмжээний 34 хувийн уналт нь экспортын 25 хувийн уналтаас өндөр учраас бусад орнуудтай харьцуулахад гадаад худалдааны салбарт хямралыг харьцангуй хохирол багатай давсан орон боллоо. Үүнд алтны үнэ тогтвортой байсан болон зэсийн үнэ харьцангуй богино хугацаанд өсч эхэлсэн, мөн манай экспортын гол түнш болон БНХАУ-ын эдийн засгийн тогтвортой байдал нөлөөлсөн гэж үзэж байна.

4.3. Үнэ ханш ба мөнгөний бодлогын тойм³⁰

Мөнгөний бодлого

Тайлант онд мөнгөний бодлого үндсэндээ гол зорилгоо биелүүлсэн харагдаж байна. 2009 онд инфляцийн түвшин 4.2 хувь байсан нь Монголбанкнаас тайлант онд тавьсан зорилго болох нэг оронтой тоонд багтсан. Үнийн өсөлт ийнхүү тогтворжиж эхэлсэн нь макро эдийн засгийн тогтворжилтийн эхлэлийг тавьсан ч өнөөгийн байдлаар банкны салбар нэлээд тогтворгүй орчинд үйл ажиллагаагаа явуулж байна.

2008 оны сүүлийн улиралд манай гол экспортын бүтээгдэхүүнүүдийн дэлхийн зах зээл дээрх үнэ буурсантай холбоотойгоор их хэмжээний гадаад худалдааны алдагдалд орсон. Энэ нь төгрөгийн ханш сулрах дарамтыг бий болгосон нь бодлого боловсруулагчдыг гадаад валютын ханшинд зохицуулалт хийхэд хүргэсэн. Нөгөө талаас, эдийн засгийн өсөлттэй байсан сүүлийн жилүүдэд мөнгөний хэт тэлэх бодлого явуулсан нь үнийн өсөлтийг бий болгоод байсан бөгөөд 2008 онд инфляци дунджаар 26 хувь байсан нь үндсэндээ 2009 онд баримтлагдсан мөнгөний бодлогыг тодорхойлж байна.

2009 онд манай гол экспортын бүтээгдэхүүнүүдийн үнэ өсөх хандлагатай байсан нь гадаад худалдааны алдагдлыг бууруулж улмаар төгрөгийн ханш буурах дарамт багасч, түүнтэй зэрэгцээд мөнгөний хатуу бодлого явуулсан нь үнийн өсөлт буурахад нөлөөлжээ. Тодруулбал, гадаад худалдааны алдагдал оны эцэст 230 сая ам.доллар байсан нь өмнөх онд 1 тэрбум ам.долларт хүрээд байсан түвшнээс ихээхэн буурсан харагдаж байна. 2008 оны сүүл, 2009 оны эхний хагаст мөнгөний нийлүүлэлт тогтвортойгоор буурч тайлант оны 6 дугаар сарын байдлаар 5 хувиар буураад байсан. Харин, тайлант оны хоёрдугаар хагаст мөнгөний нийлүүлэлт өсч оны эцсийн байдлаар 26.9 хувиар өсөөд байна.

Инфляцийн түвшин 2008 оны эцэст 23 хувь байсан бол тайлант оны хоёрдугаар хагаст буурснаар мөнгөний нийлүүлэлтийг өсгөх боломж Монголбанкинд бүрдсэн юм. Тайлант оны эцэст инфляцийн түвшин 4.2 хувьд хүрсэн бөгөөд оны турш дунджаар 7 хувьтай байсан нь мөнгөний бодлого үндсэндээ тавьсан зорилтдоо хүрсэн нь харагдаж байна.

Ийнхүү, инфляцийн түвшин буурч тогтворжсон хэдий ч мөнгөний нийлүүлэлт огцом өссөн байдалтай байна. Мөнгөний нийлүүлэлтийг өсгөх нь бодит эдийн засгийн өсөлтийг бий болгоход түлхэц болох хэдий ч өнөөгийн байдлаар

30 “Дэлхийн санхүү эдийн засгийн хямралын Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө: Монгол улсын санхүүгийн зах зээл” хоёрдугаар хагас жилийн тайлангаас дэлгэрэнгүй хэлэлцүүлгийг үзнэ үү.

бодит эдийн засаг руу гарсан зээлийн үлдэгдэл тэр бүр өссөнгүй. Тухайлбал, банкуудаас олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2009 оны эцсийн байдлаар 2.5 их наяд төгрөг байгаа нь өмнөх оны түвшиндээ байна. Энэ нь тайлант онд банкны системээс шинээр зээл гараагүй гэдгийг харуулж байгаагаас гадна банкууд дахь хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн үлдэгдэл огцом өсч 583 тэрбум төгрөг буюу нийт зээлийн багцад 22 хувь эзлэх болсон нь банкны системийн хэвийн үйл ажиллагаа доголдож ирснийг илтгэж байна. Бид өмнөх улирлын тайлангууддаа Монголбанкнаас хямралтай тэмцэх зорилгоор баримталсан мөнгөний хатуу бодлогын гол үр дүн нь үйлдвэрлэл, үйлчилгээний уналт, үүнээс улбаалаад банкуудын зээлийн чанарын бууралт бий болно гэж сануулж байсан нь харамсалтай нь өнөөдөр биелэлээ олж байна.

Тэгвэл хямралтай тэмцэхийн тулд мөнгөний зөөлөн бодлого буюу мөнгөний тэлэлт хийх ёстой байсан уу гэдэг асуулт гарч байна. Сүүлийн үед олон эдийн засагчид, бодлого боловсруулагчид болоод үйлдвэрлэгчид мөнгөний хатуу бодлогыг шүүмжилсэн. Тэд мөнгөний зөөлөн бодлого явуулж улмаар зээлийн нийлүүлэлтийг ихэсгэх замаар үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг зээлээр хангаж өгөх ёстой гэж үзсэн. Үүнд үнэний хувь бий. Жишээлбэл, өнөөдөр хямралтай амжилттай тэмцэж байгаа улс орнуудыг харахад мөнгөний тэлэх бодлого явуулж байгаа. Тухайлбал, АНУ-д л гэхэд мөнгөний нийлүүлэлтийг бодлогын хүүгээ бууруулах замаар цааш өсгөх боломжгүй болсон ч гэсэн шинэ төрлийн бодлогын арга хэрэгсэл нэвтрүүлэх замаар өсгөсөн. 2008 оны 9 дүгээр сарын байдлаар АНУ-ын Холбооны Нөөцийн Системийн тэнцэл 1.2 их наяд ам.доллар байсан бол 2009 оны эцэст 2.2 их наяд ам. доллар болж огцом өссөн нь чухамхүү мөнгөний нийлүүлэлтийг өсгөх бодлогын үр дүн юм. Сонирхуулахад, өнөөгийн байдлаар АНУ-ын төв банкнаас шинээр нэвтрүүлсэн бодлогын арга хэрэгсэл болох үл хөдлөх хөрөнгийн үнэт цаасыг барьцаалж банкууддаа олгосон зээл 1.2 их наяд ам.долларын үлдэгдэлтэй байгаа нь мөнгөний тэлэх бодлогыг хэрхэн хүчтэй хийж байгааг харуулж байна.

Тэгвэл манай оронд анхнаасаа яагаад мөнгөний тэлэх бодлого баримтлаагүй вэ, яагаад иймэрхүү тэлэлт хийх боломжгүй байсан бэ, яагаад 2009 оны хоёрдугаар хагасаас л тэлэлт хийсэн бэ гэх мэт асуулт гарч байна. Бидний үзэж байгаагаар инфляцийн түвшин хэт өндөр байсан учраас мөнгөний хатуу бодлого баримтлахаас өөр арга байсангүй. Учир нь үнийн өсөлт өндөртэй үед мөнгөний нийлүүлэлтийг хэт өсгөх нь хямралыг улам хурцатгах аюултай байдаг. Тийм ч учраас үнийн өсөлтийг бага түвшинд барих нь макро эдийн засгийн тогтворжилтийг бий болгоход хамгийн чухал. 2009 оны хоёрдугаар хагаст үнийн өсөлт үндсэндээ бага түвшинд ороод ирсэн учраас Монголбанкнаас мөнгөний нийлүүлэлтийг өсгөх бодлого баримталсан гэж үзэх үндэстэй. Дээр өгүүлсэнчлэн, мөнгөний нийлүүлэлтийн өсөлт нь банкнаас бодит эдийн засаг руу гарах зээлийг өсгөх учраас бодит эдийн засагт бий болоод байгаа уналтыг сааруулах, эдийн засгийн өсөлтийн үндэс болох учиртай.

Хэдийгээр мөнгөний бодлогын арга хэмжээнүүд ийнхүү зөв өрнөлтэй явагдаж байгаа ч анхаарах зүйлс багагүй байна. Юуны өмнө мөнгөний нийлүүлэлт маш богино хугацаанд ийнхүү өндөр өсч байгаа нь сонирхол татаж байна. Зөвхөн 9 дүгээр сарын эцэст гэхэд л 12 сараар тооцсон мөнгөний нийлүүлэлт 5.1 хувь байсан бол оны эцэс гэхэд 26.9 хувь болтлоо огцом өссөн. Өөрөөр хэлбэл, зөвхөн оны сүүлийн гурван сарын дотор сарын 8.5 хувиар өссөн нь хэт өндөр байна. Монголбанк энэхүү өсөлтийг үйлдвэрлэл, үйлчилгээний

салбарыг дэмжихэд зориулж бий болгосон уу гэвэл хараахан тийм биш. Монголын эдийн засаг улирлын шинж чанартай, тухайлбал өвлийн улиралд томоохон салбарууд зогсонги байдалд ордог гэдгийг бид бүхэн мэдэж байгаа. Тэгэхээр намрын улиралд ийнхүү мөнгөний нийлүүлэлт өсөх нь тэр болгон үйлдвэрлэл, үйлчилгээнд нөлөөлөхгүй. Энэ нь ч банкуудын тэнцлээс харагдаж байна. Тухайлбал, банкуудын илүүдэл нөөц дөрөвдүгээр улиралд огцом өссөн. Банкууд төв банкинд харилцах данстай байдаг бөгөөд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийнхөө 5 хувьтай тэнцэх хөрөнгийг энэ дансанд байршуулж байх ёстой. Илүүдэл нөөц гэдэг нь заавал байх хэмжээнээс давсан хөрөнгийн үлдэгдлийг хэлж байгаа юм. Илүүдэл нөөцтэй байна гэдэг нь тухайн банк зээл олгохгүй хөрөнгөө сул байршуулж байна гэсэн үг.

Бидний хийсэн тооцоогоор 9 дүгээр сард илүүдэл нөөц 180 гаруй тэрбум төгрөг байсан бол 12 дугаар сарын байдлаар банкуудад 270 орчим тэрбум төгрөгт хүрсэн байна.³¹ Өөрөөр хэлбэл, банкууд зээл олгохгүй харилцах дансандаа их хэмжээний хөрөнгийг сул байршуулж байна. Үүн дээр төв банкны үнэт цаасны үлдэгдэл болох 392 тэрбум төгрөгийг нэмж тооцвол нийтдээ 600 гаруй тэрбум төгрөгтэй тэнцэх хөрөнгийн эх үүсвэр банкуудад байгаа хэдий ч зээл олгохгүй байна гэсэн үг. 600 тэрбум төгрөг гэдэг бол одоогийн банкуудаас олгоод байгаа цэвэр зээлийн (чанаргүй зээлийг хасч тооцсон зээл) үлдэгдэл болох 1.7 их наяд төгрөгийн 35.3 хувьтай тэнцэж байгаа нь маш өндөр үзүүлэлт гэдгийг тэмдэглүүштэй.

Тэгвэл ийм их хэмжээний хөрөнгө зээл болохгүй юм бол яагаад мөнгөний нийлүүлэлтийг өсгөсөн бэ? Энэ нь Монголбанкнаас явуулсан гадаад валютын нөөцөө зузаатгах гэсэн бодлоготой нь холбоотой. Бид өмнөх тайлангууддаа гадаад валютын ханшны бодлого мөнгөний бодлогоосоо урьтаж мөнгөний нийлүүлэлтэд зохицуулалт хийгээд байгаа талаар дурдсан. Бидний үзэж байгаагаар энэ бол маш их төөрөгдөл үүсгэж байгаа асуудал юм. Монголбанк гадаад валютын ханшийг тогтвортой барих хангалттай нөөц байхгүй учраас гадаад валютын ханшны өсөлтийг барих чадамж байхгүй талаар бид сануулж байсан. Түүгээр ч үл барам өмнөх жилүүдэд явж ирсэн хандлагаас харахад алт тушаалт их хийгддэгтэй холбоотойгоор мөнгөний нийлүүлэлт огцом өсдөг талаар ч дурдаж байсан. Тийм учраас иймэрхүү огцом өсөлтийг энэ жил гаргахгүй байх нь зах зээлд зөв дохио өгөхөд дэмтэй талаар сануулж байсан. Гэтэл, дөрөвдүгээр улиралд бидний сануулж байсан зүйл яг хэвээр давтагдсан нь харагдаж байна. Ганцхан ялгаа нь энэ жил алт тушаалтаас биш гадаад валют худалдан авах замаар Монголбанк мөнгөний нийлүүлэлтийг өсгөсөн байна.

Монголбанкнаас ийнхүү гадаад валютын нөөцөө өсгөх бодлого идэвхийлэн баримталсан нь мөнгөний нийлүүлэлтийг тайлант улиралд хүчтэй өсгөөд байна. Өөрөөр хэлбэл, энэ улиралд гадаад валютын нөөцийн бодлого мөнгөний бодлогоосоо урьтаж мөнгөний нийлүүлэлтэд зохицуулалт хийсэн байна. Манай улсын гадаад валютын нөөц оны эцэст 1.1 тэрбум ам.долларт хүрсэн нь чухамхүү дээрх гадаад валютын зах дээр хийсэн худалдан авалт томоохон үүргийг гүйцэтгэсэн байна. Дашрамд дурдахад, Монголбанк Засгийн газрын хадгаламж болоод ОУВС-аас Стэнд-бай хөтөлбөрийн хүрээнд авсан зээлээр гадаад валютын нөөцөө мөн зузаатгасан.³²

31 Илүүдэл нөөцийг банкуудын нөөцөөс заавал байлгах нөөцийг хасах замаар тооцов.

32 “Дэлхийн санхүү эдийн засгийн хямралын Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө: Монгол улсын санхүүгийн зах зээл” хоёрдугаар хагас жилийн тайланд дэлгэрэнгүй хэлэлцсэн

Хэдийгээр, гадаад валютын нөөцийн хуримтлалыг бий болгох нь эдийн засгийн онцгой нөхцөл байдал эсвэл аюул бий болсон нөхцөлд улс орныг импортоор тасралтгүй хангахад хэрэг болдог ч байнга мөнгөний нийлүүлэлтийн бодлогоосоо урьтаж байгаа нь бидний санааг зовоож байгаа юм. Өөрөөр хэлбэл, мөнгөний бодлогын үр нөлөө, ач холбогдол, цаашилбал нэр хүндийг нь унагаж байна. Үүнтэй адилаар гадаад валютын ханшны бодлого мөнгөний бодлогоос байнга урьтаж байгаа нь мөнгөний бодлогын нөлөөллийг илт сулруулж байна. Энэ талаар бид өмнөх улирлын болоод санхүүгийн зах зээлийн тайлангууддаа дэлгэрэнгүй хэлэлцсэн байгаа. Тухайлбал, мөнгөний бодлого бодит эдийн засгийн өсөлтийг дэмжих үү аль эсвэл үнийн өсөлтийг хязгаарлах уу гэсэн хүндхэн сонголттой учирдаг бол, манайх шиг жижиг нээлттэй эдийн засагтай орнуудад гадаад валютын хөвөгч ханшийг эрхэмлэх үү аль эсвэл хангалттай нөөцтэй тохиолдолд тогтмол ханшийг сонгох уу гэсэн хүндхэн сонголтуудтай тулгардаг. Тийм ч учраас хэдийгээр амаргүй ч гэсэн Монголбанк хараат бус байдлаа хадгалан дээрх сонголтуудыг нэг тийш нь шийдэх нь чухлаар тавигдаж байна. Бидний үзэж байгаагаар нэг боломжит хувилбар бол инфляцийг бус харин мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг “онилох” бодлого баримтлах явдал юм.

Энэ бүхнээс дүгнэхэд хэдийгээр үнийн өсөлт бага түвшинд хүрч макро эдийн засгийн тогтворжилт ажиглагдаж эхэлж байгаа ч өмнөх жилүүдэд хэрэгжсэн мөнгөний хэт тэлэх бодлого 2010 онд үргэлжилж үнийн өсөлтийг хөөрөгдөж магадгүй байдалтай байна. Бидний үзэж байгаагаар үнийн өсөлтийг нам түвшинд барих нь Монголбанкны цорын ганц зорилго гэж олон нийтэд зарлах нь зүйтэй санагдаж байна. Учир нь олон нийтэд энэ байгууллагын үндсэн зорилгын талаар нэгдмэл ойлголт байхгүй байна. Тодруулбал, зарим нэг нь үнийн өсөлтийг бага байлгахад Монголбанкны гол зорилго оршиж байгаа гэж үзэж байхад зарим нэг нь үүн дээрээ нэмээд гадаад валютын ханшийг тогтвортой байлгах, зарим нэг нь бүр бодит эдийн засгийг дэмжих ёстой гэж үзэж байна. Монголбанкны зүгээс ч гэсэн энэ тал дээр бүрхэг хариулт өгч байгаа нь байдлыг бүр ч ойлгомжгүй байдалд оруулж байна. Тухайлбал, төгрөгийн худалдан авах чадварыг тогтвортой барихыг зорьж байгаа гэдэг тайлбар нь хоёрдмол утгатай байгааг анхаарах хэрэгтэй байна.

Монголбанк болон мөнгөний бодлогын хараат бус байдал

Монголбанк ийнхүү гол зорилгоо олон нийтэд нэг мөр тодорхой болголгүй гадаад валютын захад байнга оролцож ирсэн нь энэ байгууллагын хараат бус үйл ажиллагаа явуулж чадаж байгаа эсэхэд анхаарал тавихад хүргэж байна. Ялангуяа, Монголбанкны үйл ажиллагаанд Улсын Их Хурлаас ихээхэн оролцож байгаа нь байдлыг улам хурцатгаж байна. Төв банкны хараат бус үйл ажиллагаа бол тухайн улсын эдийн засаг тогтвортой өсч чадах эсэхтэй салшгүй холбоотой, тухайн улс орны эдийн засгийн бодлогын амин чухал бүрэлдэхүүн хэсэг нь юм. Тийм ч учраас хөгжингүй орнуудад төв банкны хараат бус байдлыг нийтээрээ хүлээн зөвшөөрч үйл ажиллагаанд нь төрийн байгууллагууд оролцдоггүй, төв банк нь хараат бус учраас ямар нэг “дарамт” ирсэн ч гэсэн бие даан шийдвэрээ гаргадаг чадамж бүхий байдаг. Хараат бус байдлаа алдсан төв банктай орнууд эдийн засгийн хувьд эмгэнэлтэй байдалд ордогийг Зимбабвед болж байгаа гипер инфляци харуулж байна. Энэхүү улсад хамгийн сүүлийн хэмжилтээр өдөрт 98 хувийн үнийн өсөлттэй байгаа нь (бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ нэг өдөрт л хоёр дахин өсч байна

гэсэн үг) дэлхийн түүхэнд хоёр дахь хүчтэй инфляци гэж тооцогдож байна.³³ Энэ жишээ манай улсын хувьд хол сонсогдож болох ч аливаа нэг орны төв банк нэгэнт нөлөөнд автагддаг болсон тохиолдолд байдал маш амархан хурцдах аюултай гэдэг нь тодорхой. Аргентины төв банкны ерөнхийлөгч тус улсын шинэ ерөнхийлөгчөөс ирсэн “дарамт”-ыг эсэргүүцэн ажлаа хүлээлгэн өгсөн нь чухам төв банкны хараат бус байдлын ач холбогдлыг илэрхийлж байна.

Манай улсын хувьд төв банкны хараат бус байдлыг хадгалж байх нь маш чухлаар тавигдаж байна. Ялангуяа, томоохон эрдэс баялгийн ордууд ашиглалтад орохоор хүлээгдэж байгаа үед мөнгөний бодлого хараат бус байх нь бүр ч чухал байна. Харамсалтай нь манай орны өнөөгийн улс төрийн тогтолцоо эрдэс баялгаас орсон орлогыг олон нийтэд хавтгайруулан тэтгэмж хэлбэрээр үргүй зарцуулах замаар дахин сонгогдох сонирхлыг их хэмжээгээр төрүүлж байна. Энэхүү ашиг сонирхлыг дарах улс төрийн, эдийн засгийн механизм харамсалтай нь алга. Үүнтэй тэмцэх нэг байгууллага нь Монголбанк. Монголбанк хараат бус байх нь манай улсыг баялгийн “хараал”-аас хэлтрүүлэх угтвар нөхцөл болж өгнө.

Гэтэл, сүүлийн үед Монголбанкинд гарсан удирдлагын өөрчлөлт энэ байгууллагын хараат бус үйл ажиллагаа явуулж чадаж байгаа эсэхийг сорьлоо. Бидний үзэж байгаагаар хуучин тэргүүн дэд болоод дэд ерөнхийлөгчид ажлаа чухам ямар шалтгааны улмаас ийнхүү нэгэн зэрэг хүлээлгэн өгч байгаа нь тодорхойгүй өнгөрлөө. Нөгөө талаас, Улсын Их Хурал чухам ямар шалтгааны улмаас эдгээр хүмүүсийг ажлаас нь чөлөөлж байгаа талаар үнэмшилтэй тайлбар гаргасангүй. Үнэхээр эдгээр хүмүүс буруу бодлого явуулсан бол УИХ үүнийг тодруулах ёстой байсан. Ингэж тодруулснаараа УИХ Монголбанкнаас чухам ямар гүйцэтгэл хүлээж, шаардаж байгаагаа нээлттэй илчлэх байсан юм. Харамсалтай нь иймэрхүү мэдээлэл гаргасангүй. Энэ бүхнээс харахад Монголбанк хараат бус үйл ажиллагаа явуулж чадахгүй байна гэж үзэхээс өөр аргагүй мэт.

Энэхүү үйл явц гадаадын хөрөнгө оруулагчид болоод дотоодод үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа хүмүүст маш их түгшүүр, сөрөг дохио өгсөн гэдэг нь эргэлзээгүй. Харамсалтай нь энэ бол анх удаагаа тохиолдож байгаа үйл явдал биш юм. Улсын Их Хурлын сонгуулийн дараа Засгийн газар солигдох бүрт Монголбанкны ерөнхийлөгч өөрчлөгдөж ирсэн нь маш буруу зуршил юм. Эдийн засгийн бодлогын залгамж холбоог хангаж байхын тулд Монголбанкны ерөнхийлөгчийг зургаан жилээр томилдог байтал сүүлийн хэд хэдэн ерөнхийлөгчид ийнхүү хугацаанаасаа өмнө ажлаа өгч байгаа нь үйл явц хуульд заасны дагуу тэр бүр өрнөхгүй байгааг харуулж байна.

Төв банкны бодлогод тодорхой улс төрийн хүчин, бүлэглэл нөлөөлөөд байвал үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт өрсөлдөөн үүсэхгүй, харин ч улс төрийн ашиг сонирхол дагасан бүлэглэлүүд улам хүчирхэгжиж хүмүүст шинэлэг үйлдвэрлэл, үйлчилгээ гэхээсээ илүү иймэрхүү бүлэглэлүүдэд автах сонирхлыг бий болгодог. Эдийн засгийн өсөлт зөвхөн шинэ үйлдвэрлэл, үйлчилгээгээр тэжээгдэж байдаг бөгөөд эцсийн дүндээ иймэрхүү ашиг сонирхлын бүлэглэлүүд шинэ үйлдвэрлэл, үйлчилгээг нухчин дардаг. Өөрөөр

33 Steve H. Hanke, “R.I.P Zimbabwe Dollar”, Cato Institute, 25 June, 2008. www.cato.org/zimbabwe

хэлбэл, нэмэгдсэн өртөг үйлдвэрлэлийг үгүй хийхэд хүргэдэг гэдгийг хатуу анхаарах хэрэгтэй байна. Эдийн засгийн ухаанд “рент хүүлэх” (rent seeking) гэдэг ойлголт байдаг. Энэ бол ерөнхийдөө хүмүүс үр ашиггүй үйл ажиллагаанд хүч, хөрөнгөө зарцуулахыг хэлж байгаа юм. Тухайлбал, шинэ үйлдвэрлэл, үйлчилгээнд хөрөнгөө оруулж байхын оронд авилга, хээл, хахуульд хөрөнгө мөнгө зарцуулах нь хөрөнгийн эх үүсвэрийг хамгийн үр ашиггүй хэлбэрээр зарцуулж байгаа хэрэг юм. Нийт эдийн засгийн хувьд аваад үзвэл энэ нь орлогын тэгш бус хуваарилалтыг улам хурцатгана гэсэн үг. Тиймээс энэхүү “рент хүүлэх” үйл ажиллагааг улс төрийн хүчнүүд анхааралдаа авч, зориг зүрх, тэвчээр гаргаж Монголбанкны үйл ажиллагааны хараат бус байдлыг дэмжих нь чухлаар тавигдаж байна.

Мөнгөний бодлогыг хараат бус болгож, үр нөлөөг сайжруулах нэг арга бол мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг жилээр гаргаж өгөхөөс гадна дунд болоод урт хугацаанд мөн гаргаж өгөх нь зүйтэй юм. Энэ замаар мөнгөний бодлогын залгамж халааг хангаж өгөхөөс гадна Монголбанкны нэг, хоёр жилийн үйл ажиллагаанд нь бус дунд хугацаанд хэр амжилттай ажиллав гэдэгт үнэлэлт дүгнэлт өгөх боломжийг бүрдүүлэх юм. Яг одоогийн тогтолцоогоор бол үндсэн чиглэлийг нь нэг жилээр тогтоож байгаа бөгөөд дунд хугацаандаа бодлогууд нь хэр уялдаатай байв гэдэг үнэлэлт дүгнэлт бага өгч байна. Бидний үзэж байгаагаар мөнгөний бодлогын гол зорилго нь дунд хугацаандаа үнийн өсөлтийг бага түвшинд барихад оршиж байх ёстой бөгөөд чухам энэ л хэмжүүрээр үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгөх ёстой юм.

Дээр өгүүлсэнчлэн, бодлогын амаргүй сонголтуудыг нэг мөр шийдэх алхамыг Монголбанк 2010 онд баримлах үндсэн чиглэлдээ оруулж өгсөн нь сайшаалтай. Тухайлбал, тус чиглэлийн 1.2-т “гадаад валютын нөөцийг хамгаална” гэж зааж өгсөн нь гадаад валютын захад хийх зохицуулалтыг хязгаарлажээ гэж ойлгогдож байна. Өөрөөр хэлбэл, гадаад валютын ханшыг чөлөөтэй хэлбэлзэх боломжтой болгож байна.

Банкны салбар

Тайлант оны дөрөвдүгээр улиралд банкны салбар нэлээд өрнөлтэй байлаа. Нийт банкны системд эргэлдэж буй хөрөнгө 0.2 их наяд төгрөгөөр өсч 4 их наяд төгрөгт хүрсэн хэдий ч банкуудын олгосон зээлийн өрийн үлдэгдэл өсөөгүйгээр үл барам чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 583.7 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт банкны системийг эрсдэлд оруулсаар байна. Хугацаа хэтэрсэн, чанаргүй зээл нийт зээлийн багцын 22 хувьтай тэнцүү байгаа нь маш өндөр үзүүлэлт юм.

Чанаргүй болоод хугацаа хэтэрсэн зээлийн хувь өсөх тусам банкууд үйл ажиллагааны эрсдэлээ бууруулах үүднээс шинээр зээл олгохгүй хөрөнгөө төв банкны үнэт цаас эсвэл гадаад валют худалдан авах замаар байршуулж байна. Нөгөө талаас банкууд ихээхэн хэмжээний алдагдлыг чанаргүй зээлээсээ үүрч байна. Тухайлбал, 2009 оны эцэст зээлийн эрсдлийн сан 327 тэрбум төгрөгт хүрсэн нь банкууд ийм хэмжээний алдагдал үндсэндээ үүрээд байгааг илэрхийлж байгаа юм.

2009 онд Анод, Зоос банкууд үйл ажиллагаагаа зогсоосон нь эдийн засагт томоохон цочрол өглөө. Банк, санхүүгийн салбарт хүндрэлүүд гарч эхэлсэнтэй холбоотойгоор төрөөс банкууд дахь иргэд, байгууллагын

харилцах, хадгаламжид баталгаа гаргаж өгсөн нь байдлыг намжаахад тус дэм үзүүлсэн. Үүнээс гадна Монголбанкнаас банкуудад шууд зээл олгох замаар төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг нь дэмжиж өгсөн. Бид өмнөх улирлын тайлангууддаа бодлогын эдгээр арга хэмжээний талаар дэлгэрэнгүй хэлэлцсэн билээ.

Тайлант оны дөрөвдүгээр улиралд Зоос банк үйл ажиллагаагаа зогсоож түүний оронд Төрийн банк нэртэй арилжааны банк байгуулсан. Зоос банкны харилцах, хадгаламжийг, нөгөө талаас хэвийн зээлүүдийг энэхүү Төрийн банкинд шилжүүлж нэмэлт хөрөнгийг Монголбанкнаас гарган байгуулсан. Хүндрэлд орсон банкийг иймэрхүү маягаар өөрчлөн зохион байгуулсан нь манай улсын хувьд анхны тохиолдол юм. Гэхдээ, эцсийн дүндээ банкуудын харилцах, хадгаламжид төрөөс баталгаа гаргасан тохиолдолд хүндрэлд орсон банкийг Анод шиг үйл ажиллагааг нь зогсоох уу, аль эсвэл Зоос шиг өөрчлөх үү гэдэг нь зарчмын хувьд ялгаа багатай. Жишээлбэл, Анодын хадгаламж эзэмшигчид хөрөнгөө бусад банканд хадгалуулсан бол Зоосынх Төрийн банкинд очсон. Нөгөө талаас, энэ хоёр банкинд хугацаа хэтэрсэн, найдваргүй зээлийн үлдэгдэл болох 240 тэрбум төгрөгийн алдагдлыг төрөөс хариуцахаар байгаа. Ийнхүү нийт системийн хувьд нь аваад үзвэл ялгаагүй л төр эцсийн хариулагыг үүрч байна.

Энд нэг зүйл тэмдэглэхэд банкуудын алдагдлыг байнга төрөөс хариуцаж ирсэн нь ёс суртахууны эрсдлийг (moral hazard) улам дэвэргэж байна гэдгийг бид дахин сануулж байна. Цаашид банк, санхүүгийн үйл ажиллагаанд тавьдаг хяналтыг улам сайжруулах, хариуцлагын тогтолцоог хэвшүүлэх зайлшгүй шаардлага урган гарч ирж байна. Бидний үзэж байгаагаар банкуудын үйл ажиллагааг хянах хяналтын тогтолцоог зах зээлийн механизмд ойртуулж өгөх бололцоо байна. Хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлж, хэвшүүлэх нь ёс суртахууны эрсдлийг багасгахаас гадна өнөөгийн банкны хяналтын тогтолцооны сул талыг давхар шийдэх боломжтой гэдгийг дахин сануулахад илүүдэхгүй биз ээ.



5. Монгол Улсын төрийн санхүү ба төсөв, сангийн бодлого

5.1. 2009 онд хэрэгжүүлсэн төсөв, сангийн бодлогын тойм

2009 оны хувьд төсөв, сангийн бодлогын гол зорилго нь ерөнхийдөө Засгийн газрын зарлагыг өсгөх замаар нийт эрэлтийг өсгөж, эдийн засгийн уналтаас сэргийлэхэд оршиж байлаа. 2008 оны сүүлийн улирал, 2009 оны эхний улиралд манай улсын эдийн засаг гадаад зах зээл дээр бий болсон сөрөг нөлөөлөлд огцом өртөж хямралт байдалд орсон. Үүнтэй холбоотойгоор Засгийн газрын орлого эрс буурсан, мөн өмнө хуримтлуулсан нөөц үндсэндээ байгаагүй нь хямралын үед төсөв, сангийн тэлэх бодлого явуулж бодит эдийн засгийн уналтаас сэргийлэх боломжийг хязгаарласан.

Ерөнхийдөө, эдийн засгийн хямралын үед төсөв, сангийн тэлэх бодлого явуулах замаар нийт эрэлтийг өсгөж улмаар бодит эдийн засагт өсөлт бий болгох аль эсвэл эдийн засгийн уналтыг бууруулах бодлогыг гадаад улс орны Засгийн газрууд түгээмэл баримталдаг. Жишээлбэл, санхүү, эдийн засгийн гүнзгий хямралтай тулаад байсан АНУ-ын засаг, захиргаа 2007 оны сүүлч, 2008 оны эхэн үед томоохон хэмжээний төсвийн тэлэлтийг бий болгох хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн. Эдийн засгийн хямралын үед хамгийн түрүүнд хүмүүсийн орлого буурч улмаар нийт эрэлтийг бууруулдаг. Тэгвэл энэ үед нь Засгийн газрын зарлагыг өсгөх нь нийт эрэлтийн бууралтыг сааруулах ба зарим тохиолдолд өсгөдөг. Нийт эрэлт өсөх үед үйлдвэрлэл, үйлчилгээний салбар бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ худалдах замаар үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжтой болдог. Жишээлбэл, эдийн засгийн хямралын үед зам, гүүр, байшин барилга барих, засварлах зэрэг дэд бүтцийн төрөл бүрийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх нь үйлдвэрлэлийн салбарыг дэмждэг. Гэтэл аливаа нэг үйлдвэрлэл явуулахын тулд заавал дагалдах бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэг болдог учраас эдийн засгийн бусад салбарыг ч идэвхжилд оруулдаг. Ийнхүү бодит эдийн засагт салбарууд нэг нэгэндээ нөлөөлөх замаар гинжин урвал явагдаж нийт үйлдвэрлэл, үйлчилгээг өсгөдөг байна.

Эдийн засагчид энэхүү нөлөөллийг төсөв, сангийн үржүүлэгч гэж нэрлэдэг. Тэгвэл энэхүү үржүүлэгч хэдтэй тэнцүү байдаг вэ гэдэг асуулт гарна. Өөрөөр хэлбэл, төсвийг нэг төгрөгөөр өсгөхөд нийт эрэлтийг хэдэн төгрөгөөр өсгөж болох вэ гэдэг асуудал гарч байна. Харамсалтай нь энэ асуултад хариулах амаргүй. Түүгээр ч үл барам энэхүү үржүүлэгч цаг хугацааны хувьд тогтворгүй байдаг нь харагддаг. Нэгэнт эдийн засагчид үржүүлэгчийн нөлөөлөл дээр ийнхүү нэгдсэн байр суурьтай болж чадахгүй байгаа учраас санал болгож буй бодлогын шийдлүүд нь өөр өөр байдаг. Жишээлбэл, нэрт эдийн засагч Р.Барро энэхүү үржүүлэгчийг АНУ-ын хувьд нэгээс бага, ойролцоогоор 0.8 байхад гайхах зүйлгүй гэж үзсэн.³⁴ Өөрөөр хэлбэл, Засгийн газрын төсвийг нэг төгрөгөөр өсгөхөд нийт эрэлт 0.8 төгрөгөөр өснө гэсэн үг. Тэгвэл АНУ-ын засаг захиргаанд ажиллаж буй одоогийн бодлого тодорхойлогчид үүнийг 1.5 хавьцаа гэж үзэж байх жишээтэй. Эндээс харахад үржүүлэгч бага гэж тооцвол их хэмжээний төсвийн тэлэлт хийх болно, харин үржүүлэгч өндөр гэж тооцвол харьцангуй бага хэмжээний тэлэлт шаардлагатай болох нь. Түүнээс гадна, энэхүү үржүүлэгч хөгжиж буй орнуудад бас өөр өөр байх үндэстэй гэж Илзецки нар³⁵ (2009) үзсэн. Тухайлбал, тогтмол валютын ханш зарладаг орнуудад үржүүлэгч 1.5 хавьд байдаг байхад чөлөөтэй хөвөгч ханштай орнуудад 0 байдаг гэж тооцсон.

Ийнхүү төсөв, сангийн үржүүлэгчийн талаар янз бүрийн үзэл баримтлал байдаг учраас төсвийн тэлэлтийг зөв, буруу гэж дүгнэхэд хүндрэлтэй байдаг. Цаашилбал, нэгэнт хэмжүүр нь ялгаатай учир аливаа нэг бодлогыг амжилттай болсон эсэх талаар ч нэгдмэл ойлголт байдаггүй. АНУ-ын Засгийн газар эдийн засгийн хямралтай тэмцэх зорилгоор 1.5 их наяд ам. доллартай тэнцэхүйц төсвийн тэлэлт хийх хөтөлбөр боловсруулсан. Энэ нь тухайн орны ДНБ-ий 10 орчим хувьтай тэнцэхүйц томоохон хөтөлбөр юм. Одоогийн байдлаар үүнээс 750 тэрбумыг нь Засгийн газрын зарлагыг өсгөх, банкуудыг хөрөнгийн эх үүсвэрээр хангах зэрэг арга хэмжээнүүдэд зарцуулаад байна. Зарим эдийн засагчид үүнийг хэт бага тэлэлт гэж үзэж байхад зарим нэг нь энэ хэмжээний тэлэлт болж байна гэж үздэг.

Хэт бага байна гэж үзэж байгаа эдийн засагчид эдийн засгийн өсөлт бий болоход нэлээд хугацаа зарцуулна гэж таамаглаж байгаа. Жишээлбэл, эдийн засагч Ж.Штиглиц ийм байр суурьтай байгаа.³⁶ Харин, АНУ-ын бодлого боловсруулагчид одоогоор хийгдээд байгаа төсвийн тэлэлтийг үр дүнд хүрч байгаа гэж үзсэн. Гэтэл Р.Барро Засгийн газрын зарлагыг өсгөхдөө гол нь биш, харин татварыг бууруулах замаар хүмүүсийн үйлдвэрлэх, шинэ бүтээгдэхүүн гаргах, хөрөнгө оруулалт хийх сонирхлыг бий болгох зэргээр хямралтай тэмцэх нь зүйтэй гэж сануулсан. Ийнхүү, төсвийн бодлогын талаар эдийн засагчид, бодлого боловсруулагчдын дунд маш олон үзэл баримтлал байдаг. Чухам аль нь зөв юм бэ гэдэг нь одоогоор тодорхойгүй. Сонирхолтой нь энэ асуудал 1929 оны Их хямралын жилүүдээс хойш эдийн засагчдыг үндсэндээ хоёр хэсэгт хуваахад хүргэсэн бөгөөд эдийн засагт гүйцэтгэх Засгийн газрын үүргийн талаарх хоёр томоохон үзэл баримтлалын ялгааны нэг илрэл нь болдог. Эдийн засгийн хямралын үед төсвийн тэлэлт хийх нь зүйтэй гэсэн байр суурьтай эдийн засагчдыг Кейнсийн тал, харин татварын

34 "Government Spending Is No Free Lunch", Wall Street Journal, January 22, 2009.

35 Ilzetzki, Ethan, Enrique G. Mendoza and Carlos A.Vegh, "How big are fiscal multipliers?", CEPR Policy Insight No.39, October 2009

36 "Skepticism for Obama's Fiscal Policy", New York Times, January 18, 2010.

хөнгөлөлт эдлүүлэх замаар тэмцэх учиртай гэж үздэг эдийн засагчдыг сонгодог үзэл баримтлалтай гэж нэрлэх нь түгээмэл. Гэвч, энэ удаагийн хямрал харамсалтай нь аль нэг үзэл баримтлалын ялалт эсвэл ялагдлыг тодорхойлохгүй нь бололтой.

Манай улсын хувьд төсөв, сангийн үржүүлэгчийг тооцсон судалгаа шинжилгээ хомс байна. Сүүлийн жилүүдийн тоон өгөгдлийг харахад энэхүү үржүүлэгчийг тодорхойлогч үзүүлэлтүүд болох ахиу хэрэглэх хандлага, орлогын татварын хувь хэмжээ болоод ахиу импортын хэрэглээний хандлага зэрэг үзүүлэлт тогтворгүй байгаа нь тооцоололтыг хүндрүүлж байна. Сүүлийн жилүүдийн тоон мэдээллийг ашиглан урьдчилсан байдлаар тооцоолоход уг үржүүлэгч 0.92-тэй тэнцүү байх магадлалтай байна.³⁷ Өөрөөр хэлбэл, төсвийг нэг төгрөгөөр өсгөхөд нийт эрэлт 92 мөнгөөр өснө гэсэн үг. Хэдийгээр энэхүү тооцоололт ихээхэн бүдүүн бараг ч бид ерөнхий чиг хандлагыг харуулж чадаж байна гэж үзлээ. Үнэхээр ч сүүлийн жилүүдэд Засгийн газрын төсвийн хэмжээ ихээхэн өссөн бөгөөд ДНБ ч нэрлэсэн дүнгээрээ бүр ихээр өссөн. 2004-2008 оны хооронд Засгийн газрын нийт зарлага 3.2 дахин өссөн байхад ДНБ 2.8 дахин өссөн байна. Ийнхүү Засгийн газрын зарлагын өсөлт нь нийт эрэлтийг өсгөх замаар ДНБ-ийг өсгөсөн дүр зураг харагдаж байгаа ч бид энэхүү өсөлтийг шууд утгаар нь хүлээж авч болохгүй юм. Тухайлбал, Засгийн газрын зарлагыг байнга өсгөөд байх нь ДНБ-ий өсөлтийг байнга авчирна гэсэн үг биш юм. Учир нь Засгийн газрын зарлагын тэлэлтээр бий болсон нийт эрэлтийн өсөлт үнийн өсөлтийг давхар бий болгоно. Ялангуяа, эдийн засгийн өсөлттэй он жилүүдэд огцом үнийн өсөлтийг бий болгодгийг сүүлийн жилүүдийн үйл явц харуулсан. Тодруулбал, зөвхөн сүүлийн гурван жилд хэрэглээний үнэ 50 хувиар өссөн нь төсвийн тэлэлттэй холбоотой.

Эдийн засгийн хямралын үед төсөв, сангийн бодлогын тэлэлт хийх нь хямралын гол сөрөг үр дагавар болох бодит үйлдвэрлэлийн бууралт, ажилгүйдэлтэй тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг гэж дээр дурдсан. Тэгвэл энэ удаагийн хямралын үед манай Засгийн газрын баримталсан төсөв, сангийн бодлого хямралтай үр ашигтайгаар тэмцэж чадав уу гэдэг асуудал гарч байна. Хямралын эхэн үед Засгийн газраас 1.5 их наяд төгрөгийн хөтөлбөр боловсруулж бидний дээр хэлэлцсэн төсвийн огцом тэлэлт хийх замаар хямралыг давахыг зорьсон. Гэвч ийм хэмжээний хөрөнгө Засгийн газарт байгаагүйгээр үл барам өнөөгийн хямралын үед гадаад зах зээл дээрээс ийм хэмжээний хөрөнгийг зээлэх боломжгүй нь тодорхой болсон. Ийнхүү улс орнууд төсвийн тэлэлт хийх замаар хямралтай тэмцэж байсан бол манай Засгийн газарт тэлэлт хийх орон зай байхгүй байжээ. Тодруулбал, “Монгол Улсыг хөгжүүлэх сан”-д төвлөрсөн хөрөнгө чухам иймэрхүү хямралын үед хэрэглэгдэх зориулалтаар зохион байгуулагдсан хэдий ч энэ сангийн хөрөнгийг Засгийн газрын бусад зарлагатай адилаар зарцуулсан учраас хямралтай тэмцэх хөрөнгийн эх үүсвэргүй болсон.

Ийнхүү, өмнөх жилүүдэд явж ирсэн төсөв, сангийн хэт тэлэх бодлого үүдэн “Монгол Улсыг хөгжүүлэх сан”-ийн хөрөнгийн буруу зарцуулалт улс орныг хямралын нөлөөлөлд ихээхэн өртөмтгий болгосон байна. Тийм ч учраас Засгийн газар ОУВС-аас зээл, тусламж хүсч, тогтворжилтын хөтөлбөр

37 ОУВС-ийн тоон мэдээг ашиглаж тооцоход сүүлийн жилүүдийн ахиу хэрэглээний хадлага дунджаар 0.53, ахиу импортын хэрэглээ дунджаар 0.56 –тай тэнцүү байна гэж тооцлоо. Орлогын албан татварын хувийг 10%-тай тэнцүү гэж үзлээ.

хэрэгжүүлэхээс өөр аргагүй байдалд орсон. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын алдагдлыг тодорхой түвшинд барьж байхаар тохирсон нь үндсэндээ Засгийн газрын зарлагыг төсвийн орлоготой уялдуулан тодорхойлж байхаар зохицуулсан. Өөрөөр хэлбэл, төсвийн орлого өссөн нөхцөлд л төсвийн тэлэлт хийх боломжтой болсон гэсэн үг.

Эдийн засгийн хямрал эрчээ авч эхэлсэн 2008 оны дөрөвдүгээр улиралд Засгийн газрын орлого өмнөх оныхтойгоо харьцуулахад 87 тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч бүтэн жилийнхээ дүнгээр 305 тэрбум төгрөгөөр өссөн байна. Тухайн үед манай гол экспортын бүтээгдэхүүн болох зэсийн дэлхийн зах зээл дээрх үнэ буурсан хэдий ч төсөвт үзүүлэх нөлөөлөл нь биелэлээ арай олоогүй байсан. Харин, 2009 оны эхний хагас жилд төсвийн орлогод нэлээд нөлөөлсөн талаар бид өмнөх улирлын тайлангуудад дэлгэрэнгүй хэлэлцсэн.

Зэсийн үнэ 2009 оны хоёрдугаар хагаст өссөн нь төсвийн орлогыг өсгөхөд дорвитойхон түлхэц өгчээ. Тайлант оны хоёрдугаар хагаст Засгийн газрын орлого 1.1 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оныхтой дүйцэхүйц бөгөөд оны эцэст 2 их наяд төгрөг болжээ. Энэ нь өмнөх оны эцэстэй харьцуулахад 163 тэрбум төгрөгөөр буюу 7 хувиар буурсан нь хямралын жил гэхэд харьцангуй багаар буурчээ гэсэн үг. 2009 оны төсвийн орлогын төлөвлөгөө 2 их наяд төгрөг байсан учраас төсвийн гүйцэтгэл 100 хувьтай гарчээ.

Засгийн газрын орлогыг бүтцээр нь задлаад үзвэл өмнөх оныхтой харьцуулахад ерөнхийдөө үзүүлэлт тус бүр нэг түвшинд байжээ. Харин, зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татвар буюу гэнэтийн ашгийн татвар тайлант онд 198 тэрбум төгрөгөөр буурч 186 тэрбум төгрөгт хүрсэн нь үндсэндээ Засгийн газрын нийт орлогын бууралтыг тайлбарлаж байна. Гэнэтийн ашгийн татварын орлого тайлант онд нэлээд хэлбэлзэлтэй байсан хэдий ч дэлхийн зах зээл дээрх алт болоод зэсийн үнэ өссөнтэй холбоотойгоор уг татварын орлого өсч нийт төсвийн орлогын 9.3 хувийг бүрдүүлсэн. Сонирхолтой нь өмнөх оны дөрөвдүгээр улиралд нэгдсэн төсвийн орлого 537 тэрбум төгрөг байсан бол 2009 оны хувьд 662 тэрбум төгрөг болж огцом өссөн. Эндээс харахад санхүү, эдийн засгийн хямралын Засгийн газрын орлогод нөлөөлөх сөрөг нөлөөлөл тайлант оны эхний хагастай харьцуулахад ихээхэн суларсан байна.

Харамсалтай нь энэхүү шинж тэмдэг бол манай улс эдийн засгийн хямралыг Засгийн газар амжилттай даван туулж байна гэсэн үг огтхон ч биш юм. Харин ч эсрэгээрээ, манай улсын төсөв, сангийн бодлогод бүтцийн эсвэл тогтолцооны шинжтэй томоохон сул тал байгааг энэ удаагийн хямрал тодруунаар харууллаа. Тухайлбал, манай Засгийн газрын орлого үндсэндээ зарлагаа тодорхойлдог бөгөөд эдийн засгийн мөчлөгөөс хэт хараат байгаа нь ирээдүйд бий болох эдийн засгийн хямралд манай улс өртөмтгий хэвээр байх нь гэдгийг нотолж байна. Цаашилбал, төсөв, сангийн бодлогыг эдийн засгийн мөчлөг сөрсөн бодлого болгохоос нааш эдийн засгийн хямралтай тэмцэх орон зай Засгийн газарт үүсэхгүй юм байна гэдгийг энэ удаагийн хямрал бодлого боловсруулагчдад ухааруулсан байх гэж найдаж байна.

Засгийн газрын зарлага тайлант онд 2.3 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оныхтой харьцуулахад 140 тэрбум төгрөгөөр буюу 5.9 хувиар буурчээ. 2009 оны улсын нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө 2.4 их наяд төгрөг байсан нь төсвийн зарлага 97 хувийн гүйцэтгэлтэй байжээ гэсэн үг. Дөрөвдүгээр улирлын хувьд Засгийн газрын нийт зарлага 657 тэрбум төгрөг байсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 183 тэрбум төгрөгөөр буурсан.

Ийнхүү, бүтэн жилийн хувьд аваад үзвэл Засгийн газрын зарлага үндсэндээ төсөвлөгдсөний дагуу зарцуулагдсан харагдаж байна. Зарлагыг бүтцээр нь задлаад үзэхэд үндсэндээ өмнөх оны бүтэцтэй ижил байна. Өөрөөр хэлбэл, урсгал зарлага нийт зарлагын 70 гаруй хувь, хөрөнгийн зарлага 20 гаруй хувийг эзэлж байгаа нь хэвээр хадгалагджээ. 2009 онд төсвийн алдагдал 328.6 тэрбум төгрөгт хүрсэн нь төлөвлөгдсөн хэмжээ болох 364 тэрбум төгрөгөөс бага байна. Эндээс харахад төсөв, сангийн бодлого үндсэндээ тавьсан тоон зорилтуудаа биелүүлжээ.


Санхүү, эдийн засгийн хямралтай холбоотойгоор Засгийн газрын орлого оны эхний хагаст нэлээд доголдож ирсэн нь сангийн бодлогоор дамжуулан эдийн засгийг тогтворжуулах бодлого баримтлах боломжгүй болгосон. Тийм ч учраас 2009 онд төсвийн тодотголыг гурван удаа хийсэн бөгөөд хамгийн сүүлчийн тодотголыг 6 дугаар сард хийсэн. Тухайн үед манай Засгийн газар Олон Улсын Валютын Сан-тай Стэнд-бай хөтөлбөр тохирсон учраас төсвийн алдагдалд тоон зорилт тавьсан нь ийнхүү хэрэгжжээ. Төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувийн жин макро эдийн засгийн чухал үзүүлэлт болдог. Зураг 5.1-т сүүлийн 16 жилийн ДНБ-д эзлэх төсвийн алдагдлын хувийн жинг үзүүлээ. Сүүлийн 2 жилд эдийн засгийн хямралтай холбоотойгоор Засгийн газрын төсөв алдагдалд орсон нь энэхүү зургаас харагдаж байна. Харин, энэхүү алдагдал 90-ээд оны сүүлээр өнөөгийнхөөс ч өндөр байсан нь мөн харагдаж байна.

5.2. 2010 оны төсөв ба сангийн бодлого

2010 оны төсвийн тойм

2009 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр УИХ 2010 оны төсвийг баталсан. Энэхүү төсвөөр нийт орлого ба тусламжийн дүн 2.43 их наяд төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн нь 2.79 их наяд төгрөг, төсвийн алдагдал нь 358.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 5 хувьтай тэнцүү байхаар заасан байна (Хүснэгт 5.1).

Зураг 5.1. Төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувийн жин



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, ОУВС

	Нийт дүн тэрбум төг.	ДНБ-д эзлэх хувийн жин, %
Нийт орлого ба тусламжийн дүн	2,426.8	33.8
- Татварын орлого	2,083.5	29.1
- Татварын бус орлого	319.7	4.5
- Тусламжийн орлого	22.0	0.3
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,785.4	38.8
- Урсгал зарлага	2,174.6	30.3
• Бараа үйлчилгээ (цалинг оруулан)	1,054.7	14.7
• Татаас, урсгал шилжүүлэг	1,077.0	15.0
- Хөрөнгө оруулалт	518.4	7.2
- Цэвэр зээл	92.5	1.3
Төсвийн тэнцэл	-358.6	-5.0
Алдагдлыг санхүүжүүлэх	358.6	5.0
- Засгийн газрын бонд	130.8	1.8
- Зээл	159.0	2.2
- Бусад	68.8	1.0
ДНБ	7,171.4	
Зэсийн үнэ, ам.доллар	5,800	

Эх сурвалж: Сангийн яам 2010

2010 оны батлагдсан төсвийн нийт орлого нь 2009 оны хавар УИХ-аар баталсан Төсвийн хүрээний мэдэгдлээс 265 тэрбум төгрөгөөр, Засгийн газраас оруулсан төсвийн төслөөс даруй 121 тэрбум төгрөгөөр буюу бараг 5 хувиар илүү байна. Харин төсвийн нийт зарлагыг Төсвийн хүрээний мэдэгдлээс 333 тэрбум төгрөг, Засгийн газрын төсвийн төслөөс 121 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан төсөв боллоо. ДНБ-ий хувиар авч үзвэл УИХ-аар өмнө нь өөрөө батлагдсан Төсвийн хүрээний мэдэгдэл нийт зарлагыг ДНБ-ий 35.1 хувьд, Засгийн газрын төсвийн төсөл нь 37.2 хувьд тус тус төсөвлөж байсан бол УИХ-аар батлагдсан төсвийн нийт зарлага ДНБ-ий 38.8 хувьтай тэнцүү байхаар батлагдсан байна.

УИХ-аас баталсан төсөв яагаад ийнхүү өндөр гарав? УИХ хаанаас ийм хэмжээний орлогын эх үүсвэр олов? Энэ нь зэсийн үнэтэй холбоотой. Засгийн газрын хийсэн тооцоогоор зэсийн үнэ 2010 онд нэг тонн нь 5184 ам.доллар байхаар төсөөлж байж. Энэ нь ОУВС, Deutsche Bank AG, National Australia Bank, JP Morgan Chase зэрэг олон улсын туршлагатай байгууллагуудын үнийн төсөөллийн дундаж үзүүлэлт юм. Гэтэл УИХ зэсийн үнэ 5800 ам.доллар байна гэж “таамаглаж” байна. Ямар тооцоо, үндэслэлтэй вэ гэдэг нь тодорхойгүй боловч зэсийн өнөөгийн үнийг баримжаалсан болов уу. Зэсийн үнэ болон бусад бага зэрэг өөрчлөлтийг хийхэд төсөвт 121 тэрбум төгрөгний “нэмэлт” орлого бий болж байгаа тул УИХ-аас төсвийн нийт зарлагыг яг ийм хэмжээгээр нэмж баталсан байна. Төсвийн алдагдал нийт Засгийн газрын төсөвлөсөн хэмжээнд буюу 358 тэрбум төгрөг байхаар батлагджээ. Гэхдээ энэ нь Төсвийн хүрээний мэдэгдэлд батлагдсан 290 тэрбум төгрөгөөс нэлээд өндөр үзүүлэлт юм.

Дээрх тоонууд юуг хэлж байна вэ? Юуны өмнө Төсвийн хүрээний мэдэгдэл нь хэдийгээр УИХ-аас баталдаг улсын дунд хугацааны хөгжил болон ирэх жилийн төсвийн ерөнхий хүрээг харуулдаг чухал баримт бичиг гэгдэх боловч үнэн чанартаа ач холбогдол нь улам багассаар байна. Энэ нь нэг талаас

дэлхийн эдийн засгийн төлөв байдал болон үүн дээр суурилоод манай эдийн засгийн байдал тогтвортой бус, үүнээс үүдээд энэ талаарх Засгийн газрын төсөөлөл сул, таамаглал буруу байдагтай холбоотой юм. Нөгөө талаас, бодлого боловсруулагчид, үүнд улстөрчид болон төрийн албаныхны төсвийн талаарх байр суурь нь хувьсамтгай, нэгэнт гаргасан шийдвэрийг нөхцөл байдалд тохируулан байнга өөрчилдөг, төсвийн тодорхой зарчимгүй явж байгааг илэрхийлж байна.

Цаашилбал, төсвийн талаарх УИХ болон Засгийн газрын эрх мэдэл, хүчний харьцаа УИХ-д давуутайгаар өөрчлөгдөж байгаа нь ажиглагдаж байна. Энэ нь юуны өмнө Засгийн газраас оруулсан төсвийн төсөл, УИХ-аар батлагдан гарч буй тухайн жилийн төсвийн тухай хуулин дахь орлого, зарлагын зөрүүгээр идэрхийлэгдэж байна. Энэ зөрүү нь сүүлийн жилүүдэд улам бүр нэмэгдэх хандлагатай байгааг дурдах хэрэгтэй. Ялангуяа орлогыг өсгөх, тэр дундаа зэс болон бусад эрдэс баялгийн үнийн талаар үндэслэл тооцоогүй таамаглал дэвшүүлж, орлогоо өсгөх хандлага даамжирч байна.

Гэхдээ энэ нь Монгол Улсын хуулинд харш зүйл биш юм. Үндсэн хууль болон бусад хуулинд заагдсан бүрэн эрхээ УИХ хэрэгжүүлж байгаа хэрэг юм. Бусад улс орны хувьд төсөвтэй холбоотой парламентын бүрэн эрх нь харьцангуй хязгаарагдмал байдаг. Жишээ нь парламент нь Засгийн газраас оруулсан төсвийн орлогыг хөндөх эрхгүй байх, хэрэв ямар нэгэн зарлагаа нэмэгдүүлбэ гэвэл зөвхөн өөр төрлийн зарлагыг хасч байж нэмэгдүүлэх эрхтэй байх нь түгээмэл байна. Мөн төсвийн алдагдлыг нэмэгдүүлэхгүй байх ерөнхий зарчим үйлчлэх нь олонтаа. Ингэх нь яагаад чухал вэ? Парламентийн бүрэн эрхэд халдаж байгаа хэрэг биш үү?

Асуултын учир нь хэн хэний өмнө ямар хариуцлага хүлээж байгаад оршино. Парламентийн гишүүд сонгогч иргэдийн өмнө хариуцлага хүлээж, тэдгээрийн ашиг сонирхлыг бодлого, тэр дотроо төсөвт тусгаж байх үүрэгтэй. Энэ нь маш чухал бөгөөд ардчилсан ёсонд зайлшгүй байх ёстой зарчим юм. Гэтэл үүний зэрэгцээгээр макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, макро тэнцвэрийг хангаж байх нь улс орны дунд болон урт хугацааны өсөлт, хөгжилд маш чухал юм. Энэ нь иргэдийн эрх ашгийг урт хугацаандаа хамгаалах тухай асуудал юм. Энэ асуудлыг хариуцдаг гол субъект нь Засгийн газар байдаг. УИХ болон Засгийн газрын энэ хоёр үүргийн аль аль нь иргэдийн сайн сайхан байдлын төлөө боловч цаг хугацааны хувьд зөрчилдөх нь зүйн хэрэг юм. Засгийн газар нь, тэр дундаа яам тамгын газар болон мэргэжлийн технократуудын үүрэг дунд болон урт хугацааны эрх ашгийг хамгаалах байдаг бол улстөрчид буюу УИХ нь сонгогдсон хугацаандаа амлалтаа биелүүлэх үүрэгтэй. Парламентийн гишүүдийн хувьд амлалтаа биелүүлэх нь дахин сонгогдох магадлалыг нэмэгдүүлэх учир технократуудын зорилготой зөрчилдөх нь олонтаа байдаг.

Ийнхүү зөрчлийг шийдвэрлэх арга зам нь зарим оронд парламентийн эрх мэдлийг хуулиараа хязгаарлах, зарим улс оронд “бичигдээгүй хууль” хэлбэрээр үйлчилдэг тохиролцоонд суурилдаг байна. Өөрөөр хэлбэл парламент нь өөрийнхөө төсөвтэй холбоотой эрх мэдлийг хязгаарлаж байна гэсэн үг юм. Яагаад ингэж байна вэ гэхээр улс орны дунд болон урт хугацааны тогтвортой байдал нь сонгогч олны эрх ашигт богино хугацаанд мөнгө тараах зэрэг бодлогоос илүүтэйгээр нийцдэг гэж үздэгтэй холбоотой юм.

Манай улсын хувьд УИХ-ын төсвийн эрх мэдлийг ямар нэгэн байдлаар хязгаарласан хууль байхгүй байна. Төсөвт Ерөнхийлөгч хориг тавих эрхтэй хэдий ч түүнийг хүлээж авахгүй байх эрх нь мөн л УИХ-д байна. Төсвийн зарлагыг хязгаарлах талаар “бичигдээгүй хууль” шиг үйлчилдэг зарчим бүр алга. Төсөв нь улс төрийн намуудын зарлагаа өсгөхийн төлөө уралддаг үндсэн талбар болж хувираад байна. Өндөр өсөлттэй байсан он жилүүд энэ хандлагыг баталгаажуулж, энэ удаагийн хямрал энэ суурь доголдлыг илрүүлж өглөө.

Дараагийн нэг ажиглагдаж байгаа зүйл бол төсөв, сангийн бодлого эдийн засгийг тогтворжуулах үүрэг бүхий макро эдийн засгийн бодлогын гол арга хэрэгслийн үүргээ биелүүлж чадахгүй байна. Бид цуврал тайлангууддаа сангийн бодлого нь бизнесийн мөчлөг дагасан шинж чанартай байна гэж удаа дараа тэмдэглэсэн. Энэ нь төсвийн зарлагаас тод харагдаж байна. Татварын орлого болон төсвийн зарлага нь сангийн тэлэх эсвэл хумих бодлого хэрэгжиж байгааг тодорхойлдог. Манай улсын хувьд 2006 онд татварын шинэчлэл хийж, татварын дарамтыг бууруулсан нь нөгөө л мөчлөг дагасан бодлогын нэг тод ирлэл байсан. Хямрал нүүрлэхэд татвар нэгэнт бага учир үргэлжлүүлэн бууруулах боломж байгаагүйгээс зарлагаараа дамжуулан бодлого хэрэгжүүлэхээс өөр арга байсангүй. Гэтэл зарлага хэрхэн тодорхойлогдож байна вэ гэхээр энд онцгой бодлого гээд байх юм алга. Зарлагыг тодорхойлох үндсэн зарчим нь тухайн жилд олсон орлогоо бүрэн хэрэглээд, төсвийн алдагдлыг ДНБ-ий тодорхой хувиас илүү гаргахгүй байх гэсэн ганц л зарчим үйлчилж байна. 2010 оны хувьд ДНБ-ий 5 хувиар алдагдал тогтоогдсон. Зарлагыг ийнхүү орлогоороо тодорхойлох нь макро бодлого огт байхгүй байгаагийн илрэл юм. Иймээс манай улсын төсөв нь эдийн засгийг тогтворжуулах бодлогын арга хэрэгсэл гэхээсээ илүү улстөрчдийн анхнаасаа тооцоогүй, хариуцлагагүй өгсөн амлалтыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл болоод байна.

Макро тогтворжилттой холбоотойгоор нэг асуулт гарч ирж байна. Төсөв алдагдалтайгаар батлагдсан нь хэр оновчтой вэ? Үүнийг шүүмжлэх улстөрчид болон иргэд байдаг. Төсвийн алдагдлыг *бүтцийн ба эдийн засгийн мөчлөгийн* гэж ангилдаг. Бизнесийн мөчлөгийн доод цэг болох хямралын үед татварын орлого бага байдаг, нөгөө талаас тэтгэвэр тэтгэмж зэрэг зарлага өндөр байдаг тул төсөв алдагдалтай байх нь зүй ёсны хэрэг юм. Харин эдийн засгийн өндөр өсөлтийн үед орлого ихэсч, зарлага багасдаг учир төсөв илүүдэлтэй болж, хуримтлал хийгдэх ёстой юм. Хямралын үед төсвийн санхүүжилтийн дутууг зээл авах зэргээр нөхдөг бөгөөд энэ алдагдлыг мөчлөгийн алдагдал гэнэ. Төсвийн мөчлөгийн алдагдал нь эдийн засгийн сэргэлтийн үеийн төсвийн илүүдлээр нөхөгдөх ёстой.

Төсвийн бүтцийн алдагдал нь бизнесийн мөчлөгийн үе шатыг үл харгалзан байдаг алдагдал юм. Энэ алдагдлын шалтгаан нь эдийн засгийн ерөнхий байдал бус харин төсвийн зарлага нь орлогоосоо тогтмол өндөр байх нөхцөл юм. Төсвийн бүтцийн алдагдал өндөр байх бөгөөд энэ нь урт хугацаанд үргэлжилбэл засгийн газрын хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийг өнөөгийн татварын тогтолцоогоор санхүүжүүлэх боломжгүй гэдгийг харуулж байна гэсэн үг юм. Энэ алдагдлыг арилгахын тулд эсвэл татвараа нэмэх, эсвэл засгийн газрын хөтөлбөрүүдийг эргэн харж, зарлагаа багасгах, эсвэл энэ хоёр аргыг хослуулан хэрэглэх шаардлага зайлшгүй тулгарна.

Аливаа улсын тухайн жилийн төсвийн нийт алдагдал нь бүтцийн болон мөчлөгийн алдагдлын нийлбэрээр тогтоогдоно. Манай улсын төсвийн тэнцлийн сүүлийн хэдэн жилийн үзүүлэлтийг харахад 2005-2007 онд төсөв бага зэрэг илүүдэлтэй, харин 2008-2009 онд төсөв алдагдалтай гарсан байна.

Төсвийн алдагдлыг засгийн газрын бондоор санхүүжүүлэх нь санхүүгийн зах зээл дээр хүүгийн түвшинг нэлэнхүйд нь нэмэх хандлагыг бий болгодог. Учир нь засгийн газрын гаргаж буй бонд нь зээлийн эрэлтийг нэмэгдүүлж, улмаар зээлийн хүүг өсгөнө. Ингэснээр хувийн секторын зээлэх боломж хумигдаж, эдийн засагчдын нэрлэдгээр “шахан гаргах” (crowding out) үзэгдэл бий болдог сөрөг талтай. Эдийн засгийг дэмжих гэсэн сангийн тэлэх бодлого нь ийнхүү эргээд хөрөнгө оруулалтыг бууруулж, өсөлтөд сөргөөр нөлөөлөх боломж бий.

2003 онд Засгийн газрын зээлийг багасгаж ихээхэн бонд гаргасан, мөн өмч хувьчлалын орлогоор алдагдлыг санхүүжүүлж байсан бол 2008 оны алдагдлыг харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлтөөр санхүүжүүлсэн байна. 2009 оны төсвийн алдагдлыг үндсэндээ гадаад эх үүсвэрээр санхүүжүүлсэн. Үүнд олон улсын санхүүгийн байгууллагуудас олгосон хөтөлбөрийн зээл болон хандивлагч орнуудын зээл болон буцалтгүй тусламжаар санхүүжүүлсэн. 2010 оны хувьд төсвийн алдагдлыг “Монгол Улсыг хөгжүүлэх сан”-гийн үлдэгдлийг төсөвт шилжүүлэх, урт хугацаатай бонд гаргах болон гадаад эх үүсвэрээс төслийн зээл авах замаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Хямралыг бүрэн даван туулаагүй, эдийн засаг эмзэг хэвээр байгаа энэ нөхцөлд төсвийг тодорхой хэмжээний (хэт өндөр бус) алдагдалтай байлгаж, алдагдлыг гадны эх үүсвэрээс илүүтэйгээр санхүүжүүлэх нь энэ оны хувьд чухал хэвээр байна.

2010 оны төсөвтэй холбоотой нэг чухал үйл явдал бол 2009 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр “Монгол Улсын Хүний хөгжил сангийн тухай” хуулийг УИХ-аас батлан гаргасан явдал юм. Энэ хуулийн зорилт нь “ашигт малтмал, уул уурхайн салбарын орлогоос хуримтлал үүсгэж, тогтвортой өсөн нэмэгдэх байнгын нөөц бүрдүүлэн иргэддээ тэгш хүртээх зорилгоор хүний хөгжил сан байгуулах, түүнийг бүрдүүлэх, сангийн хөрөнгийг удирдах, зарцуулах, гүйцэтгэлийг нь тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад” оршино гэж заасан байна.

2010 оны хувь сангийн нийт орлогыг дараах эх үүсвэрээр бүрдүүлэхээр хуулинд заасан байна. Үүнд: (i) хувьцааны ногдол ашгаас 39.9 тэрбум төгрөг; (ii) ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс 94 тэрбум төгрөг, (iii) урьдчилгаа мөнгө, зээлээр 212.7 тэрбум төгрөг. Нийтдээ “Хүний хөгжил сан”-д 346.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 5.9 хувьтай тэнцүү орлого төвлөрүүлэхээр төсөвлөсөн байна. Энэхүү хөрөнгийн 10.9 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөрт, бэлэн мөнгөөр 324 тэрбум төгрөг, 11.8 тэрбум төгрөгийг эрсдлийн нөөц бүрдүүлэхэд зарцуулахаар хуулинд заасан байна.

Хишиг, хувь хүртээхдээ тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөр; орон сууц худалдаж авсны төлбөр; бэлэн мөнгө; эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний төлбөрт зарцуулах боломжтой гэж хуулинд заасан байна. 2010 оны хувьд 324 тэрбум төгрөгийг Монгол Улсын бүх иргэдэд бэлэн мөнгөөр тэгш хуваарилах зарчмыг баримталж байна. Энэ сан нь өмнө нь үйл ажиллагаа явуулж байсан “Монгол Улсыг хөгжүүлэх сан”-гийн

оронд гарч ирсэн бөгөөд хуучин сан нь үгүй болсонтой холбоотой хүүхдийн мөнгө, шинэ гэр бүлийн мөнгө зэрэг хөтөлбөрүүд дагаад цуцлагдсан нь хавтгайрсан халамжийг өөрчлөх чиглэл рүү явах гэж байгаа гэсэн хүлээлтийг бий болгосон ч 2010 оны хувьд энэ хандлага огт ажиглагдахгүйгээр үл барам, харин ч халамжийг бүх иргэдэд тэгш хуваарилах зарчим үйлчилж байгаа тул ухарсан арга хэмжээ боллоо гэж үзэж байна. Энэ талаар бид дараагийн хэсэгт илүү дэлгэрэнгүй авч үзнэ.

Дүгнэж хэлэхэд, 2010 онд сангийн тэлэх бодлого үндсэндээ үргэлжлэх нь. Эдийн засаг хямралаас гаран, тогтворжих энэ хугацаанд сангийн тэлэлт нь илүү оновчтой бодлого гэдэг нь тойдорхой юм. Дэлхийн ихэнх улс орон 2010 онд тэлэлтийг үргэлжлүүлэн хийж эдийн засгаа дэмжих бодлогыг хэрэгжүүлэхээр байна. 2010 оны төсөв хэлэлцэж батлагдах үйл явц манай улсын төсвийн тогтолцооны сул талыг тодруулж байна. 2010 оны төсөв хуучин зарчмаараа батлагдлаа. Төсвийн мөчлөг дагасан бодлого үргэлжилж байгаа бөгөөд улс төрийн нөлөө ихсэхийн хэрээр төсвийн тэнцвэртэй байх, макро эдийн засгийн тогтворжилтыг бий болгох, орлого багатай ядуу иргэдээ дэмжих зэрэг суурь зарчмууд улам бүр алдагдаж байна.

Монгол Улсын төсвийн цаашдын төлөв ба эрх зүйн орчин

Ашигт малтмалын томоохон ордууд эргэлтэд орох хүлээлтийн улмаас манай улсын төсвийн дунд хугацааны төлөв эерэг байгаа. 2010 онд төсвийн томоохон хүндрэл гарахгүй гэж хүлээгдэж байна. Цаг уурын байдал эрс муудаж, өвөлжилт ихэнх нутгаар хүндэрсэнтэй холбоотой богино хугацаанд төсвийн дарамт нэмэгдэх магадлалтай байгааг энд дурдах нь зүйтэй.

2009 оны 8 дугаар сарын 25-ны өдөр УИХ-аас баталсан “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай” хуулийн дагуу энэхүү хууль хүчингүй болж, 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэж заасан байна. 2011 оны хувьд энэ нь төсвийн хүндрэлийг бий болгох магадлалтай хэдий ч энэ нь даван туулах бүрэн боломжтой асуудал гэж үзэж байна.

Манай улсын төсвийн тулгамдсан асуудал бол төсвийн богино хугацааны бэрхшээлийг хэрхэн даван туулах вэ гэдэг бус харин тогтолцооны суурь гажуудлыг хэрхэн засч, цаашдаа төсөв, сангийн бодлогыг зөв гольдролд нь оруулах асуудал юм. Дээр дурдсан бэрхшээлүүдийг даван туулах талаар Засгийн газраас тодорхой алхамуудыг хийж байгааг энд дурдах хэрэгтэй. Юуны өмнө Засгийн газраас “Төсвийн тогтвортой байдлын тухай” хуулийн төслийг санаачилж, УИХ-д өргөн бариад байна. Үүнийг дагаад одоо үйлчилж буй хэд хэдэн хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг мөн хамт өргөн барьсан билээ. Тухайлбал, УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай зэрэг хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулахаар заасан байна.

Энэхүү хуулийн төсөл (дагалдах хуулинд орох нэмэлт, өөрчлөлтийн хамт) батлагдвал хэд хэдэн суурь бэрхшээлийг даван туулахад тус дэм болох юм. *Нэгдүгээрт*, төсвийн орлого, зарлагыг мөчлөг дагасан бус илүү мөчлөг сөрсөн шинж чанартай болгоно. Төсвийн орлогыг тооцохдоо зэс болон бусад эрдэс баялгийн тухайн жилийн үнээр бус харин олон жилийн дунджаар буюу тэнцвэржүүлсэн журмаар тооцно. Үүнээс үүдээд төсвийн тэнцлийг (төсвийн алдагдал болон ашгийг) ердийн тэнцлээр бус “тэнцвэржүүлсэн тэнцэл”-ээр

(structural balance) тооцох зарчимд шилжинэ. Энэ нь төсвийн орлого эрдэс баялгийн үнийг дагаад хэлбэлзэх биш, харин урт хугацаандаа тогтвортой байх зарчмын дагуу тогтоогдох болно гэсэн үг юм.

Хоёрдугаарт, төсвийн зарлагын өсөлтөд хязгаар тавигдана. Энэ нь төсвийн зарлага зөвхөн орлогоо дагаад өөрчлөгддөг, орж ирсэн орлогоо тэр жилдээ бүрэн зарцуулдаг аргаас сална гэсэн үг юм. Ингэснээр орлого ихтэй жил хуримтлал бий болгож, эдийн засгийн бэрхшээл нүүрлэсэн, орлого багассан жилд зарлагаа тодорхой хязгаарын хүрээнд нэмэх эрх нь байгаа тул иргэд болон нийт эдийн засгаа дэмжих, өөрөөр хэлбэл мөчлөг сөрсөн бодлого явуулах боломж бүрдэнэ. Өргөн бариад байгаа хуулийн төсөлд төсвийн зарлагын өсөлтийг тухайн жилийн ДНБ-ий өсөлтөөс хэтрэхгүй байхаар заасан байна. Гэхдээ энэ заалт дангаараа бодлогыг мөчлөгийн эсрэг болгож чадахгүй гэдгийг анхаарна уу. Сангийн бодлого нь мөчлөг сөрсөн шинжтэй болгохын тулд тогтворжуулалтын сан чухал үүрэг гүйцэтгэх ёстой юм.

Гуравдугаарт, улс төрийн үндэслэлгүй, холбогдох тооцоо нь хийгдээгүй амлалтыг хязгаарлах. Ингэхийн тулд Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо болон Сангийн яамнаас улс төрийн намууд болон Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн амлалтыг хэрэгжүүлэхэд гарах зардлын тооцооны үнэлгээг хийж, хэрэгжих боломжтой эсэхийг тайлбарласан дүгнэлтийг гарган олон нийтэд мэдээлэх юм. Ингэснээс намуудын хэрэгжих үндэслэлгүй, тооцоо нь хийгдээгүй, бие биенээсээ өрсөн амлалтыг хязгаарлах боломж нь бүрдэнэ, нөгөө талаас иргэдийг сонгуулийн үеэр шаардагдах мэдээллээр хангаснаар улс төрийн хариуцлагатай сонголт хийхэд дэм үзүүлнэ гэж тооцоолж байна.

Өргөн барьсан хувилбараар мөрийн хөтөлбөрийн амлалтын зардлын тооцоог Сангийн яам болон ҮХШХ-оос хийхээр заасан нь үнэлгээ гаргах байгууллагын хараат бус байдлын асуудлыг эргэлзээтэй болгож байна. Мөрийн хөтөлбөрт үнэлгээ хийх байгууллага нь улс төрийн аль нэг хүчнээс хараат бус, жинхэнэ бие даасан шинж чанартай байж уг үнэлгээ нь бодит болох юм. Сангийн яам болон ҮХШХ энэхүү үнэлгээг хийснээр эрх барьж буй намд давуу талыг олгох боломж бүрэн байна гэж үзэж байна. Нөгөө талаас үнэлгээ хийж буй байгууллагын нэр хүнд, чадавхи мөн чухал. Энэ байгууллага нь холбогдох тоо баримттай, ур чадвар мэдлэг бүхий боловсон хүчинтэй, тооцоог бүрэн дүүрэн хийх чадавхитай байх ёстой. Гэтэл төсвийн талаарх мэдээлэл болон тооцоо хийх аргачлал нь Сангийн яаман дээр төвлөрдөг нь өөр байгууллагаар тооцоог хийлгүүлэхэд сул тал болж байна. Бусад орны туршлагаас харахад иймэрхүү тооцоог Төрийн сан нь хийдэг тохиолдол олон байна.

Ямартаа ч сонгуулийн мөрийн хөтөлбөрийн үнэлгээ хийх асуудлыг хуульчлахаар өргөн барьсан нь сайшаалтай хэрэг. Энэ нь, нэг талаас улс төрийн намуудын хариуцлагагүй амлалтыг хязгаарлах, нөгөө талаас нэгэнт олонх болоод Засгийн газраа бүрдүүлсэн намын хувьд амлалтаа биелүүлэхийн тулд Төсвийн тогтвортой байдлын тухай болон бусад хуулийг (батлагдсаны дараа) өөрчлөх сонирхол бага байх болно гэж үзэж байна. Харин улстөрчдийн хувьд эрх барьж буй намын давуу эрхийг хэрхэн хязгаарлах тал дээр мэтгэлцэж, үнэлгээ хийх байгууллагын бие даасан байдлыг хангах оновчтой хувилбарыг олох шаардлагатай юм.

Дөрөвдүгээрт, тогтворжуулалтын сангийн тухай асуудал юм. Өргөн барьсан хуулийн төслөөр Тогтворжуулалтын санг байгуулах тухай заасан байна. Энэ

сан нь төсвийн тэнцвэржүүлсэн орлогоос давсан орлогыг, өөрөөр хэлбэл эрдэс баялгийн зарцуулагдаагүй орлогыг төвлөрүүлж, шаардлагатай үед төсвийн алдаглыг санхүүжүүлэхэд чиглэх юм. Ингэснээр төсөв, сангийн бодлогын мөчлөг сөрсөн шинж чанар нь хэрэгжих үндэстэй болно. Хуулийн төсөлд орсон тогтворжуулалтын сан нь өмнө нь хэрэгжиж байсан Монгол Улсыг хөгжүүлэх сан болон одоо үйл ажиллагаа явуулж буй Хүний хөгжил сангаас зарчмын хувьд, ялангуяа зарцуулалтын хувьд ялгаатай байх ёстойг бид өмнө нь дурдаж байсан бөгөөд тайлангийн дараахь хэсэгт дэлгэрэнгүй авч үзнэ.

Дээрх арга хэмжээнүүд нь манай төсвийн тогтолцооны суурь гажуудлыг арилгахад дөхөмтэй байх нь дамжиггүй. Цаашилбал “Нэгдсэн төсвийн тухай” хууль, “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийг нэгтгэж, нэгдсэн хуультай болох бодлогын санаачилга явж байгааг дурдах хэрэгтэй.

Төсвийн тогтолцооны шинэчлэл, ялангуяа төсвийн зарлагын шинэчлэл, төв болон орон нутгийн төсвийн харилцааны шинэчлэлийн асуудал хурцаар тавигдаж байна. Энэхүү хүлээлт нь бодлого боловсруулагчдын хүрээнд бус мөн иргэний нийгэм, бизнес эрхлэгчдийн хүрээнд томоохон асуудал болсон нь саяхан болж өнгөрсөн Монголын эдийн засгийн чуулганы үеэр³⁸ өрнөсөн хэлэлцүүлгээс илт байна. Монголын улстөрчдийн хувьд төсвийн шинэчлэлийг хийж, өөрсдийн эрх мэдлийг хязгаарласан хуулийг батлах хариуцлагатай цаг хугацаа тулгараад байна. Үүнд иргэний нийгэм болон хувийн хэвшлийн төлөөлөгчид зөв шийдвэр гаргахад нөлөө үзүүлэх нь асуудлыг шийдвэрлэхэд тус дөхөм болох ёстой юм.

5.3. Тогтворжуулалтын сан: Олон улсын туршлага ба Монгол Улс

Сүүлийн жилүүдэд баримталсан эдийн засгийн мөчлөг дагасан төсөв, сангийн бодлого манай улсыг гадаад зах зээл дээрх сөрөг нөлөөлөлд хэт өртөмтгий болгосоор байгааг энэ удаагийн хямрал тодоор харууллаа. Нөгөө талаас, манай улсын бодит эдийн засаг жил ирэх тусам ашигт малтмалын салбараас ихээхэн хараат болж байгаа нь гадаад зах зээл дээрх өөрчлөлтөд улам өртөмтгий болгож байна. Тухайлбал, зөвхөн 2004-өөс 2008 оны хооронд олборлох салбарын ДНБ-д эзлэх хувийн жин 17 хувиас 27 хувь болж өссөн нь үүнийг илтгэж байгаа юм.

Дэлхийн зах зээл дээр ашигт малтмал, эрдэс баялгийн үнэ байнгын хэлбэлзэлтэй байдаг нь манайх шиг олборлох салбартаа хэт түшиглэж байгаа орнуудын эдийн засгийг зайлшгүй хэлбэлзэлд оруулдаг байна. Эдийн засгийн хэлбэлзэл гэдэг нь эрдэс баялгийн үнэ өсөхөд эдийн засаг нь хэт өсч халалт үүсдэг байхад эрдэс баялгийн үнэ буурахад эдийн засгийн уналт бий болж улмаар хямардаг зүй тогтлыг хэлж байгаа юм. Тэгвэл эдийн засаг ийнхүү өндөр хэлбэлзэлтэй байх нь үйлдвэрлэгч болоод хөрөнгө оруулагчдаас тогтворгүй, таамаглахад түвэгтэй, хязгаарлагдмал мэдээллийн орчинд үйл ажиллагаа явуулахыг шаарддаг учраас шинэ бүтээгдэхүүн, шинэ санаа бий болгох, эрэлхийлэх урам зоригийг нь бууруулдаг. Эдийн засгийн тогтвортой өсөлт бол хүмүүсийн шинэлэг зүйл бүтээх, бий болгох санаачилгаас эх

38 Монголын эдийн засгийн анхдугаар чуулган 2010 оны 2 дугаар сарын 8-9 өдрүүдэд Төрийн ордонд болж өнгөрөв.

үүсвэртэй учраас эдийн засгийн тогтворгүй орчин хүмүүсийн шинэ санаа, бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох эрмэлзлийг нь алга болгодог. Тийм учраас аливаа орны эдийн засгийн бодлого аль болох тодорхой бус байдлыг арилгах, гадаад сөрөг нөлөөллийг багасгаж эдийн засгийн тогтвортой орчин бий болгоход чиглэгддэг байх ёстой юм.

Эдийн засгийн тогтвортой орчин бий болгоход төрийн гүйцэтгэх үүрэг хэр байх ёстой вэ, ерөнхийдөө эдийн засагт гүйцэтгэх төрийн үүрэг ямар түвшинд байх вэ гэдэг асуудлууд ургаж гарч ирнэ. Сүүлийн үед манай бодлого боловсруулагчид төрийн эдийн засагт гүйцэтгэх үүргийн талаар ихээхэн ярьж байгаа. Үүн дотор харамсалтай нь төрийн эдийн засагт гүйцэтгэх үүргийг чухалчлах нь ихээхэн элбэг ажиглагдаж байна. Жишээлбэл, ашигт малтмалын ордуудыг ашиглалтад оруулах, түүнийг тойрсон дэд бүтцийг хөгжүүлэх, түүнээс улбаалаад нэмэгдсэн өртөг шингэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох зэрэг асуудлуудад төрийн оролцоотой шийдэх ёстой мэт ярьж бичиж байна. Түүгээр ч үл барам одоогийн үйл ажиллагааг явуулж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний салбарынхан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх гэхээсээ илүү төрөөс тусламж дэмжлэг авахад ихээхэн хүч хөрөнгө зарж байгаа ажиглагдаж байна.

Эдийн засагт гүйцэтгэх төрийн үүргийг ихэсгэх нь улс орныг улам их эрсдэлд оруулж байна. Тухайлбал, эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох боломжийг улам хязгаарлана гэсэн үг. Эцсийн дүндээ бидний байгуулах гэж зорьж байгаа эдийн засгийн тогтолцоо бол нэмэгдсэн өртөг шингэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг хувь хүмүүс, пүүс компаниуд бий болгох замаар эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг бий болгодог тогтолцоо юм. Өөрөөр хэлбэл, хувь хүмүүс, пүүс компаниудын шинэлэг санаа, эрэлхийлэлд тулгуурлаж байж эдийн засгийн тогтвортой өсөлт бий болж, цаашилбал орлогын тэгш хуваарилалт, ядуурал зэрэг нийгмийн хурц асуудлуудыг зөвөөр шийдэх нөхцөл бүрдэх юм. Харамсалтай нь одоогийн байгаа тогтолцоогоор бол нэмэгдсэн өртөг гэхээсээ илүү ашигт малтмалын үл сэргээгдэх, тогтворгүй орлогыг хүмүүст жигд хуваарилах гэж оролдсон явцуу байдалтай байна. Үүний нэг илрэл нь сүүлийн арав гаруй жилд ярьж, хэлж, зорьж, хэрэгжүүлэх гэж оролдож ирсэн нийгмийн чиглэлийн бүх арга хэмжээ ядуурлыг бууруулж чадаагүй тоо баримтаас харагдаж байна.³⁹ Өөрөөр хэлбэл, ашигт малтмалд хэт суурилсан эдийн засгийн өсөлт орлого хуваарилалтыг тэгшитгэж чаддаггүй, улмаар нийгмийн асуудлуудыг шийдвэрлэж чаддаггүй гэдгийг манай улсын жишээ тод харууллаа гэж үзэх үндэстэй.

Хэдийгээр байгалийн баялаг бол ард түмний өмч учраас орох орлогоос нь хүмүүст хуваарилах нь зүйтэй бөгөөд ашигт малтмалыг олборлоход нь төрийн тодорхой оролцоо байх нь залшгүй шаардлагатай ч олборлох салбар уруу хэт анхаарах нь маш буруу чиг хандлага. Хүмүүст олборлох салбараас орж буй орлогыг жигд хуваарилах нь үнийн өсөлтийг бий болгож улмаар улс орныг “Голланд өвчин”-д нэрвэгдэхэд нөлөөлдөг гэдгийг бид бүхэн мэдэж байгаа. Энэ өвчний зах зухаас бид аль хэдийнэ амсч байгаа. Сүүлийн жилүүдэд бий болсон зэсийн дэлхийн зах зээл дээрх үнийн өсөлттэй холбоотойгоор

39 “Дэлхий санхүү эдийн засгийн хямралын Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө” улирлын тайлангууд болоод “Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө: Хөдөлмөрийн зах зээл ба Нийгмийн эмзэг байдал, ядуурал” тайлангуудаас дэлгэрэнгүй үзнэ үү.

Засгийн газраас хавтгайруулж олгосон төрөл бүрийн нийгмийн хамгааллын болоод бусад зарлагын огцом өсөлт үнийн өсөлтийг бий болгосон. Тухайлбал, нэрлэсэн үнэ болох инфляци 2008 онд дунджаар 26 хувьд хүрч, бараа бүтээгдэхүүний бодит үнэ болох бодит ханш 2007-оос 2008 оны 11 дүгээр сарын хооронд 30 гаруй хувиар өсөөд байсан нь чухамхүү Засгийн газрын зарлагын хэт өсөлттэй холбоотой.

Түүнээс гадна, бодлого боловсруулагчдын зүгээс огт ярихгүй орхигдуулж байгаа нэг асуудал бол манай улсын байгалийн баялаг нь одоогийнхоос гадна ирээдүй хойч үеийн баялаг бас мөн болохыг бодлогын шийдлүүддээ оруулж өгөх асуудал. Өөрөөр хэлбэл, энэхүү баялаг нь үл сэргээгдэх баялаг учраас олборлогдоод дуусах үед чухам ямар үйлдвэрлэл, үйлчилгээний салбарууд манай улсын эдийн засгийг цааш нь авч явах вэ гэдэг асуудал байна. Энэ асуудлыг анхааралгүйгээр зөвхөн ойрын жилүүдээ харж бодлогоо тодорхойлж болохгүй гэдэг нь ойлгомжтой. АНУ л гэхэд нүүрсний нөөцөөрөө дэлхийд нэгдүгээрт, нефтийн нөөцөөрөө дэлхийд 12-т ордог хэдий ч эдгээр нөөцөө тэр болгон хэрэглэх гэж яардаггүй, харин ч хойч үедээ үлдээх бодлого баримталдаг нь бидэнд сургамжтай санагдаж байна. Тиймээс хойч үеэ харсан, урт хугацааны эдийн засгийн бодлого боловсруулах шаардлагатай.

Тэгэхээр энэхүү гадаад зах зээл дээрх сөрөг нөлөөллөөс улс орны эдийн засгийг хэрхэн хохирол багатай гарч болох вэ гэдэг ганц асуултад хариулахын тулд бид энэхүү асуудлыг маш олон талаас нь харж үзэх шаардлага гарч байна. Тухайлбал бид наад зах нь дараахь дөрвөн үндсэн асуудлуудыг анхаарах шаардлага гарч байна. Энэ нь *нэгдүгээрт*, мөчлөг дагасан төсөв, сангийн бодлого манай эдийн засгийг улам тогтворгүй болгож байгаа, *хоёрдугаарт* манай улсын эдийн засаг жил ирэх тусам олборлох салбараасаа улам хараат болсоор байгаа, *гуравдугаарт* эдийн засаг дахь төрийн оролцоо хэт их байх нь хувь, хүмүүс, пүүс компаниудын шинийг бүтээх, эрэлхийлэх сонирхлыг дардаг, *дөрөвдүгээрт* олборлох салбар эдийн засгийн тэргүүлэх салбар болбол ирээдүй, хойч үед чиглэгдсэн урт хугацааны бодлоготой тэр бүр нийцдэггүй. Өөрөөр хэлбэл, наад зах нь эдгээр тулгуур асуудлыг шийдэж, зөв гольдролд нь оруулахаас нааш баялгийн “хараал”-аас мултарч чадахгүй гэж үзэж байна.

Дээрх асуудлууд бүгд өөр өөрийн гэсэн өвөрмөц хүндрэлүүдийг дагуулахаас гадна өөр өөрийн шийдлийг шаардах нь зайлшгүй. Экспортын төрөлжилтийг өсгөх, мөчлөг сөрсөн төсөв, сангийн болоод мөнгөний бодлого явуулах, Засгийн газрын зарлагыг бууруулах замаар эдийн засаг дахь оролцоог хязгаарлах, зарим ашигт малтмалын ордуудыг ашиглалгүйгээр хойч үедээ үлдээх зэрэг шийдлүүд нь хэт ерөнхий, бодлогын шийдлүүдийг гаргахад тус болохгүй гэдэг нь тодорхой байна.

Тэгвэл бид тайлангийнхаа энэ хэсэгтээ дээрх дөрвөн тулгуур асуудлуудад хэсэгчилээд ч болов хариулт өгөх шийдлийг хөндөж байна. Энэ нь тогтвортой хөгжлийн санг бий болгох, жинхэнэ утгаар нь ажиллуулахтай холбоотой юм. Өөрөөр хэлбэл, тогтвортой хөгжлийн санг зөв зүйтэй хэрэгжүүлж чадвал дээр хөндөгдсөн дөрвөн асуудлуудыг зөв шийдэхэд түлхэц болно.

Тогтвортой хөгжлийн санг бий болгох гол зорилго нь олборлох салбараас орох гадаад валютын урсгалд зохицуулалт хийхэд оршиж байна. Ямарваа нэг орны эдийн засагт ашигт малтмалын орлого ихээр орж ирэх нь тухайн

оронд нэрлэсэн болоод бодит үнийн өсөлтийг бий болгож улмаар эдийн засгийн тогтворгүйжилтийг авчирдаг. Эдийн засгийн бодлогоор дамжуулан энэхүү урсгалыг зохицуулахгүй бол эдийн засаг дахь төрийн оролцоо энэхүү тогтворгүйжилтийг улам хурцатгадаг болохыг бид дээр дурдсан.

Тийм учраас ашигт малтмалын орлого өсөх үед тогтворжилтын санд хөрөнгийг хуримтлуулахаас гадна төвлөрсөн хөрөнгө нь тухайн орны эдийн засагт шууд нөлөө үзүүлдэггүй байх ёстой болж таарч байна. Өөрөөр хэлбэл, энэхүү сангийн хөрөнгийг зарцуулахгүй, хадгалж байх нь хамгийн чухал. Дэлхий дээр маш олон улс тогтворжилтын сангуудтай байдаг.⁴⁰ БНХАУ, Арабын нэгдсэн эмират, АНУ зэрэг улс орон хэд хэдэн тогтворжилтын сантай байна. Эдгээр сан ихэвчлэн аливаа нэг олборлох бүтээгдэхүүнээс олох орлогын урсгалыг зохицуулахаар байгуулагдсан нь харагдаж байна.

Тогтвортой хөгжлийн сан (sovereign wealth fund) гэдэг нь ерөнхийдөө төрийн мэдэлд байдаг санхүүгийн хөрөнгийн хуримтлалыг хэлдэг байна. Энэхүү санд нарийн тодорхойлолт байхгүй хэдий ч сангууд нь нийтлэг шинж чанаруудтай. Үүнд, энэхүү сангийн хөрөнгийг ихэвчлэн үнэт цаас, бонд, үл хөдлөх хөрөнгө зэрэг хэлбэрээр байршуулдаг бөгөөд ихэнх сан дэлхий нийтийг хамарсан хөрөнгө оруулалт хийдэг. Өөрөөр хэлбэл, гадаад санхүүгийн зах зээл дээр хөрөнгөө байршуулдаг гэсэн үг. Гэтэл, зарим сан дотоод пүүс, компаниудад хөрөнгө оруулах, бүр Засгийн газрын хэрэглээг санхүүжүүлэх нь ч бий. Түүнчлэн, энэхүү санд эрдэс баялгийн экспортоос татвар авах эсвэл хувь эзэмших болоод бусад замаар хөрөнгө хуримтлуулдаг.

Манай улсын хувьд тогтворжилтын сантай төстэй сан байгуулагдаж байсан. 2006 онд байгуулагдсан “Монгол Улсыг хөгжүүлэх сан” (МУХС) нь тогтворжилтын сангийн тодорхой шинж чанаруудыг агуулж байжээ. Тухайлбал, алт болоод зэсийн үнэд тогтоосон онцгой албан татварын орлогыг энэхүү санд байршуулсан. Харин энэхүү сан гурван төрлийн үйл ажиллагааг ижил хувиар санхүүжүүлэхээр зааж өгсөн. Үүнд хөрөнгө оруулалтын зарлага, нийгмийн халамжийн чиглэлийн зарлагыг санхүүжүүлж, үлдсэн хэсэг нь хуримтлагдаж байжээ. Тус санд алт, зэсийн үнэ өссөнтэй холбоотойгоор тодорхой хэмжээний хөрөнгө хуримтлагдаад байсан. Тухайлбал, 2007 оны эцсийн байдлаар ДНБ-ий 7.7 хувь буюу 354 тэрбум төгрөгтэй тэнцэхүйц хөрөнгө хуримтлагдсан нь 2008 оны Засгийн газрын төсвийн алдагдал болох 305 тэрбум төгрөгийг бүрэн нөхөх хэмжээнд байсан нь харагдаж байна. Харин 2009 он бүхэлдээ хямралын жил байсан учраас энэхүү сангийн хөрөнгө үндсэндээ зарцуулагдаад дууссан байна. Түүнчлэн, 2009 оны 12 дугаар сард Улсын Их Хурлаас МУХС-г татан буулгаж “Хүнийн хөгжил сан”-г байгуулсан нь тогтворжилтын сангийн бодлогод цоо шинэ хандлагыг бий болголоо.

“Монгол улсыг хөгжүүлэх сан”-гаас санхүүжигдэж ирсэн хүүхдийн, шинээр гэр бологсодын зэрэг нийгмийн тэтгэлэгт хөтөлбөрүүд болоод хөрөнгө оруулалтын төслүүд нь үндсэндээ бусад Засгийн газрын зарлагаас ялгагдахгүй байсан. Тийм ч учраас МУХС бидний дээр хэлэлцсэн тогтворжилтын сангийн үүргийг гүйцэтгэж чадаагүй. Тогтворжилтын сан эдийн засгийн мөчлөгийг сөрсөн төсөв, сангийн бодлого явуулахад санхүүжилтийг нь хэсэгчлээд ч гэсэн шийдэж өгч байх ёстой. Гэтэл МУХС-гаас Засгийн газрын зарлагуудыг

40 Тогтворжуулалтын сангуудын чансааг <http://www.swfinstitute.org/funds.php> вэб сайтаас харна уу.

эдийн засгийн өсөлттэй үед санхүүжүүлж байсан учраас эдийн засгийн мөчлөгийг сөрөх биш харин ч мөчлөг дагасан бодлого явуулахад нь түлхэц болж өгсөн. Харамсалтай нь эдийн засгийн хямрал нүүрлэж төсвийн орлого огцом буурахад МУХС-д Засгийн газрын зарлагын бууралтыг санхүүжүүлэх хөрөнгө үлдээгүй. Тийм ч учраас нийгмийн тэтгэлэгт хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэх боломжгүй болж байгааг Засгийн газар удаа дараа мэдэгдэж байлаа. Ийнхүү төлөвлөлт муутай, Засгийн газрын зарлагыг өсгөхөд чиглэсэн бодлого явагдаж байсан учраас хямралтай тэмцэх хөрөнгө энэхүү санд үлдээгүй.

Тэгвэл, Засгийн газар “Хүний хөгжил сан (ХХС)”-г шинээр байгуулахдаа дээрх буруу бодлогоосоо сургамж авав уу гэдэг асуудал гарч байна. Харамсалтай нь сургамж аваагүйгээр ул барам бүр ч муутгасан дүр зураг харагдаж байна.

ХХС-ийн хуулийн дагуу энэ санд төвлөрүүлэх хөрөнгийг голчлон ашигт малтмалын ордуудаас төрд ногдох ашгаар санхүүжүүлэхээр төлөвлөж байна. Гэнэтийн ашгийн татвар 2011 онд цуцлагдаж байгаа учраас төрийн эзэмшлийн хувьд ногдож буй ашиг ийнхүү ХХС-ийн орлогын гол эх үүсвэр болох нь. Энэ утгаараа ХХС бол яах аргагүй тогтворжилтын сан мөн. Энэхүү сангийн өдөр тутмын удирдлагыг гадаадын санхүүгийн байгууллагад менежментийн гэрээгээр ажиллуулах эрхийг нээж өгсөн бөгөөд энэ сангийн хөрөнгийг дотоод, гадаадын үнэт цаас худалдаж авах, хадгаламжид байршуулахаар зааж өгчээ. Ингэхдээ засгийн газраас жишиг багцыг гаргаж өгөх юм байна. Өөрөөр хэлбэл, Засгийн газар ямар хөрөнгө оруулалтад хөрөнгөө байршуулахыг нь зааж өгчээ.

ХХС-ийн хөрөнгийг хэрхэн байршуулах тал дээр хэд хэдэн дутагдалтай тал ажиглагдаж байна. Хамгийн гол дутагдалтай тал нь Засгийн газраас хөрөнгийг хэрхэн байршуулах дээр жишиг гаргаж өгнө гэсэн нь ойлгомжгүй байна. Өөрөөр хэлбэл, үүнийг зааг хязгаар гэж ойлгох нь зүйтэй юу, аль эсвэл тодорхой хувьд барих ёстой хэм хэмжээ юу гэдэг нь тодорхойгүй байна. Энэ тал дээр бид Азербайжаны тогтворжилтын сан болох “Улсын нефтийн сан”-гаас суралцах зүйл байгаа мэт санагдаж байна. Энэхүү сангийн хөрөнгийг хэрхэн, юунд байршуулахыг тодорхой зааж өгдөггүй харин тодорхой хязгааруудыг тавьж өгдөг. Аливаа нэг гадаад санхүүгийн байгууллагаар хөрөнгөө удирдуулах гэж байгаа бол тухайн сангийн 15 хувиас илүүгүй хөрөнгийг удирдахыг нь зөвшөөрсөн байна. Түүнээс гадна энэхүү сангийн хөрөнгө хэрхэн, юунд, ямар хэмжээгээр байршиж, ямар үлдэгдэлтэй байгаа ямар зүйлд энэ сангийн хөрөнгөөс зарцуулж байгаа нь олон нийтэд ил тод байгаа нь энэхүү сангийн үйл ажиллагаа зөв гольдролоор явах боломжийг олгож байна. Азербайжаны “Улсын нефтийн сан”-гийн үйл ажиллагаанд “Улсуудын баялгийн сангийн хүрээлэн” (Sovereign wealth fund institute)-гээс ил тод үйл ажиллагааны хамгийн өндөр оноог өгсөн нь үүнийг давхар илтгэж байна.

Дээрх асуудлыг тодорхой шинэ дүрэм, журмын хүрээнд шийдэж болохоор харагдаж байгаа бол ХХС-ийн зарцуулалт МУХС-ийн зарцуулалттай харьцуулахад бүр их үрэлгэн болохоор байна. Тухайлбал, ХХС-ийн гол зорилго нь иргэдэд тус санд төвлөрсөн хөрөнгийг жигд хуваарилахад оршиж байгаа бөгөөд иргэдэд ногдох хувь хэмжээг УИХ тогтоож байхаар зааж өгчээ. Бид өмнөх улирлын тайлангууддаа МУХС-аас санхүүжигдэж байгаа нийгмийн чиглэлийн хөтөлбөрүүд хэт үрэлгэн байгаа талаар дурдаж,

эдгээр хөтөлбөрүүдийг зорилтот бүлэг рүүгээ оновчтойгоор чиглүүлэх шаардлага тулгарч байгаа талаар хэлэлцэж байсан. Өөрөөр хэлбэл, нийгмийн эмзэг бүлэг рүү эдгээр хөтөлбөрийг илүү нарийвчлал сайтайгаар чиглүүлэх шаардлага байсан бөгөөд тухайн үед Засгийн газар болоод зарим олон улсын санхүүгийн байгууллага ч гэсэн тус хөтөлбөрийг зорилтот бүлэг рүү хэрхэн оновчтой чиглүүлж болох талаар судалж байгаагаа мэдэгдэж байсан. Гэтэл ХХС байдлыг улам дордуулж тус санд хуримтлагдах хөрөнгийг ямарваа нэг зорилтот бүлэг рүү чиглүүлэх биш харин ч нийт ард иргэдэд жигд хуваарилахаар зохион байгуулагдсан нь хөрөнгийг өмнөхөөсөө илүү үрэлгэн байдалтайгаар зарцуулахаар байна.

Ер нь орлогын тэгш хуваарилалтыг багасгахын тулд Засгийн газраас төрөл бүрийн шилжүүлэг хийх нь аль ч улс оронд байдаг. Жишээлбэл, орлогын тодорхой эх үүсвэргүй иргэд, өрхийг санхүүгийн эх үүсвэрээр дэмжих, ажлаа түр алдсан тохиолдолд тэтгэмж олгох, эсвэл сурах, боловсроход нь зориулж төрөл бүрийн татварын хөнгөлөлт үзүүлэх зэрэг нийгмийн хөтөлбөрүүдийг өргөн хэрэглэдэг. Гэхдээ нийт ард иргэдийг хамарсан иймэрхүү тэтгэлгийн хөтөлбөрийг авч хэрэгжүүлдэггүй. Учир нь бидний дээр дурдсан иймэрхүү төрлийн хөтөлбөрүүд үнийн өсөлтийг бий болгодог бөгөөд бодит утгаар нь тооцоход өмнөхөөсөө илүү ядууруулах нөхцөл байдлыг ч үүсгэж болох талтай. Тийм учраас иймэрхүү хөтөлбөрүүд эдийн засгийн үр ашиг талаасаа муу байдаг учраас улс орнууд аль болох зорилтот бүлгээ тодорхойлж түүндээ тохирсон хөтөлбөрүүд хэрэгжүүлэх нь элбэг. Жишээлбэл, ажилгүйдэл газар авсан тохиолдолд ажлаа алдсан хүмүүст сурч боловсрох, мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэхэд нь дэм үзүүлэх зорилгоор Засгийн газраас нь эдгээр бүлэг хүмүүст зориулж сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлдэг хөтөлбөр хэрэгжүүлэх нь элбэг харагддаг. Энэхүү хөтөлбөр хувь хүндээ ч, улс орондоо ч ашигтай гэдэг нь тодорхой байна.

Манай улсын хувьд нийгэм, эдийн засгийн хамгийн эмзэг сэдэв бол ядуурал гэдгийг хүн бүхэн хүлээн зөвшөөрч байна. Сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлсэн нийгмийн чиглэлийн хөтөлбөрүүд ядуурлын түвшинг бууруулж чадаагүй гэдгийг бодолцон нийт ард, иргэдэд гэхээсээ илүү нийгмийн тодорхой давхаргад зориулж төрөл бүрийн хөтөлбөрүүд хэрэгжүүлбэл илүү үр дүнтэй мэт. Иймэрхүү тодорхой зорилтот бүлэгтэй хөтөлбөрүүдийн хамрах хүрээ нь хязгаарлагдмал учраас үнийн өсөлтийг бий болгох нөлөөлөл багатай байх нь тодорхой.

Үүнээс гадна энэ сангаас зарцуулах мөнгөн хөрөнгийн хэмжээний асуудал урган гарч байна. Энэ санд хэдий хэмжээний хөрөнгө, ямар хугацаанд төвлөрөх нь тодорхойгүй байна. Үүнийг тодорхой болгох боломж ч асар бага. Өөрөөр хэлбэл, томоохон орд газрууд ямар хугацаанд ашиглалтад оруулж чадах, ордуудыг ашиглахад төрийн оролцоо ямар хэлбэртэй байх, эрдэс баялгийн үнэ дунд хугацаанд хэрхэн өөрчлөгдөх нь тодорхойгүй байгаа зэргээс харахад энэхүү санд ямар хэмжээний хөрөнгө ногдол ашгаас төвлөрөх нь бүрхэг байна.

2010 онд ХХС-аас иргэн болгонд 70,000 төгрөг олгох шийдвэр Засгийн газраас гаргасан. Энэхүү 70,000 төгрөгийг иргэн болгонд олгохын тулд Засгийн газар Айвэнхоу Майнз ХХК-ас авсан “урьдчилгаа төлбөр” болох 150 сая ам.доллар, улсын төсвөөс энэ сан руу төвлөрүүлэх 133.9 тэрбум төгрөг, нийтдээ 346.6 тэрбум төгрөгийг ХХС-д төвлөрүүлэх замаар санхүүжилтийг

нь шийдэхээр тооцжээ.⁴¹ Ийнхүү нийт ард, иргэдэд халамжийг хавтгайруулан олгохын тулд татвар төлөгчдийн мөнгө болоод Оюу толгой төслийг барьцаалж авсан зээлээр санхүүжүүлж байгаа нь хэр зөв шийдэл вэ гэдэг асуултыг тавихад хүргэж байна. Хамгийн харамсалтай гэж болох асуудал бол аливаа төр засаг ирээдүй хойч үедээ мөнгө, хөрөнгө, баялаг үлдээдэг байтал манай бодлого боловсруулагчид энэ удаад харин ч эсрэгээрээ ирээдүй хойч үеэсээ баялгийг нь авч, тарааж байгаа нь хариуцлагагүй үйлдэл болж байна.

Энд хөндөгдөж байгаа нэг ноцтой асуудал бол хэдий хэмжээний хөрөнгийг энэ сангаас ард, иргэдэд хуваарилахыг нь зөвхөн УИХ шийдэж байгаа явдал. Бидний ойлгож байгаагаар энэхүү санд төвлөрөх хөрөнгө бол одоо үе гэхээсээ илүү ирээдүй, хойч үеийн амьжиргааны баталгаа болж өгөх учиртай мэт. Гэтэл энэ хөрөнгийн зарцуулалтыг дөрвөн жилээр сонгогддог УИХ, Засгийн газар ямар нэг хэмжээ, хязгааргүйгээр зарцуулах эрхтэй байгаа нь эрсдлийг дагуулж байна. Өөрөөр хэлбэл, УИХ-д зөвхөн дөрвөн жилийн үйл ажиллагаанд нь хариуцлага тооцож болох бол ХХС дээр гаргасан буруу шийдвэр маш урт хугацааны хохирлыг бий болгоно. Тэгвэл УИХ-д тавих хяналт, хязгаар, хэм хэмжээг хэн тогтоож өгөх вэ гэдэг асуудал урган гарч байна. Бидний үзэж байгаагаар энэ сангаас нийгмийн арга хэмжээнд зарцуулах хөрөнгөд тодорхой хязгаар, тодорхой хугацаа тавьж өгвөл шудрага мэт.

Энэ бүхнээс дүгнэхэд ХХС маш их эрсдлийг дагуулсан шийдвэр болсон. Бидний үзэж байгаагаар энэхүү хуулийг хүчингүй болгож тогтворжилтын санг жинхэнэ утгаар нь байгуулж, ажиллуулах нь зүйтэй. Нийгмийн чиглэлийн арга хэмжээнүүдийг заавал ийм төрлийн сан байгуулах замаар санхүүжүүлэх шаардлага байхгүй мэт. Харин, үүний оронд тогтвортой хөгжлийн санг байгуулан тэндээсээ тодорхой хэмжээний хөрөнгийг тодорхой зорилтот бүлэгт зарцуулж байх нь зүйтэй.

УИХ-д өргөн бариад буй “Төсвийн тогтвортой байдлын тухай” хууль болон “Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуульд шинээр байгуулах Тогтворжуулалтын сангийн үндсэн зарчмыг тодорхойлсон байна. Энэ сан нь өнөөгийн үйлчилж буй “Хүний хөгжил сангийн тухай” хуулийг хүчингүй болгох эсвэл өөрчилсөн тохиолдолд төсөв, сангийн бодлогод шинэчлэл гарна гэдгийг анхааруулъя. Заавал ХХС байх ёстой гэж үзэж байвал энэхүү сангийн зарцуулалтад хойч үеэ бодсон, алсаа харсан хязгаарлалтуудыг тавьж өгөх шаардлагатай байна.

41 “Хүний хөгжил сангийн төсвийн тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцэхээр болов” мэдээлэл, www.open-parliament.mn



6. Дүгнэлт: Дэлхийн эдийн засгийн хямрал Монгол Улсад ямар сургамж өгөв?

2009 он хямралын хамгийн хүнд жил байлаа. Манай улсын хувьд сүүлийн арав гаруй жил эдийн засаг өсөлттэй байсан хэдий ч энэ жил 1.6 хувийн уналттай гарсан нь дэлхийн хөгжиж буй, тэр тундаа Зүүн Азийн бүс нутагтаа нэлээд хүнд өртсөн орны тоонд зүй ёсоор орж байна. Энэ нь манай эдийн засаг ихээхэн нээлттэй, дэлхийн зах зээлээс маш их хамаардагтай холбоотой юм. Цаашид энэ хамаарал улам бүр нэмэгдэх төлөвтэй байна. Гэтэл эдийн засгийн мөчлөг хэлбэртэй хөгжил үргэлжлэх нь ойгомжтой. Хямрал нэгээр дуусахгүй. Энэ нөхцөлд яах вэ? Энэхүү хямрал бидэнд ямар сургамж өгөв гэсэн асуулт гарч ирж байна.

Эдийн засгийн нээлттэй байдал нь манай улсад бий болсон хямралын үндэс нь юм. Дахин хямралд автагдахгүй байх үүднээс эдийн засгаа хаах уу гэвэл тийм биш юм. Алийн болгон бид Хятадаас бараа зөөх вэ, өөрөө өөрсдийгөө хэрэглээний наад захын зүйлээр хангах цаг болжээ гэж ярьдаг иргэд битгий хэл эдийн засагчид байдаг хэдий ч тэдний үзэл бодлын нөлөө бага юм. Манай улсын хувьд нээлттэй байхаас өөр сонголт байхгүй. Ер нь нээлттэй эдийн засгийн бодлого нь үсрэнгүй хөгжиж буй ихэнх улс орнуудын, ялангуяа Азийн орнуудын хөгжлийн стратеги байсан, одоо ч байгаа. Эдгээр орон нь эхлээд худалдаагаа өргөжүүлж, улмаар санхүүгийн зах зээлээ нээж, цаашилбал хөдөлмөр экспортлож эхэлсэн байна. Тэгэхээр бараа, үйлчилгээ, санхүүгийн капитал, тэр бүү хэл шилжих хөдөлгөөн хамгийн багатай гэж үзэж байсан хөдөлмөр хүртэл хил хязгаарыг чөлөөтэй даван глобальчлагдаж байна.

Мэдээжийн хэрэг энэ өөрчлөлт, бодлогыг дагаад эрсдэл давхар бий болсон нь ойлгомжтой. 1997 оны Азийн санхүүгийн хямрал чухамдаа энэхүү эрсдлийн том илрэл байлаа. Азийн хямралд нэрвэгдсэн орнууд сургамж авч, санхүүгийн зах зээлийн зохицуулалтаа нарийсган, сайжруулж, шинэчлэл хийсэн. Тиймдээ ч энэ орнууд энэ удаагийн хямралд харьцангуй бага автаж байх шиг байна. Харин санхүүгийн тогтолцоогоо сайтар зохицуулж чадаагүй ОХУ, Мексик зэрэг орнууд ихээхэн нэрвэгдлээ. Энэ удаагийн хямрал нь зөвхөн санхүүгийн биш мөн бодит эдийн засгийн хямрал байсан тул дэлхийн

зах зээлийн худалдан авах чадварын уналтаар дамжуулан хөгжиж буй улс орнуудын бодит үйлдвэрлэл унасан. Энэ нь дэлхийн худалдааны томоохон уналтаар илэрсэн бөгөөд манай улсын хувьд энэхүү суваг хүчтэй нөлөөлсөн талаар бид энэ болон өмнөх тайлангууддаа дэлгэрэнгүй авч үзсэн.

Тэгэхээр нээлттэй эдийн засагтай байна гэдэг нь нэг талаас давуу тал бөгөөд нөгөө талаас мөн ижил хэмжээний эрсдлийг дагуулдаг зүйл байх нь. Монгол Улсын хувьд нэгэнт эдийн засгаа хааж, өөрөө өөрийгөө бараа үйлчилгээгээр хангах бодлого хэрэгжүүлэх боломжгүй нөхцөлд бид яах вэ?

Манай улсын эдийн засаг өнөөдөр уул уурхайн салбараас хараат маш энгийн бүтэцтэй байгаагаас гадаад эдийн засгийн тааламжтай болон тааламжгүй нөлөө, тогтвортой болон тогтвортой бус байдлын аль алины хүчтэй хэлбэлзэл, савалгаанд оршин байна. Цаашдаа энэ хандлага улам бүр лавширна. Дэлхийд томоохонд тооцогдох цөөн тооны ордуудын үйл ажиллагаанаас манай улсын ирээдүйн төлөв хандлага, эдийн засгийн хөгжил хамаарах болоод байна. Уул уурхайн эдгээр түүхий эд бүтээгдэхүүнийг бид зөвхөн гадаадын зах зээлд борлуулах нь ойлгожтой. Тиймээс манай улсын нээлттэй байдал улам бүр нэмэгдэнэ.

Нээлттэй эдийн засаг нь ямагт гадаад хүчин зүйлд өртөмтгий, эмзэг байдаг. Хамгийн түрүүнд үнийн хэлбэлзэл, цаашилбал дэлхийн эдийн засгийн ерөнхий бүтэц, уул уурхайн салбарын түүхий эд ашигладаг салбаруудын ирээдүй, эдгээр салбарт суурилан хөгжиж буй улс орнуудын хэтийн төлөв гээд нөлөө үзүүлэх олон хүчин зүйлс байна. Энэ бүгд манай эдийн засгийг илүү их өртөмтгий, эмзэг болгоно.

Эдийн засгийн эмзэг байдлыг (economic vulnerability) эдийн засгийн тэсвэрлэх чадвараас (economic resilience) салгаж үзэх хэрэгтэй гэж эрдэмтэд үзэж байна⁴². Эдийн засгийн тэсвэрлэх чадвар гэдгийг (i) гадаад эдийн засгийн цохилтыг даван туулах, (ii) эдийн засгийн гадаад, дотоод шокийг шингээх, (iii) өөрчлөгдсөн нөхцөл байдалд дасан зохицох, (iv) бодлогын хариу үйлдэл хийх цогц чадвар, нэг ёсны эдийн засгийн дархлаа гэж тодорхойлж болно. Эмзэг байдлаараа ижил төстэй улс орнууд эдийн засгийн бэрхшээл нүүрлэхэд харилцан адилгүй хариу үйлдэл хийх боломжтой байдаг. Энэ нь тухайн улс орны эдийн засгийн тэсвэрлэх чадвартай холбоотой юм. Эдийн засгийн тэсвэрлэх чадвар сайтай, дархлаа өндөртэй улс орнууд гадаад эрсдэлд оновчтой хариу үйлдэл хийснээр бага хохирч байхад, дархлаа султай улс орнууд ихээхэн хохирох боломжтой юм. Үүнийг энэ удаагийн хямрал ч мөн харууллаа. Тэгэхээр эдийн засгийн тэсвэрлэх чадвар юунаас шалтгаалах вэ? Баскаран, Гош нарын эдийн засагчид дархлаад нөлөөлөх, түүнийг тодорхойлох таван бүлэг хүчин зүйлийг авч үзсэн байна.

42 Manu Bhaskaran and Ritwick Ghosh (2010) "Global Economic Crisis: Impact on Developing Asia and Immediate Policy Implications", report prepared for the Asian Development Bank

Хүснэгт 6.1. Эдийн засгийн тэсвэрлэх чадварыг тодорхойлогч хүчин зүйлс

Хүчин зүйл	Тайлбар
Улс төрийн хүчин зүйлс	Гадаад болон дотоод зөрчил, хурцадмал байдал байгаа эсэх, засгийн газрын тогтвортой байдал, удирдагч эсвэл улс төрийн эвслийн тогтвортой байдал, бодлого хэрэгжүүлэх институцийн чадавхи зэрэг нь эдийн засгийн тэсвэрлэх чадварыг сулруулах эсвэл нэмэгдүүлэх хүчин зүйл болно.
Санхүүгийн өртөмтгий байдал	Санхүүгийн хүчтэй зах зээл нь хямрал буюу гадаад шокийг шингээх чадвар илүүтэй байна. Үүнд хөдөлгөөнтэй санхүүгийн капиталын гадаад валютын нөөцтэй харьцах харьцаа, банкны хяналт ба тогтолцоо, хувийн хэвшлийн санхүүгийн тайлан тэнцэл, мөнгөний урсгал зэрэг нь санхүүгийн чадавхид нөлөөлж, улмаар эдийн засгийн тэсвэрлэх чадварт нөлөө үзүүлнэ.
Эдийн засгийн төрөлжилт	Эдийн засгийн бүтцийн хувьд төрөлжилт (диверсификаци) өндөртэй эдийн засгийн суурь илүү бат бөх, гадаад шоконд бага өртдөг. Үүнд гадаад болон дотоод эрэлтийн харьцаа, гадаадын хөрөнгө оруулалт болон гадаад эх үүсвэрээс шалтгаалж буй түвшин, гадаад худалдаа нь нэг орны эсвэл газар зүйн нэг бүсээс шалтгаалж буй түвшин зэрэг нь төрөлжилтийн түвшинг тодорхойлох юм.
Эдийн засгийн уян хатан чанар	Эдийн засагт шокийн нөлөө гарлаа гэхэд эдийн засаг нь өөрөө өөрийгөө тогтворжуулах чадавхитай эсэх, тодруулж хэлбэл автомат тогтворжуулагчтай эсэхээс шалтгаалан эдийн засгийн тэсвэрлэх чадвар өөр өөр байх юм. Жишээлбэл, ажилгүйдэл, ядуурлын эсрэг оновчтой хөтөлбөрүүдтэй эсэх, хөдөлмөрийн зах зээл болон цалингийн уян хатан байдал, валютын ханшны уян хатан байдал нь гадаад шокийг шингээх чадварыг тодорхойлно.
Бодлогын оновчтой хариу үйлдэл хийх чадвар	Бодлогын хурдан, оновчтой хариу үйлдлээр гадаад нөлөөллийг даван туулах боломжтой юм. Энэ нь төв банкны бие даасан байдал, чадавхи, төсөв сангийн бодлогоор дамжуулан хариу үйлдэл хийх боломж зэргээр шалтгаална.

Эх сурвалж: Centennial Asia Advisors Group

Баскаран, Гош нар дээрх ерөнхий таван бүлгийн хүрээнд 9 үзүүлэлтийг авч үзэн *resilience index* буюу эдийн засгийн тэсвэрлэх чадварын индексийг Азийн зарим улс орнуудын хувьд тооцож үзсэн байна. Ингэхдээ улсын өрийн ДНБ-д эзлэх хувийн жин, инфляцийн түвшин, улс төр болон зохицуулалтын үзүүлэлтээр улс орнуудад өгсөн Фрэйзер Институтын оноо, найдваргүй зээлийн нийт зээлд эзлэх хувийн жин, экспортын гол бараа болон түнш орнуудын вариацийн коэффициент, эрчим хүчний үйлдвэрлэлийн цэвэр илүүдэл, дотоодын эрэлтийн ДНБ-д эзлэх хувийн жин, ДНБ-ий өөрчлөлт болон татварын орлогын өөрчлөлтийн хамаарал, санхүүгийн капитал болон урсгал тооцооны тэнцэл зэрэг есөн үзүүлэлтээр тооцож үзсэн байна.

Азийн сонгосон орнуудын хувьд Хонконг, Сингапур, Вьетнам, Өмнөд Солонгос зэрэг улс эдийн засгийн тэсвэрлэх чадварын индекс өндөртэй гарсан (54-67) бол Филиппин, Шри Ланка, Бангладеш зэрэг орнуудын үзүүлэлт (30-38) харьцангуй доогуур байна. Харин БНХАУ-ын хувьд 2000 онд энэхүү үзүүлэлт нь нэлээд доогуур буюу 38.5 байснаа 2008 онд 55.1 болж өссөн нь үсрэнгүй өөрчлөлт болсон байна. Монгол Улсын хувьд энэхүү индексийг тооцож үзээгүй хэдий ч нэлээд доогуур, ялангуяа эдийн засгийн төрөлжилт, эдийн засгийн уян хатан чанар, бодлогын хариу үйлдэл хийх орчин зэрэг үзүүлэлтээр доогуур байх нь тодорхой байна.

Дээрх судалгаанаас харахад эдийн засгийн тэсвэрлэх чадвар гэдэг нь ерөөсөө эдийн засгийн үндэс суурийг, үүнд суурь бодлого мөн хамаарна гэдгийг анхаарна уу, бэхжүүлэхээс л шалтгаалж байна. Энэ нь өөрөө өнөөдөр хэрэгжүүлж буй бодлогыг даруй засахыг биднээс шаардаж байна. Хямрал энэ суурь гажуудлыг илрүүлж өгсөнөөрөө сайн талтай. Энэ “үүрэг”-ээ хямрал сайн “биелүүлсэн” гэж үзэж байна.

Одоо бодлогын өөрчлөлтийг хийх нь чухал юм. Энэ байдлыг даван туулах боломжийг хямрал мөн нээж өгч байна. Хямралт байдал аливаа бодлогын шинэчлэлийн хөшүүрэг болдгийг түүх бэлхнээ илчилж байна. Хямралт байдал ховор боломжийг улстөрчдөд олгодог. Эдийн засгийн хүндрэлээр “далимдуулан” бодлогын дорвитой өөрчлөлт хийхэд амар байдаг, учир нь иргэд нөхцөл байдлыг ойлгон хүлээцтэй хандаж, дэмжлэг үзүүлэх нь илүүтэй байдаг. Энэхүү хямрал илүү урт хугацаанд үргэлжилсэн бол энэхүү хоёрдох үүргээ илүү сайн биелүүлэх байсан болов уу гэж үзэж байна.

7. Ашигласан материал

Barro, Robert “Government Spending is no Free Lunch“, Wall Street Journal, January 22, 2009

Clausen, Jens R., “Calculating Sustainable Non-mineral Balances as Benchmarks for Fiscal Policy:

The Case of Botswana”, IMF Working Paper, WP/08/117, May 2008

Freedman, Charles, Michael Kumhof, Douglas Laxton and Jaewoo Lee, “The Case for Global Fiscal Stimulus”, IMF Staff Position Note, SPN/09/03, March 2009

Global Economic Prospect 2009: Commodities at Crossroads, Washington DC, World Bank.

Hanke, Steve H., “R.I.P. Zimbabwe Dollar”, the Cato Institute, 2009

Iizetzki, Ethan, Enrique G. Mendoza and Carlos A.Vegh, “How big are fiscal multipliers?”, CEPR Policy Insight No.39, October 2009

Johnson, Simon “Economic Recovery and The Coming Financial Crisis” presentation at AEA annual meeting, 2009

Kakutani, Michiko, “Skepticism for Obama’s Fiscal Policy” New York Times, January 18, 2010

“The Implications of the Global Financial Crisis for Low-Income Countries,” IMF, 2009.

“TARP Bailout Repayment: Citigroup Stronger on Own Feet”, www.ledger.com, December 29, 2009

Mongolia Monthly Economic Update, World Bank 2009 April-November

Mongolia: Request for Stand-By Arrangement—Staff Report; Staff Supplements; Press Release on the Executive Board Discussion; and Statement by the Executive Director for Mongolia, International Monetary Fund, April 2009

Mongolia: First Review Under the Stand-By Arrangement—Staff Report; Press

Release on the Executive Board Discussion; and Statement by the Executive Director for Mongolia, International Monetary Fund, August 2009

Mongolia: Blue-sky opportunity, country overview, Renaissance Capital 2009

Mongolia: Technical Memorandum on the Fiscal Stability Law, Technical Memorandum, IMF Fiscal Affairs Department, July 2009

“Obama’s Move to Limit ‘Reckless Risks’ Has Skeptics” by Sewell Chan and Eric Dash, New York Times, January 21, 2010

Second Review Under the Stand-By Arrangement and Request for Modification of Performance Criteria, IMF, September 2009

World economic outlook: Sustaining the Recovery, International Monetary Fund, 2009

Б.Лхагважав, “Мөнгөний амлалт зогсохгүй бол банкны зээлийн хүү буурахгүй”, нийтлэл, Монголбанк, 2010 оны 1 дүгээр сар

Монголын эдийн засгийн эрх чөлөөний тойм 2008: Эдийн засаг дах Засгийн Газрын оролцоо, Нээлттэй Нийгэм Форум, Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн Сургууль, 2009

Монгол Улс – Урт хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийн дараах үнэлгээ, Сангийн яам 2006

Монгол Улсын 2009 оны төсвийн тухай, Монгол Улсын хууль 2008

Монгол Улсын 2009-2011 оны төсвийн төсөл, Монгол Улсын Засгийн газар 2008

Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар 3 дахь удаагаа хэлэлцүүлсний дараах нэгдсэн төсвийн үр дүнгийн талаар, Сангийн яам 2009

Монголбанкны жилийн тайлан, 2004-2008, Монголбанк

Монголбанк бодлогын хүүгээ яагаад өсгөв, Монголбанкны мэдээлэл 2009

Л.Пүрэвдорж, “Зөвхөн Монголд л банк дампуураад байгаа юм биш шүү дээ”, ярилцлага, 2009 оны 12 дүгээр сарын 28

Санхүү, эдийн засгийн хямрал: Монгол Улс, 2009 оны 1, 2, 3 дугаар улирлын тайлан, Нээлттэй Нийгэм Форум 2009

Статистикийн 2007, 2008 оны эмхэтгэлүүд, Үндэсний статистикийн хороо

Статистикийн сарын мэдээлэл, Монголбанк 2008-2009

Статистикийн бюллетень, Үндэсний статистикийн хороо 2008-2009

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2009 онд баримтлах үндсэн чиглэл, Монгол Улсын Их Хурал 2008

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2010 онд баримтлах үндсэн чиглэл, Монгол Улсын Их Хурал 2009

Хэрэглэгчийн итгэлийн индекс, Нээлттэй Нийгэм Форумын захиалгаар Монгол Улсын их Сургуулийн Эдийн засгийн сургуулийн баг, 2009 оны 11 дүгээр сар

Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2010 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай, Улсын Их Хурлын тогтоол, 1 дүгээр сар 2010 он


“Хүний хөгжлийн сангаас Монгол Улсын иргэнд 2010 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай”, Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлал, 1 дүгээр сар 2010 он

Хүний хөгжил сангийн тухай, Монгол Улсын Хууль




8. Хавсралт

Хавсралт 1. 2009 он дахь экспортын хэмжээний өөрчлөлт, хувиар (өмнөх оны мөн үетэй харьцуулахад)




Эх сурвалж: УСХ, 2009 оны 12-р сарын бюллетень

Хавсралт 2. 2009 он дахь импортын хэмжээний өөрчлөлт, хувиар (өмнөх оны мөн үетэй харьцуулахад)



Эх сурвалж: УСХ, 2009 оны 12-р сарын бюллетень

Хавсралт 3. Ам. доллартай төгрөгийн нэрлэсэн ханш



Эх сурвалж: Монголбанкны 12 дугаар сарын мэдээ

Хавсралт 4. Гадаадаас шилжүүлсэн хувийн мөнгөн гуйвуулгын хэмжээ (мянган ам. доллар)

Сар	2008 он	2009 он
1	16,934.56	9,198.58
2	16,206.09	10,694.44
3	17,049.46	10,335.14
4	15,087.65	12,355.63
5	20,057.30	12,424.84
6	17,754.89	12,622.98
7	18,489.52	18,801.32
8	12,063.06	23,119.32
9	17,727.94	17,744.73
10	13,180.75	19,018.11
11	8,867.60	20,828.76
12	12,162.35	
Нийт	185,581.17	167,143.84

Эх сурвалж: Монголбанкны Валют эдийн засгийн газрын тооцоо